


# ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-II



Улаанбаатар хот  
2024 он



ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ  
ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН  
ТӨСӨӨЛЛИЙН СУДАЛГАА-II



Энэхүү судалгааг “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн судалгааны баг гүйцэтгэв.

Судалгааны тайланд тусгагдсан дүгнэлтүүд судалгааны багийн байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/ болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

#### СУДАЛГААНЫ БАГ

Багийн ахлагч:	С.ТҮМЭНДЭЛГЭР. (МУБИС-ийн багш, доктор, дэд проф)
Судлаачид:	Т.БҮРЭНЖАРГАЛ (МУИС-ийн багш, доктор, проф) Ц.ОДГЭРЭЛ (НБХСХ-ийн захирал, докторант) Т.ОЮУНБИЛЭГ (ШУТИС-ийн багш, доктор, дэд проф) Н.ҮҮРИЙНТУЯА (МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, докторант) Б.СОДБАЯР (УБТЗ-ын Статистик мэдээллийн албаны программист) Б.ХАНХҮСЛЭН (НБХСХ-ийн ахлах судлаач, улс төр судлаач) С.СОЛОНГО (НБХСХ-ийн ахлах судлаач)

# АГУУЛГА

---

■	Товчилсон үгсийн жагсаалт	4
■	Хүснэгт, зураг, матрицын жагсаалт	5
■	Судалгааны хураангуй	8
■	<b>НЭГ. УДИРТГАЛ</b>	<b>14</b>
	1.1 Судалгаа явуулах хэрэгцээ, шаардлага	14
	1.2 Судалгааны зорилго, зорилтууд	14
	1.3 Судалгааны арга зүй, аргачлал	15
	1.4 Судалгааны түүвэрлэлт	15
	1.5 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа	17
	1.6 Мэдээлэл боловсруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа	18
	1.7 Судалгаанд баримталсан ёс зүйн зарчмууд	18
■	<b>ХОЁР. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20</b>
	2.1 Асуулгын судалгаа	19
	2.2 Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага	20
	2.3 Фокус бүлгийн ярилцлага	21
■	<b>ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН</b>	<b>23</b>
	3.1 Жендэрийн хэвшмэл үзэл	22
	3.2 Улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжих байдал	29
	3.3 Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх үзэл бодол	42
	3.4 Квот (түр тусгай арга хэмжээ) тогтоох аргын талаарх мэдлэг, хандлага	56
	3.5. Улс төрийн манлайлагчаас хүлээх хүлээлт	64
■	Дүгнэлт	71
■	Зөвлөмж	77
■	Хавсралт	80

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АН	Ардчилсан нам
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МАН	Монгол ардын нам
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОУБ	Олон улсын байгууллага
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
ХШҮ	Хяналт шинжилгээ, үнэлгээ
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ТМЯ	Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УТН	Улс төрийн нам
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага

## ■ ХҮСНЭГТ, ЗУРАГ, МАТРИЦЫН ЖАГСААЛТ

### Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 2.2.1 ТМЯ-д оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл
- Хүснэгт 3.1.1 Хэний оролцоо давуу байх нь зүйтэй вэ?, хувиар
- Хүснэгт 3.1.2 Удирдах ажил, манлайлагчаар итгэл хүлээлгэх байдал, хувиар
- Хүснэгт 3.2.1 УИХ-ын сонгуулиар эрэгтэй болон эмэгтэй нэр дэвшигчдэд саналаа өгсөн үндэслэл, хувиар
- Хүснэгт 3.3.1 УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн шалтгааны талаарх үзэл бодол
- Хүснэгт 3.4.1 Квотын арга хэрэглэхийг мэддэг байдал, байршил болон хүйсээр
- Хүснэгт 3.4.2 Квотын арга хэрэглэхийг дэмжих байдал, байршил болон хүйсээр
- Хүснэгт 3.4.3 Нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар зохицуулсан зохицуулалтын талаарх олон нийтийн үзэл бодол, хувиар
- Хүснэгт 3.5.1 Манлайллын чанаруудыг эрэгтэй, эмэгтэй хүнд хамааруулах хандлага, хувиар
- Хүснэгт 3.5.2 Эрэгтэй, эмэгтэй улс төрчдөд илэрч байх зохимжтой чанарууд, хувиар

### Зургийн жагсаалт

- Зураг 1.4.1 Түүврийн төлөвлөлтийн бүдүүвч
- Зураг 1.4.2 Түүврийн төлөвлөлт, мэдээлэл цуглуулах аргуудаар
- Зураг 2.1.1 Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, хувиар болон хүйсээр.
- Зураг 2.2.1 Иргэдийн төлөөллийн байгууллагын сонгуулийн үр дүн, хувиар, хүйсээр
- Зураг 3.1.1 Эхнэр, нөхөр хоёулаа ажил мэргэжлийн чадамж, цалин ижил бол хэн нь бага насны хүүхдээ асрах нь дээр вэ?, хүйсээр болон хувиар
- Зураг 3.1.2 Эхнэр, нөхөр хоёулаа ажил мэргэжлийн чадамж, цалин ижил бол хэн нь улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь дээр вэ?, хүйсээр болон хувиар
- Зураг 3.1.3 Салбаруудын удирдлага болон нэр бүхий өндөр албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүнийг илүүд үзэх сонголт, хувиар
- Зураг 3.2.1 Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог дэмжих хандлага, нэгтгэснээр, хүйсээр
- Зураг 3.2.2 Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт итгэх байдал, хүйсээр

- Зураг 3.2.3 Сонгуульд санал өгсөн байдал, хүйсээр (2020 оны УИХ-ын сонгуульд оролцоогүйг хасаж тооцсоноор)
- Зураг 3.2.4 Адил шинж бүхий нэр дэвшигчээс сонгох хандлага, хүйсээр
- Зураг 3.2.5 Хөрөнгө багатай эрэгтэй болон баян эмэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар
- Зураг 3.2.6 Хөрөнгө багатай эмэгтэй болон баян эрэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар
- Зураг 3.2.7 Шинэ, залуу эмэгтэй улс төрч болон ахмад настай туршлагатай эрэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар
- Зураг 3.2.8 Шинэ, залуу эрэгтэй улс төрч болон ахмад настай туршлагатай эмэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар
- Зураг 3.2.9 Олон нийтийн зүгээс улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдэж чадсан эсэх, хувиар, 2024
- Зураг 3.2.10 Эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих хандлага, хүйсээр
- Зураг 3.2.11 Эмэгтэйчүүдийн улс төрийн карьерт олон нийтийн ойлголтоос хамаарах сөрөг хүчин зүйлс, хувиар, 2024
- Зураг 3.3.1 УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх сэтгэгдэл, хүйсээр
- Зураг 3.3.2 Эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар авсан мэдээллийн хэв шинж, хувиар, 2024
- Зураг 3.4.1 Квотын арга хэрэглэдгийг мэдэх үү? хүйсээр болон хувиар
- Зураг 3.4.2 Квотын аргыг дэмждэг үү?, хувиар болон хүйсээр
- Зураг 3.4.3 Олон нийтээс санал болгосон квотын хэмжээ, хувиар
- Зураг 3.4.4. Олон нийтээс санал болгосон квотын дундаж түвшин, хүйсээр болон хувиар
- Зураг 3.5.1. Улс төрийн манлайлагчаас хүлээх чанарууд, хүйсээр

#### Матрицын жагсаалт

- Матриц 3.2.1 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдэд итгэл үзүүлэх шинж, 2021, 2024
- Матриц 3.2.2 Олон нийтийн зүгээс шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүй шалтгаан
- Матриц 3.2.3 Эмэгтэй улс төрчдөд тулгардаг хүндрэл бэрхшээл
- Матриц 3.2.4 Эмэгтэй улс төрчдөд буй давуу тал, боломж болон эрсдэл, 2021, 2024
- Матриц 3.3.1 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эрэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар
- Матриц 3.3.2 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эмэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар
- Матриц 3.3.3 Сонгуульд ялахад хүргэсэн хүчин зүйлс, эмэгтэй оролцогчдын өгсөн хариултаар
- Матриц 3.3.4 Сонгуульд ялагдахад хүргэсэн хүчин зүйлс, эмэгтэй оролцогчдын өгсөн хариултаар, 2024





Матриц 3.3.5 Эмэгтэй улс төрчийн сул тал

Матриц 3.3.6 Эмэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл хүлээн авсан байдал, хариу үйлдэл, үнэлгээ

Матриц 3.4.1 Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх зохицуулалтын талаарх иргэдийн мэдээлэлтэй байдал (n=169)

Матриц 3.5.1 Эмэгтэй улс төрчийг манлайлагчаар үзэж буй үндэслэл

Матриц 3.5.2 Эрэгтэй улс төрчийг манлайлагчаар үзэж буй үндэслэл

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

2024 оны “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөллийн судалгаа”-гаар жендэрийн хэвшмэл үзэл, улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжих байдал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөлөгч хүчин зүйлс, квот (түр тусгай арга хэмжээ) тогтоох аргын олон нийтийн мэдлэг, хандлага, улс төрийн манлайлагчаас хүлээх хүлээлтийг хандлага, төсөөллийг тодорхойлсон. Энэхүү судалгааны үр дүнг 2021 оны судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэхэд дараах өөрчлөлтүүд гарч байна. Үүнд:

### Жендэрийн хэвшмэл үзэл

- **Нийгэм-улс төрийн үйл ажиллагаанд эмэгтэй хүний оролцоог нэмэгдүүлэх талаарх төсөөлөл нэмэгдэж байна.** Хэдийгээр гурван жилийн хугацаанд эрс өөрчлөлтийг хүлээх боломжгүй ч өрх дэх эрх мэдлийн хуваарь, нийгэм-улс төрийн үйл ажиллагаа дахь эрэгтэй, эмэгтэй хүний оролцооны талаарх төсөөлөл бага зэрэг өөрчлөгджээ. Тодруулбал, “Орон нутаг, ИНБ, холбоо, улс төрийн намын гишүүнчлэлийн хурал зөвлөгөөнд оролцох” ажилд эмэгтэй хүн оролцох нь зүйтэй гэсэн хариулт 2021 онд 14.4 хувь байсан нь 2024 онд 18.2 хувь (3.8 хувиар илүү) болж нэмэгдсэн дүн гарав. Харин өрх гэр бүлд эрэгтэйг илүү эрх мэдэлтэй гэж үзэх хариулт тулгамдсан асуудлыг шийдэх, хөрөнгө нөөцийг захиран зарцуулах шийдвэрийг гаргахад, харин гэр бүлийн гишүүдийн зан үйлийг хянах үйлд эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь эрх мэдэлтэй гэж үзсэн хариулт тус бүр 4.6 хувиар өссөн бөгөөд зан үйлийг хянах эрх мэдлийн хувьд эрэгтэйд гэхээсээ эмэгтэйд оноох нь илүү илэрлээ.
- **Улс төрийн оролцооны талаарх хэвшмэл үзэл буурч байна.** Эрэгтэй, эмэгтэй хүний улс төрийн оролцооны талаарх хэвшмэл үзэл судалгаанд оролцогчдын гуравны нэгд нь илэрлээ. Улс төрийн оролцоог эрэгтэй хүнд хамааруулах хандлагыг 2021 оны дүнтэй харьцуулахад эрэгтэй оролцогчдын хувьд 6.7 хувь, эмэгтэй оролцогчдын хувьд 6.9 хувиар бага түвшинд илэрсэн нь улс төрийн оролцоон дахь жендэрийн хэвшмэл үзэл буурах төлөвтэйг илтгэж байна. 2021 болон 2024 оны судалгааны дүнд хүйсийн ялгаа ажиглагдсангүй.
- **Удирдах ажил, манлайлагчийн талаарх жендэрийн хэвшмэл үзэл хандлага буурч байна.** Удирдах ажил, манлайллыг жендэрийн хэвшмэл үзлээр тодорхойлох хандлага харьцангуй бага илэрч байгаа ч эмэгтэй хүн удирдах ажил эрхэлж чадна гэдэгт үл итгэх хандлага 2021 онд 16.7 хувь байснаа 2024 онд 14.2 хувь, манлайлагч гэдэгт итгэхгүй байх хандлага 2021 онд 18.3 хувь, 2024 онд 10.4 хувь болж тус тус буурсан байна.
- **Салбар болон албан тушаалыг жендэрчлэн ялгаж үзэх хэвшмэл үзэл байсаар байна.** Чанарын судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь боловсрол, эрүүл мэндээс бусад салбарыг эрэгтэй хүн илүү сайн удирдаж чадна гэж үзсэн. Тухайлбал, цэрэг армийн удирдлага, Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүнээр эрэгтэй хүн ажиллах нь зүйтэй гэж 70-аас дээш хувь, орон нутгийн удирдлага, хууль тогтоох байгууллагын гишүүн\төлөөлөгч, шүүхийн байгууллагын удирдлага, гадаад харилцааны салбарын удирдлагад эрэгтэй хүн байвал зохино гэж судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь үзэж байна.

- **Эрэгтэйчүүдэд эмэгтэй хүнийг дорд үзэх, үл итгэх хандлага байсаар байна.** Чанарын судалгааны баримтад эрэгтэйчүүдийн дунд жендэрийн хэвшмэл үзэл, үүнээс улбаалсан эмэгтэйчүүдийг дорд үзсэн, үл итгэх хандлага илэрч байна.
- **Гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох хэвшмэл үзэл байсаар байна.** Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 50-иас дээш хувь нь жендэрийн дүр үүргийн хуваарийг хэвшмэл үзэлгүйгээр төсөөлж байна. Гэхдээ гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох хэвшмэл үзэл судалгаанд оролцогчдын 40 гаруй хувьд амь бөхтэй байсаар байна.

#### Улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжих байдал

- **Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэсэн итгэл өссөн.** Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт 2021 онд судлагдсан оролцогчдын дийлэнх олонх буюу 80 гаруй хувь нь итгэлтэй байсан бол 2024 онд энэхүү итгэлийн хэмжээ эрэгтэйчүүд (2021 онд 80.9 хувь байсан бол 2024 онд 87.4 хувь) болон эмэгтэйчүүдийн (2021 онд 87.9 хувь байсан бол 2024 онд 91.7 хувь) хариулт 5.2 хувиар өссөн байна.
- **Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих хандлага өссөн.** 2021 онд эмэгтэйчүүдийн эмэгтэй хүнийг дэмжих хандлага 18.5 хувь байсан бол, 2024 онд 30.9 хувь болж 12 хувиар өссөн. Улс төр дэх эмэгтэйчүүдийн хувийн жин нэмэгдэхгүй байгааг “эмэгтэйчүүд нэгнээ дэмждэггүй” гэж тайлбарлагчийг энэ баримт үгүйсгэж байна.
- **Шийдвэр гаргах түвшин дэх эрэгтэй хүний оролцоог эрэгтэйчүүд дэмжих хандлага 20 гаруй хувиар буурсан.** 2021 оны судалгаанд оролцсон эрэгтэйчүүд эрэгтэй хүнийг шийдвэр гаргах түвшинд дэмжих хандлага 58.9 хувь байсан бол 2024 онд 37.6 хувь болж эрэгтэй хүн эрэгтэйгээ дэмжих хандлага 20 гаруй хувиар буурсан байна.
- **Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дэмжих хандлага өсөж байна.** Энэ судалгаагаар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дэмжих хандлага 10 гаруй хувиар (2021 онд 28.7 хувиас 2024 онд 40.5 хувь) илүү бол эрэгтэйчүүд эрэгтэйчүүдээ дэмжих хувийн жин 10 гаруй хувиар (2021 онд 71.3 хувиас 59.5 хувь) буурсан. Мөн эрэгтэйчүүдийн “хүйс хамаагүй” гэж үзсэн хариулт 2021 онд 29.7% байсан бол 2024 онд 44.6% болж өссөн.
- **Сонгогчид шийдвэр гаргах түвшинд шинэ, залуу хүнийг дэмжих хандлага нэмэгдэж байна.** 2021 болон 2024 оны судалгаагаар шинэ, залуу эмэгтэй улс төрчийг дэмжсэн хувь судалгаанд оролцогчдын 42.6 хувиас 58.7 хувь болж 16 хувиар нэмэгджээ. Харин ахмад туршлагатай эрэгтэй улс төрчийг дэмжих хувь эсрэгээрээ 57.4 хувиас 41.3 хувь болж 16 хувиар буурснаас харахад иргэд шинэ, залуу эмэгтэй улс төрчийг сонгохыг хүсэж байна.
- **Эмэгтэй улс төрчийг дэмжих хандлага 10 гаруй хувиар өссөн.** 2021 онд ТМЯ-д оролцсон улс төрч эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 60 орчим хувь, 2024 оны судалгаанд оролцогчдын 72.3 хувь нь олон нийтийн зүгээс эмэгтэй улс төрчийг дэмжих хандлагатай гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгээс 10 гаруй хувиар өссөн байна. Үүнийг хүйсээр авч үзвэл 2021 онд эмэгтэй оролцогчдын 52 хувь, 2024 онд 64.7 хувь болж, 2021 онд эрэгтэй оролцогчдын 69 хувь, 2024 онд 80 хувь нь тус тус эмэгтэй улс төрчийг дэмжих хандлагатай байна.

## Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх үзэл бодол

- **Иргэд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй гэж үзэж байна.** Улс төр, УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг 2024 оны судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь хангалтгүй гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь боломжийн, хангалттай гэж үзсэн. Энэ нь төлөөллийн бодит байдлыг дүгнэх үнэлгээ хүйсээс хамаарч ( $\chi^2 = 22.329$ ,  $p < .000$ ) байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг эрэгтэй, эмэгтэй оролцогчдын аль алиных нь хувьд хангалтгүй гэж үзсэн хариулт тус бүр 8 хувиар өссөн. Энэ нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх хэвшмэл үзэл буурч байна гэх үндэслэл болж байна.
- **Парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн байгаагийн шалтгааныг нийгмийн бүтцийн хүчин зүйлс, соёл, болон сонгогчдын ойлголт, мэдлэг хангалтгүй байгаатай холбон тайлбарлаж байна.** 2024 оны судалгаагаар парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн шалтгааныг давхардсан тоогоор 133.4 хувь (2021 оны судалгаагаар 136.2 хувь) нь эрэгтэйчүүд давамгайлсан бүтэц, соёлын хүчин зүйлийг гол шалтгаан гэжээ. Тодруулбал, парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн байгааг судалгаанд оролцогчдын 75.2 хувь нь улс төрийн нам дахь эцгийн эрхт бүтэц, тавны нэг нь (2021 оны судалгаагаар 1\3) эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргийн ачаалалтай холбон тайлбарласан байна. Мөн 2024 оны судалгаагаар 48.6 хувь (2021 оны судалгаагаар 118.3 хувь) нь эрэгтэй улс төрчдийг дөвийлгөсөн соёлын хандлагаар хариулсан ба ийм хариулт өгөгчдийн тоо 2.4 дахин буурчээ. Харин судалгаанд оролцогчдын 75.9 хувь нь сонгогчийн хүчин зүйлстэй холбоотой гэж үзсэн байна.
- **Улс төрч эмэгтэйчүүд намын бюрократ бүтэц, мөнгө, ашиг, дэм түшсэн “хөлсний” шинжтэй гишүүд, дэмжигчид бэрхшээл болж байна гэж дүгнэсэн.** УТН-ын дээрээс доош чиглэсэн бүтцийн илрэл болох “даргад таалагдах, даргад анзаарагдах” эсэх нь даргатай өдөр тутам харилцах боломжтой эсэх (жишээ нь, цүнх барих), өөрийн үйлдлээ товойлгон харуулах эдийн засгийн боломж, чадавх буй эсэхээс хамааралтай төлөв байдал бодитоор оршин буй тул энэ нь эмэгтэй улс төрчийг “үл үзэгдэгч” болгох, улс төрөөс түлхэх хүчин зүйл болж байна. Иймд улс төрийн намууд гишүүдийн идэвх оролцоо, хичээл зүтгэлийг шударгаар үнэлэх, айдас болгоомжлолгүйгээр таниулах суваг, боломжийг нээлттэй болгох нь эмэгтэй улс төрчөө дэмжих нэгэн хэрэгсэл болох юм.

## Квот (түр тусгай арга хэмжээ) тогтоох аргын талаарх мэдлэг, хандлага


- **Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор квот тогтоох арга хэрэгжүүлдэг талаарх мэдлэг нэмэгдсэн байна.** 2021 онд судалгаанд оролцогчдын 34 хувь нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд квот тогтоох арга хэрэглэдгийг мэдэж байсан бол 2024 онд 37.2 хувь болж 3.2 хувиар өсжээ. 2021, 2024 оны судалгааны дүнгээр, эрэгтэйчүүд квотын тогтоох аргыг илүү мэдэж байна. Мөн нэр дэвшигчийн хүйсийн квот тогтоох арга хэрэглэдгийг мэдэх хувь 2021 онтой харьцуулахад 2024 онд 3.8 хувиар өссөн байна. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүйсийн квот тогтоох аргыг мэдэхгүй байгаа оролцогчдод 18-24 насныхан, хөдөөгийн болон баруун аймгийн угсаатны бүлгийн хүн ам зонхилж байна.

- **Квот хэрэглэхийг дэмждэг иргэд өссөн байна.** 2021 онд квот тогтоох аргыг мэддэг иргэдийн 74.9 хувь нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд хүйсийн квот тогтоохыг дэмжиж байсан бол 2024 онд 80.7 хувьд хүрч өсжээ. Хүйсээр шинжилбэл, 2021 онд квот тогтоох аргыг мэддэг эмэгтэйчүүдийн 79.3 хувь, эрэгтэйчүүдийн 70.7 хувь нь квотыг дэмждэг байсан бол 2024 онд эмэгтэйчүүдийн 87 хувь, эрэгтэйчүүдийн 74 хувь болж нэмэгдсэн үр дүнтэй гарчээ.
- **Иргэд квотын хэмжээг нэмэгдүүлэх нь зөв гэж үзэж буй хандлага нэмэгдэж байна.** 2021 онд квотыг дэмждэг оролцогчдын санал болгосон квотын хэмжээг дундажлан тооцоход 36.67 хувийг санал болгож байсан бол 2024 онд 42.27 хувьд хүрч нэмэгдсэн байна. Квотын дундаж хувийг хүйсээр шинжилбэл, 2021 онд эмэгтэйчүүд дунджаар 39.14 хувь, эрэгтэйчүүд 34.09 хувиар квот тогтоохыг санал болгосон бол 2024 онд эмэгтэйчүүд 43.78, эрэгтэйчүүд 40.34 хувьд хүргэхээр зорьжээ. 2021, 2024 оны судалгааны үр дүнг харьцуулахад олон нийтийн дунд квот тогтоохыг дэмжих хандлага өсөж, 40:60 гэсэн харьцааг санал болгосон үр дүн ажиглагдаж байна.
- **Чанарын судалгаанд оролцогчид квотыг 50:50 хувь байх ёстой гэсэн байр суурьтай байна.** Фокус бүлгийн ярилцлагын дүнгээр, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүдийн давамгайллыг 50:50 хувийн квотоор тэнцвэржүүлэх, улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн тул квотоор дэмжих, 21-р зуунд эмэгтэйчүүд идэвхтэй улс төр хийж, шийдвэр гаргах түвшинд олноороо гарч ирэхийг дэмжих хандлагатай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн фокус бүлгийн ярилцлагаар, хүйсийн квотыг 50:50 байх ёстой гэсэн байр суурь өндөр давтамжтай илрэв. Харин баруун аймгийн эрэгтэйчүүд оролцсон фокус бүлгийн ярилцлагын үеэр 70:30 хувьтай байхад болно гэсэн санаа дурдагдав.
- **Иргэдэд квотын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээллээр хангах хэрэгцээ байна.** Иргэдийн квотыг дэмжихгүй байх үндэслэл нь анхнаасаа тэгш байх ёстой, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь өрсөлдөөд гараад ирэхэд болохгүй зүйлгүй, квотын талаар ойлголт, мэдээлэлгүй гэж тайлбарлалаа. Баруун болон хангайн бүсийн алслагдсан аймгуудын малчин эмэгтэй, эрэгтэйчүүд, угсаатны бүлгийн эмэгтэйчүүдийн фокус бүлгийн ярилцлагаар, квотын талаар анх удаагаа сонсож байгаа учраас үзэл бодлоо илэрхийлэхэд хязгаарлагдмал болохыг онцлон тэмдэглэсэн.

#### Улс төрийн манлайлагчаас хүлээх хүлээлт

- **Манлайлалд хүйс хамаагүй гэх хандлага өсөж байна.** 2021 оны судалгааны дүнгээр байгууллага, хамт олныг удирдах (эрэгтэй 37.2 хувь, эмэгтэй 24.1 хувь), бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах (эрэгтэй 33.3 хувь, эмэгтэй 29.4 хувь), шинийг санаачилж, өөрчлөлтийг авчрах (эрэгтэй 29.7 хувь, эмэгтэй 25.6 хувь), сэтгэн бодох чадварын хувьд (эрэгтэй 33.1 хувь, эмэгтэй 17.9 хувь) эрэгтэй нь илүү гэж дүгнэсэн. Харин 2024 оны судалгаагаар эрэгтэйд давуутай хамаатуулсан байгууллага, хамт олныг удирдах (эрэгтэй 26.7 хувь, эмэгтэй 30.3 хувь), бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах (эрэгтэй 29.4 хувь, эмэгтэй 36.6 хувь) чанарыг эсрэгээрээ эмэгтэйчүүдэд давуутай хамаатуулсан онцлох үр дүн үзүүлж байна. Мөн 2021 онд манлайллын шинж чанаруудыг аль ч хүйсэд адил илрэх хувилбар зонхилсон бол 2024 онд дундын хувилбарын эзлэх хувь буурч, манлайллын 7 шинж чанарыг эмэгтэй хүйсэд хамаатуулсан хувийн жин өсжээ.

- **Манлайллын талаарх жендэрийн хэвшмэл үзэл байсаар байна.** 2021 оны судалгаагаар хариуцлагатай, бусдыг ойлгож, уян хатан байх гэсэн хоёр чанараас бусад чанаруудад эрэгтэй оролцогчид “эрэгтэй нь илүү” гэж хариулсан нь өндөр жин дарж байсан. Эмэгтэй оролцогчид “эмэгтэй нь илүү” гэсэн хариултыг түлхүү өгч, хүйсээс ач холбогдлын түвшинд хамаарсан үр дүн үзүүлсэн. Харин 2024 оны судалгаагаар хариуцлагатай хандах, бусдыг ойлгож уян хатан байх чанараар эмэгтэй нь илүүг хүйсийн ялгаагүйгээр хүлээн зөвшөөрсөн бол сэтгэн бодох чадварыг эрэгтэйд илүү гэдгийг эрэгтэй, эмэгтэй оролцогчдын аль аль нь зөвшөөрчээ. Мөн байгууллага удирдах, итгэл үнэмшил, үнэт зүйлс, мэдлэг, ур чадвараараа бусдыг дагуулах, бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах, бусдад хийж бүтээх эрмэлзлийг төрүүлж, боломж олгох, шинийг санаачилж, өөрчлөлтийг авчрах чанаруудыг эмэгтэй оролцогчдын зүгээс эмэгтэйд илүү, харин эрэгтэй оролцогчдын зүгээс эрэгтэйд илүү гэсэн эсрэгцсэн байр суурийг илэрхийлж байна.
- **Иргэд улс төрч хүн шийдэмгий, тэмцэгч, бусдыг ойлгодог байхыг хүсэж байна.** 2021 оны судалгаагаар иргэд улс төрийн манлайлагчаас шийдэмгий (83.4 хувь) чанарыг хүссэн нь хамгийн өндөр давтамжтай илэрснийг 2024 оны судалгааны дүн дахин давтаж 78 хувийг эзэлжээ. 2021 онд шийдэмгий чанарын дараагаар 66.8 хувь нь зоригтой, 59.3 хувь нь бусдыг ойлгодог байх ёстой гэсэн бол 2024 оны судалгаагаар шийдэмгий чанарын дараагаар тэмцэгч (59.5 хувь), бусдыг ойлгодог (59.1 хувь), зоригтой (56.5 хувь) байхыг чухалчилсан үр дүн гарсан. Эндээс дүгнэхэд, олон нийт жендэрийн хэвшмэл үзлээр ихэвчлэн эрэгтэй улс төрчид илүүтэй хамаарах шийдэмгий, тэмцэгч, зоригтой чанарыг улс төрийн манлайлагчаас түлхүү хүлээдэг буюу улс төрчийг эрэгтэй дүрээр харсаар байна.
- **Улс төрч хүнд байх ёстой чанаруудад хүйсийн ялгаа байхгүй байна.** 2021 оны судалгаагаар эрэгтэй, эмэгтэй оролцогчид 83.1-83.7 хувь шийдэмгий, 66.2-67.3 хувь зоригтой, 58.8-60 хувь бусдыг ойлгодог чанарыг, 2024 онд 77.5-80.5 хувь шийдэмгий, 58.4-60.4 хувь тэмцэгч, 57.8-60.1 хувь бусдыг ойлгодог чанаруудыг улс төрч хүнд илүү байх ёстой чанаруудаар нэрлэсэнд хүйсийн ялгаа ажиглагдсангүй. Харин 2024 оны судалгаанд эрэгтэй улс төрчөөс шийдэмгий, зоригтой байхаас гадна бусдыг ойлгодог чанарыг хүлээж буйгаа илэрхийлсэн. Эмэгтэй улс төрчөөс мөн шийдэмгий, бусдыг ойлгодог, тэмцэгч чанарыг хүлээж байна. 2021, 2024 оны судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэхэд, олон нийт жендэрийн хэвшмэл үзлийн үүднээс эрэгтэй улс төрчдөд хамаатуулдаг шийдэмгий, тэмцэгч, зоригтой байх чанаруудыг хүлээхийн зэрэгцээ бусдыг ойлгодог байх чанарыг эмэгтэй улс төрчөөс хүсэн хүлээж байна. 2024 оны судалгаагаар эрэгтэй, эмэгтэй улс төрчөөс аль алианаас нь “бусдыг ойлгодог чанар”-ыг хамгийн чухал гурван чанарт багтааж байгаа нь нэгд, улс төрчийн хэвшмэл дүр өөрчлөгдөж байгааг, хоёрт, нийгмийн бүлгүүдийн олон талт байдлыг ойлгох чадамжтай улс төрч хэрэгцээтэй болж буйг харуулж байна.
- **Олон нийтийн зүгээс эмэгтэй улс төрчдөд илүү өндөр шаардлага тавьж байна.** 2021 оны чанарын судалгаагаар зоригтой, шулуун шударга, үгээ хэлдэг, ширүүн дүр төрхтэй эрэгтэй, эмэгтэйчүүдийг манлайлагч дүгнэж байсан бол 2024 онд эмэгтэй улс төрчөөс өндөр боловсрол, бусдыг ойлгодог, нийгмийн олон талт асуудлыг шийдэхийн төлөө зүтгэдэг, хүний төлөө, хүмүүнлэг зэрэг чанаруудыг хүлээж байна. Эндээс дүгнэхэд



эмэгтэй улс төрчөөс шийдэмгий, тэмцэгч зэрэг эрэгтэй улс төрчид илүү хамаатуулдаг чанаруудыг хүлээхийн зэрэгцээ эмэгтэй улс төрчид түлхүү хамаатуулдаг бусдыг ойлгодог, нийгэм, хүний төлөө хүнлэг чанаруудыг давхар хүлээж байгаа нь олон нийтээс илүү өндөр шаардлага тавьдаг болохыг илтгэж байгаа юм.

- **Олон нийтийн дунд эмэгтэй улс төрчөөс “шударга ёс тогтоох, өөрчлөлт авчрах байх” гэсэн хүлээлт байна.** Чанарын судалгааны дүнгээр эмэгтэй улс төрчдөөс нийгэмд шударга ёс тогтоох, авлигыг бууруулах үйл хэрэгт манлайлал үзүүлэн, итгэл хүлээлгэх хандлага илэрлээ. Жишээ нь, эрэгтэйчүүд л засаг удирдаж ирсэн тул эмэгтэйчүүдэд өгөөд үзье, авлига, том хэргээс хол байдаг тул өөрчлөлт авчирч магад хэмээн эмэгтэй улс төрчдөд итгэл үзүүлж буйгаа илэрхийлсэн. Мөн зарим эрэгтэй улс төрчид шийдвэртээ эзэн болж хатуу зогсох, бусдын ятгалаг, хов жив, уруу таталтад автахгүй байх, албан ажилд хувийн харилцаагаа хутгахгүй байх, эмэгтэйчүүд нэгнийхээ манлайллыг хүлээн зөвшөөрч нэгдэж, хүрээлэх хэрэгтэй гэсэн. Тухайлбал, УИХ-д эмэгтэй гишүүд олноороо сонгогдвол улс оронд нүүрлэсэн авлига, хээл хахууль буурна, бусдын халаасанд орохгүй, ашиг сонирхолд хөтлөгдөж хуйвалдаанд оролцохгүй, нийгмийг өөрчлөхөд хувь нэмэр оруулна гэсэн хүлээлт иргэдийн дунд байна.
- **Эрэгтэй, эмэгтэй аль аль нь шийдвэр гаргах түвшинд ажиллах ёстой гэх хандлагатай байна.** Чанарын судалгаагаар, манлайлагч хүн бол боловсрол, мэдлэг, ухаанаар тэргүүлэгч гэсэн үзэл баримтлал нийтлэг илэрч, улс төрд эрэгтэйчүүд дангаараа засагласнаар улс орон хөгжихгүй, эрх тэгш байдлыг хангах үүднээс эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг шаардаж байна. Мөн хэн ч манлайлах боломжтой, манлайлалд мэдлэг боловсрол, хувийн харизм чухал болохыг онцлон тэмдэглэсэн. 2021 оны судалгаагаар эмэгтэй манлайлагчдаас улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан, нэр дэвшсэн, нийтийн төлөө тодорхой (имиж бүрдүүлсэн) үйл хэрэгт манлайлан оролцдог, ажил хэрэгч-эмэгтэйлэг дүр төрх бүхий, амьдрал сайн мэддэг, нээлттэй ил тод эмэгтэй улс төрчийг олон нийт хүсэн хүлээсэн үр дүн үзүүлсэн. 2024 оны судалгаагаар 2021 оны судалгааны үр дүнг давтсанаас гадна шударга, одоогийн Монголын нийгмийн асуудлуудыг шийдэхэд, өөрчлөлт хийх эмэгтэй улс төрчийг илүүд үзэж байна.

# НЭГ

## УДИРТГАЛ

### 1.1 Судалгаа явуулах хэрэгцээ, шаардлага

НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, ЖҮХ 2010, 2021 онуудад Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо, төлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг тодорхойлох давтамжит судалгааг Нийгмийн Бодлого, Хөгжлийн судалгааны хүрээлэн (НБХСХ)-ээр гүйцэтгүүлж байсан. Уг судалгааны үр дүнг ашиглан 2011 онд УИХ сонгуулийн хуулийг шинэчлэн найруулж, сонгуулийн холимог тогтолцоо, хүйсийн квотыг 20-оос доошгүй хувь байхаар баталсан.

НҮБХХ БНСУ-ын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/ дэмжлэгтэйгээр “Монгол улсад шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг оролцоог дэмжих нь” төслийг 2021 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, эмэгтэй улс төрчдөд тулгардаг бүтцийн болоод бусад сорилтыг бууруулах, сонгогчид, хэвлэл мэдээллийн салбарын улс төрийн намуудын жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, дэмжих механизмыг бүрдүүлэхээр зорьж байна.

НБХСХ дээрх төслийн хүрээнд 2021 онд “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгааг гүйцэтгэсэн. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулах замаар шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн ойлголт, төсөөлөл хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлох зорилгоор 2024 онд “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгаа II-ыг гүйцэтгэв.

### 1.2 Судалгааны зорилго, зорилтууд

**Зорилго:** Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн талаарх олон нийтийн ойлголт, төсөөллийг тодорхойлох, цаашид холбогдох талуудад санал, зөвлөмжийг боловсруулах.

**Зорилт:**

- a. Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцооны талаарх олон нийтийн ойлголт төсөөлөл, хандлага, жендэрийн хэвшмэл үзэл, жендэрийн хэм хэмжээг тодорхойлох;
- b. Судалгааны үр дүнг 2021 оны “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгаатай харьцуулан шинжлэх;
- c. Үндэсний болон салбар, орон нутгийн түвшний оролцогч талуудад судалгааны үр дүн, бодлогын зөвлөмжийг боловсруулах.



### 1.3 Судалгааны арга зүй, аргачлал

2021 оны “Шийдвэр гарах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгаа болон бусад холбогдох ижил зорилго бүхий судалгаануудад дүн шинжилгээ хийж, холбогдох талуудын хамтын ажиллагааны үр дүнд үндэслэн судалгааны арга зүй, аргачлалын хэсэгт зохих өөрчлөлт оруулж судалгааг гүйцэтгэв.

Олон нийтийн төсөөллийн судалгаанд асуулгын аргыг ашигласны зэрэгцээ жендэрийн соёл, хэмжээ, манлайлагчийн жендэрчлэгдсэн дүр-үүргийг нарийвчлан тодруулах зорилгоор чанарын судалгааны аргуудыг өргөн хэмжээнд ашиглав. Мэдээлэл цуглуулах дараах аргыг ашиглалаа. Үүнд:

- А. Асуулга. Асуулгын аргаар олон нийтийг хамруулан эрэгтэй, эмэгтэй улс төрчийн дүр, хүлээлт, оролцоонд хандах хандлага болон жендэрийн хэвшмэл үзэл, жендэрийн хэм хэмжээг тодруулав.
- В. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага (ТМЯ). Манлайлал дахь жендэрчлэгдсэн дүр, олон нийтийн хүлээлт, хандлага, улс төрчдөөс хэрэгжүүлж байсан хариу арга хэмжээ, бэрхшээл, даван туулсан туршлагыг тодруулав. Залуу, дунд, ахмад насны эрэгтэй, эмэгтэй улс төрчдийг ТМЯ-д хамрууллаа.
- Г. Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ). Нас, хүйс, нийгмийн байдал, байршил, үндэс угсаа, шашин шүтлэгээр ялгаатай бүлгүүдтэй манлайлагч, улс төрч эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаарх дүр, хүлээлт, жендэрийн хэвшмэл үзэл, хэм хэмжээг тодруулан судлав.

### 1.4 Судалгааны түүвэрлэлт

Түүвэрлэлтийг тоон ба чанарын судалгааны хувьд ялгаатайгаар төлөвлөж хэрэгжүүлэв. Асуулгын аргаар мэдээлэл цуглуулах нэгж хувь хүн байх ба түүвэрлэлтэд шаталсан, энгийн санамсаргүй, буцаалтгүй түүврийн аргачлалыг баримтлав.

Асуулгаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжиж буй олон нийтийн хувийн жин ямар байгааг тодруулах зорилготой тул түүврийн үндсэн параметр нь “хувийн жин” байна. Иймд түүврийн алдааг 5 хувь, статистик ач холбогдлын түвшнийг 95 хувь байхаар, дараах томъёог ашиглан түүврийн зохистой хэмжээг тооцоолов.

$$n = \{(z^{2*} p * q) + ME^2\} / \{ME^2 + z^{2*} p * q / N\} -$$

СЕХ-ны 2021 оны мэдээллээр 2,000,624 сонгогч байгаагаас дээрх аргачлалын дагуу тооцоход нийт 836 сонгогчийг хамруулахад хангалттай ч түүврийн хазайлт, түүврийн бус алдааг харгалзах нөгөө талаас захиалагч талын төлөвлөлтөд үндэслэн 164-өөр нэмэгдүүлж, нийт 1200 хүн амаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулахаар эцэслэн тогтсон болно.


#### **Зорилтот орон нутаг, хувь хүнийг сонгосон түүврийн стратеги**

Асуулгын судалгаа нь зорилтот түүврийн шинжтэй ч нэгжийг сонгох үйл явц мужилсан, энгийн санамсаргүй, буцаалтгүй түүврийн стратегийн дагуу явагдсан бөгөөд Улаанбаатар ба аймгууд гэсэн хоёр мужид хуваасан. Аймгуудыг баруун, төв, хангай, зүүн 4 бүсэд хувааж нэг бүсээс 1-2 аймгийг зорилготойгоор сонгов. Захиалагчаас аймгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл харьцангуй өндөр, дундаж, бага хэмээн ангилж, зорилготойгоор сонгохыг санал

болгосны дагуу аймаг бүрээс аймгийн төвийн сумыг зорилготойгоор, 2-3 сумыг санамсаргүйгээр, сум бүрээс сумын төвийн сумыг зорилготойгоор, хөдөөгийн багийг санамсаргүйгээр сонгов. Багийн иргэдийн нэгдсэн мэдээллийн сангаас энгийн санамсаргүй түүврийн аргачлалын дагуу түүврийн хэмжээнд тохируулан сонгуулийн насны хүн амыг сонгож судалгаанд хамрууллаа.


Нийслэл Улаанбаатарыг төвийн ба холын дүүрэг гэж мужлан, төвийн мужаас 4, холын мужаас 2 дүүргийг санамсаргүйгээр сонгов. Дүүргээс хороодыг санамсаргүйгээр сонгож, хороодыг гэр хорооллын болон орон сууцны гэж хуваан, газар зүйн байршлаар зураглал үйлдэн, хорооны иргэдийн мэдээллийн нэгдсэн системийг ашиглан санамсаргүйгээр түүвэрлэн судалгаанд хамруулав.

Зураг 1.4.1 Түүврийн төлөвлөлтийн бүдүүвч



ТМЯ-д оролцогчдыг улс төрийн нам, хүчний гишүүн, намын дотоодын болон иргэдийн төлөөллийн байгууллагын сонгуульд нэр дэвшин оролцсон гэсэн хоёр шалгуураар сонгосон болно. Ингэхдээ УИХ, аймаг, нийслэлийн ИТХ, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-д өрсөлдөж байсан, намын дотоод сонгуульд оролцсон, сонгуульд ялсан, ялагдсан аль алины төлөөллийг судалгаанд хамруулахаар зорьсон болно. Аймаг, дүүргүүдээс улс төрийн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага, холбоо, орон нутгийн ИНБ-аас өгсөн мэдээллийн тусламжтайгаар ТМЯ-д оролцогчдын жагсаалт гаргаж, судалгаанд хамруулсан бөгөөд харьцангуй идэвхтэйгээр судалгаанд хамрагдсан болно. Харин УИХ-ын гишүүд, сайд, НИТХ-ын төлөөлөгчдөөс судалгаанд хамруулахдаа судлаачид УИХ-д суудалтай гурван нам болох МАН, МАН, ХҮН-аас судалгаанд хамруулах намын гишүүдийн жагсаалт авч тус судалгаанд хамрууллаа.

Зураг 1.4.2 Түүврийн төлөвлөлт, мэдээлэл цуглуулах аргуудаар



## 1.5 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа

### Туршилтын судалгаа

Туршилт судалгааны бэлтгэл ажлын хүрээнд 5 талбарын ахлагч, 10 мэдээлэл цуглуулагчийг оролцуулан 2024 оны 1-р сарын 15-нд хагас өдрийн сургалтыг зохион байгуулав.

2024 оны 1-р сарын 18-ны өдөр СХД-ийн 41-р хороон дээр туршилтын үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд судлаач нар хэсгийн ахлагч нараар газрын байршлыг хуваарилан авч, тус бүр 10, нийт 50 хүн амыг асуулгын судалгаанд хамруулав. 2024 оны 1-р сарын 18-ны өдөр БЗД-ийн 2-р хороонд туршилтын судалгааг явуулж 16 хэсгийн 50 өрхийг асуулгын судалгаанд хамруулсан бөгөөд цаасан болон цахим (таблет) хэлбэрээр авч туршсан болно. Мөн хороо тус бүрд нэг удаагийн ФБЯ, эрэгтэй, эмэгтэй 2 улс төрчтэй ганцаарчлан ярилцав. Туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан мэдээлэл цуглуулах хэрэгслийг дахин сайжруулсны зэрэгцээ мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, түүврийн арга, мэдээллийн чанарын баталгаат байдлыг сайжруулах тодорхой саналуудыг олж авч судалгааны аргачлалд тусган ажиллав.

**Мэдээлэл цуглуулах ажлын менежмент.** Мэдээлэл цуглуулах ажил нийт 21 хоног үргэлжиллээ. Мэдээлэл цуглуулах ажлыг нийт 3-4 (түүврийн хэмжээнээс хамаараад) судлаачийн бүрэлдэхүүнтэй 7 баг гүйцэтгэв. Баг бүр талбарын менежер 1, мэдээлэл цуглуулагч 2-3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Талбарын менежер зорилтот орон нутаг дахь мэдээлэл цуглуулах ажлыг удирдамж, төлөвлөлтийн дагуу зохион байгуулсны зэрэгцээ чанарын судалгааны мэдээлэл цуглуулж, мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, багийн ажлын нэгтгэл гарган ажиллав. Тус нэгтгэлд тухайн өдрийн хариултын түвшин (response rate)-г тодорхойлсон бөгөөд хариултын түвшин дунджаар 98 хувьтай байлаа.

Дотоод чанарын хяналтыг талбарын менежерээс гадна хяналт шинжилгээний менежер өдөр тутам тавьж ажиллав. Судалгаанд оролцогчдын нэгтгэлээс 20 хувийг санамсаргүйгээр түүвэрлэн, нэгд, зорилтот нутгийн хүн амыг хамруулсан эсэх, хоёрт, түүврийн төлөвлөлтийн дагуу сонгогдсон эсэх, гуравт, судалгаанд бүрэн хамрагдсан эсэхийг хянаж ажиллав.

## 1.6 Мэдээлэл боловсруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа

Мэдээлэл боловсруулах, нэгтгэх үйл ажиллагааг 10 хоногийн хугацаанд төлөвлөн гүйцэтгэв. Асуулгын болон түлхүүр мэдээлэгчийн ярилцлагын мэдээллийг талбарын ахлагч нараас шалган хүлээн авсны дараа кодлон, SPSS 25 программд хувьсагчийг шивэв. Оператор шивэлтийн алдааг шалгаж, санамсаргүй болон логик алдааг хянаж дүн шинжилгээ хийхэд бэлтгэв. Асуулга болон ТМЯ-ын зарим хувьсагчийн мэдээлэлд дараах статистикийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

1. Давтамж, хувийн жин, дундаж, медиан, стандарт хазайлт г.м тодорхойлох статистикийн шинжилгээ,
2. Хэв маягчлал, дахин бүлэглэлтийн болон олон хариулт бүхий хувьсагчийн давтамж, хувийн жинг тооцох,
3. Хамаарлын шинжилгээ хийх. Асуулгад гол төлөв нэрлэсэн, дараалалт шкалчлалыг түлхүү ашигласан тул хүйс, хэвшмэл ойлголтой эсэх, хүүхдийн тоо, гэрлэлт, байршлаар шинжилгээ хийхдээ харьцуулсан хүснэгтийг ашиглан, чанарлаг шинж тэмдгийн хамаарлын шинжилгээг хийж, статистикийн ач холбогдлын түвшнийг шалгав.

Фокус бүлгийн ярилцлагын дэлгэрэнгүй тэмдэглэлийг MS Excel программд асуулт бүрээр оруулж, шинжилгээг гүйцэтгэсэн. Мөн ТМЯ-ын мэдээллийг SPSS 25 программд шивж, нээлттэй асуулт бүрийг ФБЯ-ын адил чанарын дүн шинжилгээний дараах аргуудыг ашиглан гүйцэтгэв. Үүнд:

1. Мэдээллийг кодлох,
2. Категоричлох,
3. Хүйс, нас, албан тушаал, үндэс угсаагаар аналитик жишилт хийх
4. Матрицлах, хэв маягчлах аргачлалын дагуу дүн шинжилгээг хийв.

## 1.7 Судалгаанд баримталсан ёс зүйн зарчмууд

Дэлхийн социологичдын холбооноос баталсан Нийгэм судлаачдын ёс зүйн хэм хэмжээ, Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн байгууллагаас баталсан Монгол Улсын стандарт MNS ISO 20252: 2019-ийг баримтлан ажиллав. Судалгаанд оролцсон хүн ам, эрэгтэй, эмэгтэй улс төрчдийн өгсөн мэдээллийг Хувь хүний нууцлалыг хангах тухай Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хадгалж, зөвхөн судалгааны зориулалтаар ашиглахыг урьдчилан танилцуулж, судалгаанд оролцох зөвшөөрлийг авч ажиллалаа.

Тодруулбал:

- Хувь хүний нууцлалыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хадгалах, хамгаалах үүргийг хүлээх,
- Оролцогч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд судалгаанд хамруулах,
- Оролцогчийн нэр хүнд, эрхийг хамгаалах, ажил, амьдралын аюулгүй байдлыг хангах
- Нотолгоог үнэн зөвөөр бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд чанарыг эрхэмлэх,
- Судалгаагаар илэрсэн баримтыг гуйвуулахгүйгээр бодит байдлыг тайлбарлахад ашиглах зэрэг болно.

# ХОЁР


## СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 2.1 Асуулгын судалгаа

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо, жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн хэм хэмжээний талаарх олон нийтийн төсөөлөлд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох судалгаанд оролцогчдын нийгэм хүн ам зүйн төлөв байдлыг нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал, ажил эрхлэлт гэсэн үзүүлэлтүүдээр шинжиллээ. Судалгаанд Баян-Өлгий, Завхан, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Ховд, Хэнтий аймгийн 24 сум, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Багануур, Налайх дүүргийн нийт 1200 хүн амыг хамруулав.

Оролцогчдын 45.2 хувийг эрэгтэй, 54.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж, насны хувьд 34.2 хувь нь залуу, 42.2 хувь нь дунд, 23.6 хувь нь ахмад насны хүн ам байна. Судалгаанд оролцсон хүн амын дундаж нас 42.9. Боловсролын түвшнээр шинжлэхэд, 37.2 хувь нь дээд, 8.2 хувь нь тусгай дунд, 38.8 хувь нь бүрэн дунд, 12.8 хувь нь бүрэн бус дунд, 2.2 хувь нь бага, 0.8 хувь нь сургуульд сурч байгаагүй байна. (Зураг 2.1.1). Судалгаанд оролцогчдын 44.7 хувь нь нийслэл Улаанбаатар хот, 55.3 хувь нь орон нутагт буюу аймаг, сумын төв болон хөдөө нутагт аж төрж байна.

Зураг 2.1.1. Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, хувиар болон хүйсээр.



Ажил эрхлэлтийн статусаар авч үзвэл 31.1 хувь нь төрийн байгууллагад, 20.2 хувь нь хувийн хэвшилд, 2.2 хувь нь ОУБ, ИНБ, 15.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 13.5 хувь нь өндөр насны тэтгэвэрт, 1.8 хувь нь нийгмийн халамжийн тэтгэмж авдаг, 4.8 хувь нь малчин, 3.2 хувь нь оюутан, 5.5 хувь нь ажилгүй, 2.8 хувь нь хүүхэд, гэр бүлийн гишүүнээ асарч байна (Хавсралт 1). Судлагдсан хүн амын

53.7 хувь нь тогтмол цалин хөлс, орлого бүхий хөдөлмөр, 20 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, МАА-н хөдөлмөр, 19 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвтэй байна.

Судлагдсан хүн амын 75.8 хувь нь халх, 11.2 хувь нь үндэстний цөөнх, 24.2 хувь нь өөр бусад угсаатны бүлэгт багтах хүн ам эзэлж байна. Өөлд, урианхай, дархад, хотон, дөрвөд, баяд, буриад, захчин, үзэмчин, мянгад, дарьганга, хотгойд гэсэн нийт 13 угсаатны бүлгийн хүн ам асуулга судалгаанд оролцсон байна (Хавсралт 2).

## 2.2 Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага

ТМЯ-д оролцогчдын нийгэм хүн ам зүйн байдлыг нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил, намын харьяалал, улс төрийн үйл ажиллагааны идэвх оролцооны үзүүлэлтээр тодорхойлов.


Судлагдсан албан тушаалтнуудын 5 хувь нь доктор, 48.5 хувь нь магистр, 39.6 хувь нь бакалавр, 3.0 хувь нь дипломын, 2 хувь нь тусгай мэргэжлийн, 1 хувь нь бүрэн дунд, 1 хувь нь бүрэн бус боловсролтой байна. Улс төрийн намын гишүүнчлэлийг тодруулахад, 89.1 хувь нь намын гишүүн, 10.9 хувь нь намын харьяалалгүй аж. Хоёр жилээс эхлээд 34 жилийн туршлагатай улс төрч судалгаанд оролцсон нь туршлагын хувьд харилцан адилгүй төлөв байдалтайг харуулж байна. Улс төрчид дунджаар 15 жил улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ба хүйсийн хувьд ялгаа ажиглагдсангүй.

Хүснэгт 2.2.1 ТМЯ-д оролцогчдын нийгэм, хүн ам зүйн мэдээлэл

Үзүүлэлт		
Боловсрол	Тоо	Дүнд эзлэх хувь
Доктор	5	5
Магистр	49	48.5
Бакалавр	40	39.6
Дипломын	3	3.0
Тусгай мэргэжлийн	2	2
Бүрэн дунд	1	1
Бүрэн бус дунд	1	1
<b>Намын харьяалал</b>		
МАН	61	60.4
АН	26	25.7
ХҮН	3	3.0
Нам бус, бие даагч	11	10.9
<b>Сонгуулийн үр дүн</b>		
2 ба түүнээс дээш удаа сонгогдсон	49	48.5
1 удаа сонгогдсон	37	36.6
Сонгогдож байгаагүй	9	8.9
Нэрээ дэвшүүлээгүй	6	5.9
<b>Нийт</b>	<b>101</b>	<b>100.0</b>

Судлагдсан нийт улс төрчдийн 51.6 хувь нь хоёр ба түүнээс дээш удаа, 38.9 хувь нь нэг удаа аль нэг шатны иргэдийн төлөөллийн байгууллагад сонгогдсоныг хүйсээр аваад үзвэл эрэгтэй улс төрчдийн 59.2 хувь болон эмэгтэй улс төрчдийн 43.5 хувь нь хоёр ба түүнээс дээш удаа, эрэгтэй улс төрчдийн 36.7 хувь, эмэгтэй улс төрчдийн 41.3 хувь нь нэг удаа сонгогдсон туршлагатай байна.

Зураг 2.2.1 Иргэдийн төлөөллийн байгууллагын сонгуулийн үр дүн, хувиар, хүйсээр



### 2.3 Фокус бүлгийн ярилцлага

ФБЯ-д нас, хүйс, нийгмийн байдал, байршил, үндэс угсаа, шашин шүтлэгээрээ ялгаатай бүлгийн хүн амыг хамруулав. 7 аймаг, 6 дүүрэгт зохион байгуулсан 26 удаагийн ФБЯ-д 169 хүн амыг оролцуулж, манлайлагч, улс төрч эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаарх дүр, хүлээлт, жендэрийн хэвшмэл үзэл, хэм хэмжээг судлав. Нэг удаагийн ФБЯ-д 6-8 хүнийг оролцуулан зохион байгуулав.

ФБЯ-д малчин, ахмад, дунд, залуу, тариаланч, бичил уурхайчин, уурхайчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, шашны цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, угсаатны цөөнх зэрэг нийгэм-хүн ам зүйн бүлгийн төлөөлөл бүхий эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс дагнан бүрдсэн хийгээд аль аль хүйсийг хамруулсан холимог бүлгээс мэдээлэл цуглуулсан.

## ГУРАВ

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

#### 3.1 Жендэрийн хэвшмэл үзэл

Судалгаанд оролцсон иргэдийн дунд жендэрийн хэвшмэл үзэл хэр илэрч байгааг тодруулахдаа 2021 оны судалгааны адилаар 10 асуултаар тодруулав. Судалгаагаар 2021 оны үр дүнг давтсан буюу судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь жендэрийн дүр үүргийн хуваарийг хэвшмэл үзэлд автахгүйгээр төсөөлж байна. Үүнд:

- **Өрхийн хөдөлмөрийн хуваарийн талаарх хэвшмэл үзэл**

Гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох хэвшмэл үзэл судалгаанд оролцогчдын 40 гаруй хувьд байгааг тус хоёр судалгааны дүн давхар нотолж байгаа бөгөөд 2021 оноос хойш томоохон өөрчлөлт гараагүй байна.

Гэрийн ажлын үүргийг “аль аль нь” хийж болно гэсэн хариулт 2021 оныхоос 1 хувиар буурсан атлаа гэрийн ажлын үүргийг эрэгтэйд, тэжээх үүргийг эмэгтэйд оногдуулсан буюу хэвшмэл үзлийн эсрэгээр оногдуулсан хариулт тус бүр 2 хувиар өссөн байна (Хүснэгт 3.1.1).

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнх ялгаагүйгээр өрхийн хүүхэд асрах үүрэгт хэвшмэл үзлээр хандаж байгаа бөгөөд тэр дундаа эмэгтэй оролцогчдод бага зэрэг илүү илэрч буй дүн 2021 оны судалгааны дүнтэй адил илрэв. Энэ ялгаа статистикийн шинжилгээгээр анхаарч үзүүштэй түвшинд байна. Ялангуяа сургуульд сурч байгаагүй болон бага боловсролтой эмэгтэйчүүд 100 хувь хүүхэд асрах үүргийг эмэгтэйд оногдуулж байгаагаас харахад тэдэнд жендэрийн хэвшмэл үзэл түлхүү илэрч байна. Энэ нь эмэгтэйчүүд, тэр дундаа дээрх бүлгийн эмэгтэйчүүд бага насны хүүхдээ асрах үүргийг илүүтэй өөртөө нааж, нийтийн амьдрал дахь оролцоогоо хязгаарлах хандлагатайг тодорхой хэмжээгээр илэрхийлэх юм. Гэхдээ хүүхэд асрах үүргийг эмэгтэйд оногдуулдаг оролцогчдын тоо эрэгтэй, эмэгтэй оролцогч тус бүрд 6.4 хувиар буурч, эрэгтэйд оногдуулах хандлага 2 хувь, хоёулаа гүйцэтгэхийг дэмжих хандлага 5 орчим хувиар өссөн байна (Зураг 3.1.1). Судалгааны үр дүн өрхийн хөдөлмөрийн хуваарь дахь жендэрийн хэвшмэл үзэл буурах чиг хандлага буйг илэрхийлж байна.

- **Өрхийн эрх мэдлийн хуваарийн талаарх хэвшмэл үзэл**

Өрхийн эрх мэдлийн хуваарьт жендэрийн хэвшмэл үзэлгүйгээр хандагчид 58-аас дээш хувийг эзэлж байна. Харин аль нэг хүйсэд оногдуулсан хариулт өгөхдөө гэр бүлд тулгамдсан асуудлыг шийдэх шийдвэрийг гаргах, орон нутаг, ИНБ, холбоо, улс төрийн намын гишүүдийн хурал зөвлөгөөнд оролцох ажлыг эрэгтэй хүнд, эхнэр эсвэл нөхрийн (хосынхоо) юу хийх, ямар зан авир гаргахыг хянах, зөвшөөрөл өгөх үүргийг эмэгтэй хүнд хамаатуулах нь өндөр байна. Хөрөнгө нөөц захиран зарцуулах шийдвэр гаргах үүргийг эрэгтэй, эмэгтэй хүнд хамаатуулсан хариултын жин 2021 оны судалгаагаар тэнцүүхэн, эрэгтэйд хамаатуулах нь 2024 онд 2 хувиар өндөр илэрлээ (Хүснэгт 3.1.1).



Өмнөх судалгаатай харьцуулахад олон нийтийн үйл ажиллагаан дахь эрэгтэй, эмэгтэй хүний оролцооны талаарх төсөөлөлд бага зэргийн өөрчлөлт ажиглагдлаа. Тодруулбал, “Орон нутаг, ИНБ, холбоо, улс төрийн намын гишүүнчлэлийн хурал зөвлөгөөнд оролцох” ажилд эрэгтэй хүн оролцох нь зүйтэй гэсэн хариулт 2021 онд 27.9 хувь байсан бол 2024 онд 23.3 хувь буюу 4.5 хувиар бага байгаа атлаа эмэгтэй хүн оролцох нь зүйтэй гэсэн хариулт 14.4 хувь байсан нь 2024 онд 18.2 хувь болж өмнөхөөс 3.8 хувиар илүү, аль аль нь оролцох нь зүйтэй гэсэн хариултын хувь 0.9 хувиар илүү дүн гарав. Тулгамдсан асуудлыг шийдэх, хөрөнгө нөөцийг захиран зарцуулах шийдвэрийг гаргахад эрэгтэй хүн илүү эрх мэдэлтэй гэсэн хариулт 2 хувиар, харин гэр бүлийн гишүүдийн зан үйлийг хянах үйлд эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг эрх мэдэлтэй гэж үзсэн хариулт тус бүр 4.6 хувиар өссөн байна (Хүснэгт 3.1.1).


Хүснэгт 3.1.1 Хэний оролцоо давуу байх нь зүйтэй вэ?, хувиар

Төрөл	Үйл ажиллагаа	2021 он			2024 он		
		Эр	Эм	Аль аль нь	Эр	Эм	Аль аль нь
Өрхийн хөдөлмөрийн хуваарь	Гэрийн ажил хийх (хоол хийх, хүүхэд асрах, хүмүүжүүлэх)	2.1	43.1	54.8	4.7	43	52.3
	Гэр бүлээ тэжээх, өрхийн төсөв бүрдүүлэх	44.8	4.9	50.3	43.5	7.1	49.4
Эрх дэх эрх мэдлийн хуваарь	Гэр бүлд тулгамдсан асуудлыг шийдэх шийдвэрийг гаргах	20.4	10	69.6	22.3	11.3	66.4
	Эхнэр эсвэл нөхрийн (хосынхоо) юу хийх, ямар зан авир гаргахыг хянах, зөвшөөрөл өгөх	7	16.4	76.6	11.6	21	67.4
	Хөрөнгө нөөц захиран зарцуулах шийдвэр гаргах	18.1	17.2	64.7	20.3	18.1	61.6
Нийгэм-улс төрийн оролцоо	Орон нутаг, ИНБ, холбоо, улс төрийн намын гишүүнчлэлийн хурал зөвлөгөөнд оролцох	27.9	14.4	57.7	23.3	18.2	58.6
<b>Нөхцөлт бодомжийн хариулт</b>							
Өрхийн хөдөлмөрийн хуваарь	Ижил чадамжтай эхнэр ба нөхрийн хэн нь бага насны хүүхдээ асрах нь дээр вэ?	3.3	61.3	35.4	5.1	55	39.9
Улс төрийн оролцоо	Ижил чадамжтай эхнэр ба нөхрийн хэн нь улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь дээр вэ?	42.4	12	45.5	35.7	14.2	50.1
Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2021, 2024							


**• Улс төрийн оролцоо, удирдах ажил, манлайллын талаарх хэвшмэл үзэл**

Эрэгтэй, эмэгтэй хүний улс төрийн оролцооны талаарх хэвшмэл үзэл судалгаанд оролцогчдын гуравны нэгд нь илэрлээ. Үүнд хүйсээс хамаарах байдал ажиглагдсангүй. Харин улс төрийн оролцоог эрэгтэй хүнд хамааруулах хандлагыг өмнөх судалгаатай харьцуулахад эрэгтэй оролцогчдын хувьд 6.7 хувь, эмэгтэй оролцогчдын хувьд 6.9 хувиар бага түвшинд илэрч (Зураг 3.1.2), улс төрийн оролцооны талаарх жендэрийн хэвшмэл үзэл буурах төлөвтэй байна. 2021 оны судалгаагаар жендэрийн хэвшмэл үзэл нь эмэгтэй хүний улс төр дэх оролцоог дэмжих хандлагад сөргөөр нөлөөлж буйг илрүүлсэн. Иймд жендэрийн хэвшмэл үзэлтэй сонгогчдын тоо буурах нь эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог дэмжих хандлага олон нийтийн дунд давамгайлахад чухал үүрэгтэй юм.

Зураг 3.1.1 Эхнэр, нөхөр хоёулаа ажил мэргэжлийн чадамж, цалин ижил бол хэн нь бага насны хүүхдээ асрах нь дээр вэ?, хүйсээр болон хувиар



Зураг 3.1.2 Эхнэр, нөхөр хоёулаа ажил мэргэжлийн чадамж, цалин ижил бол хэн нь улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь дээр вэ?, хүйсээр болон хувиар



Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2021, 2024 (2021:  $\chi^2 = 7.850$ ,  $p < .020$ ; 2024:  $\chi^2 = 6.101$ ,  $p < .047$ )

Удирдах ажил, манлайллыг жендэрийн хэвшмэл үзлээр тодорхойлох хандлага харьцангуй бага илэрч байгаа ч удирдах ажлыг эмэгтэй хүн эрхэлж чадна гэдэгт үл итгэх хандлага 2021 онд 16.7 хувь байсан бол 2024 онд 14.2 хувьд нь болж буурсан нь сүүлийн 3 жилийн хугацаанд ийм хандлага бүхий оролцогчдын тоо 2.5 хувиар багассан эерэг төлөв ажиглагдав. Мөн эмэгтэй хүн манлайлагч гэдэгт үл итгэх хандлага 18.3 хувиас 10.4 хувь болж 8 хувиар буурсан байна.

Хүснэгт 3.1.2 Удирдах ажил, манлайлагчаар итгэл хүлээлгэх байдал, хувиар

Нэгэн байгууллагад зэрэг ажилд орсон эрэгтэй эмэгтэй ажилтнаас таван жилийн дараа хэлтсийн даргаар хэнийг нь ажиллаж чадна гэж бодож байна вэ?				
	Огт итгэхгүй байна	Ерөнхийдөө итгэхгүй байна	Ерөнхийдөө итгэлтэй байна	Бүрэн итгэлтэй байна
<b>2021 он</b>				
1. Эрэгтэйд итгэх эсэх	1.8	5.4	50.9	41.9
2. Эмэгтэйд итгэх эсэх	2.1	14.6	48.9	34.4
<b>2024 он</b>				
1. Эрэгтэйд итгэх эсэх	2.2	6.8	41.8	49.3

2. Эмэгтэйд итгэх эсэх	2.4	11.8	47.3	38.4
<b>Та эрэгтэй, эмэгтэйчүүдийн хэнийг нь манлайлагч гэдэгт итгэлтэй байна вэ?</b>				
	<b>Огт итгэхгүй байна</b>	<b>Ерөнхийдөө итгэхгүй байна</b>	<b>Ерөнхийдөө итгэлтэй байна</b>	<b>Бүрэн итгэлтэй байна</b>
<b>2021 он</b>				
1. Эрэгтэйд итгэх эсэх	1.1	6.9	48.5	43.5
2. Эмэгтэйд итгэх эсэх	2.9	15.4	54	27.7
<b>2024 он</b>				
1. Эрэгтэйд итгэх эсэх	1.1	4.4	45.4	49.1
2. Эмэгтэйд итгэх эсэх	1.7	8.7	51.3	38.3
Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2021, 2024				


ФБЯ-аар удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний хэн нь илүү тохиромжтой болохыг салбараар ялгаж сонгож байгаа эсэхийг тодруулав. Үүнд оролцогчдын 50-иас дээш хувь нь боловсрол, эрүүл мэндээс бусад салбарыг эрэгтэй хүн илүү сайн удирдаж чадна гэж үзсэн. Ялангуяа цэрэг армийн удирдлагад эрэгтэй хүний биеийн хүчний давамгайл байдал, дайнд эрчүүд явдаг зэрэг (91.9 хувь) үндэслэлээр, улсын тэргүүн бол эр хүн байх ёстой (75.4 хувь) гэж, Засгийн газрын тэргүүн илүү алсын хараатай шийдвэр гаргадаг, тууштай байж чадах хүн нь эр хүн (69.4 хувь) тул гэсэн хэвшмэл үзэл бүхий үндэслэлээр эрэгтэй хүнийг илүүд үзэж буйгаа илэрхийлсэн байна. Эдгээр албан тушаалд эмэгтэй хүн байж болно, хэн ч чадна гэсэн хариултыг гол төлөв эмэгтэйчүүд л өгч байв. Хэдийгээр оролцогчдын дийлэнхэд эрэгтэй, эмэгтэй адил тэнцүү байвал зохино гэсэн хариулт давамгайлж байсан ч орон нутгийн удирдлагад (65.7 хувь), хууль тогтоох байгууллагын гишүүн\төлөөлөгчийн хувьд (63.4 хувь), шүүхийн байгууллагын удирдлагад (60.4 хувь), гадаад харилцааны салбарын удирдлагад эрэгтэй хүн байвал зохино гэж оролцогчдын 52.9 хувь нь үзжээ (Зураг 3.1.3).

ФБЯ-аар аль салбарын удирдлагад хүйсийн хувьд хэн байвал зохилтойг сонгож тайлбарлахдаа 1. Тухайн салбарт ямар хүйсийн хүн зонхилон ажилладаг, 2. Тухайн салбарын удирдлагаар ихэвчлэн ямар хүйсийн хүн ажилладаг тухай өмнөх туршлага, олон нийтийн дунд тогтсон ойлголтоос ихээхэн хамааралтай байв. Ерөнхийлөн дүгнэвэл, салбаруудыг жендэрчлэн ялгаж үзэх хэвшмэл үзэл илэрч байна. Түүнчлэн, тухайн салбарт эмэгтэй удирдлага байж болох эсэхэд тухайн цаг үе дэх бодит дүр ихээхэн үүрэгтэй аж. Тодруулбал, гадаад харилцааны салбарын удирдлагаар “эмэгтэй хүн байвал бусад улс элэг барина” гэх мэт эмэгтэй хүнийг сул дорой гэсэн үнэлэмж бүхий дүгнэлт цөөн тохиолдол байсан. Гэсэн ч “Одоогийн эмэгтэй гадаад харилцааны сайд сайн удирдаж байна”, “өмнө нь бас эмэгтэй сайдтай байсан” гэх зэргээр хүйсийн хувьд хэн нь ч ялгаагүй гэх олон нийтийн итгэл үнэмшил бүрэлдэхэд чухал үүрэгтэй болох нь ажиглагдлаа. Үүний адил “Эмэгтэй ерөнхийлөгчтэй, ерөнхий сайдтай, аймгийн Засаг даргатай байгаагүй” гэх өнцгөөр дурдсан албан тушаалыг эрэгтэйд хаяглах нь нийтлэг ажиглагдав.

Ирээдүйд Монгол Улс эмэгтэй Ерөнхийлөгчтэй болно гэдэгт хэр итгэлтэй байгааг асуулгад оролцогчдоос тодруулахад судалгаанд оролцогчдын 44.4

хувь нь итгэлгүй, 41.6 хувь нь итгэлтэй байгаа бөгөөд хүйсээр шинжилбэл, эмэгтэйчүүдийн 45.7 хувь, эрэгтэйчүүдийн 36.7 хувь нь итгэлтэй байгаагаар илэрхийлжээ. Ер нь ФБЯ-ын үеэр удирдах ажлыг зөвхөн эрэгтэй хүйсэд хамаатуулдаг, хэвшмэл үзэл бүхий үндэслэлээр зөвтгөдөг хүмүүсийн олонх нь эрэгтэйчүүд байсан бөгөөд тэдний хэвшмэл үзэл эрх мэдлээ хадгалж үлдэх гэсэн эрмэлзэлтэй уялдаатай байх магадлалтай юм.

Зураг 3.1.3 Салбаруудын удирдлага болон нэр бүхий өндөр албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүнийг илүүд үзэх сонголт, хувиар



Эх сурвалж: ФБЯ, 2024

ФБЯ-ын дүнд тулгуурлан “манлайлагч”-ийг хэний дүрээр харж байгаагаас нь жендэрийн хэвшмэл үзлийг тодруулахыг зорилоо. Асуулгын судалгааны адил манлайлагч байх эсэхэд хүйс гэхээсээ тухайн хүний боловсрол, чадвар чухал нөлөөтэй гэж үзэх нь зонхилж илэрсэн ч хүйсийн хувьд ялгаа илрэв. Тодруулбал эрэгтэйчүүдийн ярилцлагад эмэгтэй хүнийг манлайлагч гэж хүлээн зөвшөөрөх тохиолдол тун цөөн таарсан бөгөөд тэр дундаа залуу эрэгтэйчүүдийн дунд эмэгтэй хүнийг манлайлагч хэмээн хүлээн зөвшөөрсөн нэг ч тохиолдол гарсангүй. Харин байгалиасаа манлайлах чадвартай, уламжлал ёсоор өрхийн тэргүүн тул эрэгтэйчүүд манлайлагч гэх үзэл бодол давамгайлав. Эмэгтэйчүүдийг манлайлж чадна гэсэн үндэслэлийг цөөхөн эрэгтэйчүүд илэрхийлсэн бөгөөд боловсрол өндөр, авлигыг бууруулах, нарийвчилж хардаг чадвартай ч, өөртөө итгэлгүйн улмаас улс төрөөс бусад талбарт манлайлдаг гэсэн цөөн тооны үндэслэлээр тайлбарлажээ.

Харин эмэгтэйчүүдийн, ялангуяа залуу болон дунд насны эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлагад нас, үндэс угсаа, байршлаас үл хамааран эмэгтэй хүнийг манлайлагч гэдгийг хүлээн зөвшөөрч буйгаа илтгэх, хүлээн зөвшөөрүүлэхээр чармайж үндэслэлийг дэлгэрүүлэн ярилцах нь олонтоо байв. Тодруулбал, залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлагад дурдсаныг нэгтгэн ангилбал 8, дунд насны эмэгтэйчүүд 15 үндэслэлээр эмэгтэй хүнийг манлайлагч болохыг тайлбарлажээ. Харин ахмад эмэгтэйчүүдийн ярилцлагад эмэгтэйчүүд манлайлж чадахгүй байгаагийн шалтгааныг тайлбарлахад түлхүү анхаарчээ. Бүхий л эмэгтэйчүүдийн ярилцлагад эрэгтэйчүүд манлайллаар тэргүүлж байгаагийн үндэслэлийг тайлбарлахдаа өнөөгийн эрх мэдлийн бүтцийн бодит байдал (дээгүүр албан тушаалд эрчүүд л байдаг, цаг заваа зарцуулж чаддаг, улс, эдийн засгийн эрх мэдэл эрэгтэйчүүдэд байна г.м)-тай холбон тайлбарлаж байв. Эмэгтэйчүүдийг хамруулсан бүх бүлгийн ярилцлагад эрэгтэйчүүдийг манлайлагч болохыг хүлээн зөвшөөрсний зэрэгцээ нөгөө хүйсийг дорд үзсэн яриа, хэллэг ашиглаагүй бол

эрэгтэйчүүдийн ярианд “эрэгтэйчүүдийг дөвийлгөн магтсан атлаа эмэгтэй хүйсийг дорд үзсэн” (тулга тойрсон хэрүүл тасрахгүй г.м) шинжтэй яриа гарч байлаа.

Чанарын судалгааны дээрх баримтаар эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдийг дорд үзсэн, үл итгэсэн хэвшмэл үзэл илэрч буйг нотолж байна. Эмэгтэйчүүдийн ярилцлагад эмэгтэйчүүдийн манлайлалд учирч буй саад бэрхшээлийг онцолж, гол төлөв гэр бүлийн ачаалалтай холбон тайлбарласан нь түгээмэл байв. Эрэгтэйчүүдийн ярилцлагад эрэгтэй хүний манлайлагч болохыг хүлээн зөвшөөрөхдөө уламжлагдсан нэр хүнд, өрхийн тэргүүн гэх үндэслэлээр тайлбарлаж, уламжлалыг хадгалах сонирхолтой болохоо илтгэн харуулж байв.

Матриц 3.1.1 Хэн нь манлайлагч вэ? хүйс болон насаар

		Эрэгтэй хүн бол манлайлагч	Эмэгтэй хүн бол манлайлагч	Ялгаагүй
Эр	Залуу	<ul style="list-style-type: none"> <li>Өрхийн тэргүүн төрөлхийн манлайлагч</li> <li>Түшигтэй</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>Ухаан, мэдлэг боловсрол, харизмд хүйс хамаагүй</li> </ul>
	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Давуу чанартай (шийдэмгий, зоримог г.м)</li> <li>Өрхийн тэргүүн</li> <li>Сэтгэн бодох чадвартай</li> <li>Удирдлагын чадвартай, туршлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Давуу чанартай (нарийвчилж хардаг)</li> <li>Манлайлагч эмэгтэйчүүд олон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Боловсрол, чадвараар манлайлна</li> <li>Уламжлалаар манлайлагчийг хардаг</li> </ul>
	Ахмад	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүд сул талтай (хэрүүл салдаггүй)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Боловсролтой</li> <li>Авлига багасна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ард түмний төлөө хүн – манлайлагч</li> </ul>
Эм	Залуу	<ul style="list-style-type: none"> <li>Удирдагч</li> <li>Давуу чанартай (шийдэмгий, тууштай г.м)</li> <li>Чадварлаг (харилцааны, нэгтгэж чаддаг)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Давуу чанартай (шударга, хөдөлмөрч, нямбай, нарийвчилдаг г.м)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөгжил, боловсрол</li> <li>Манлайлагч</li> </ul>
	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>Давуу чанартай (ноён нуруутай, холыг хардаг)</li> <li>Манлайлж ирсэн түүхтэй</li> <li>Цаг завтай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Давуу чанартай (нягт нямбай, шударга, тэвчээртэй)</li> <li>Боловсролтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бүтээгч-манлайлагч</li> </ul>
	Ахмад	<ul style="list-style-type: none"> <li>Эрх мэдэл - эрэгтэйд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Давуу тал ихтэй ч илтгэж чаддаггүй</li> <li>Ар гэрээ авч явдаг</li> <li>Ачаалал дааж чаддаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэвшмэл үзлээр хардаг</li> </ul>

### Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангана” гэдгийг юу гэж ойлгож байгааг тодруулах үүднээс асуулгын судалгаанд нээлттэй асуултаар асуусан. Судалгаанд оролцогчдын 41.5 хувь нь мэдэхгүй байна гэж хариулсан. Дэлгэрэнгүй хариулт өгсөн хүмүүсийн дийлэнх нь эрэгтэй, эмэгтэй хүний, хүйсийн тэгш байдал, эрх тэгш байдал, тэгш оролцоо, тэгш эрх, тэнцвэртэй байдал, ялгаварлалгүй байдал, тэгш боломж гэсэн утгаар хариулт өглөө. Цөөн хэсэг нь тэгш байдал, тэгш эрх, тэгш боломжийг бүх нийтийн амьдралын хүрээгээр хязгаарласан бол түүнтэй ижил хэмжээний хэсэг хүмүүс эрх гэр бүл харилцаа, хосуудын харилцаа, харилцан хүндэтгэл, халамж бүхий байдлыг ойлгож буйгаа илэрхийллээ. Мөн

тэдгээрээс тооны хувьд арай цөөн хэсэг нь ойлголтын утгыг бүрэн өгүүлсэн өгүүлбэрээр хариулсан байв. Мөн адил тооны оролцогчид эмэгтэйчүүдийн эрхийн төлөө, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх явдал хэмээн үзэж байв. Ажилгүйдлийг бууруулах, ажилтай болгох явдал гэх мэтээр нийгмийн асуудалтай холбож ойлгосон 5 хүрэхгүй тохиолдол илрэв. Эндээс судалгаанд оролцогчдын ойлголтын түвшин үндсэндээ хоёр хэсэгт хуваагдсан бөгөөд тал хэсэг нь уг ойлголтын талаар сайн мэдэхгүй байгаа бол нөгөө хэсэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдал, тэгш оролцоо, тэгш боломж (нийлээд 40 гаруй хувь), тэнцвэртэй байдал (7 орчим хувь) гэж ойлгож байна.

## Дүгнэлт

- Судалгаанд оролцогчдын тал гаруй хувь нь жендэрийн дүр үүргийн талаар хэвшмэл бус үзлээр хандаж байгаа бөгөөд хамгийн олон оролцогчдын дунд (40 гаруй хувьд) хадгалагдсан хэвшмэл үзэл бол гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох үзэл байна.
- Өрхийн хөдөлмөрийн хуваарь, нийгэм-улс төрийн үйл ажиллагаа дахь оролцооны талаарх төсөөллийг 2021 оны судалгааны дүнтэй харьцуулбал хэвшмэл үзлээр хандагсдын хувийн жин бага зэрэг буурчээ.
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь өрхийн хөдөлмөрийн хуваарьт жендэрийн хэвшмэл үзлээр хандаж байна. Хүүхэд асрах үүргийг эмэгтэйд оногдуулах хандлага эмэгтэйчүүдэд илүү илэрч байна. Ялангуяа сургуульд сурч байгаагүй болон бага боловсролтой эмэгтэйчүүдийн дунд хүүхэд асрах үүргийг эмэгтэйд бүрэн хамаатуулах хэвшмэл үзэл түлхүү байна.
- Чанарын судалгаагаар эрэгтэйчүүдийн дунд эмэгтэй хүнийг манлайлагч гэж хүлээн зөвшөөрөхөөсөө илүүтэйгээр эрэгтэйчүүд манлайлагч гэх үзэл бодол давамгайлж, “эрэгтэй хүнийг дөвийлгөн магтсан атлаа эмэгтэй хүйсийг дорд үзэх” зэргээр хэвшмэл үзэл илэрч байна.
- Эмэгтэй оролцогчдын дунд эрэгтэйчүүдийг манлайлагч болохыг хүлээн зөвшөөрсний зэрэгцээ нас, үндэс угсаа, байршлаас үл хамааран эмэгтэй хүнийг манлайлагч гэдгийг хүлээн зөвшөөрч буйгаа илтгэх, хүлээн зөвшөөрүүлэхээр чармайж байна. Мөн салбарын хувьд ялгаатай жендэрийн хэвшмэл үзэл бүхий хандлагаар удирдлага, манлайллыг авч үзэж буй нь эрүүл мэнд, боловсролоос бусад салбарт, тэр дундаа өндөр албан тушаал, шатлалын хамгийн дээр байх албан тушаалыг эрэгтэй хүнд хамаатуулж байгаагаар нотлогдож байна.
- Удирдлагын бүтэц дэх бодит амьдралын дүр нь жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөхөд чухал үүрэгтэй болох нь ажиглагдлаа.
- Судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” тухай тодорхой хэмжээний ойлголттой байгаа нь шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл санаа, үйл хэргийг олон нийтийн зүгээс дэмжих хэсэг цөөнх биш болохыг илтгэж байна.


### 3.2 Улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжих байдал

Олон нийт улс төр дэх эмэгтэйчүүдийг дэмжиж буй байдал, шийдвэр гаргах түвшинд ажиллахад эмэгтэй хүнд итгэл хүлээлгэх, дэмжих хандлага, түүний шалтгаан хэрхэн өөрчлөгдсөнийг тодруулан өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан авч үзлээ.


Эрэгтэйчүүд эрэгтэй хүнийг шийдвэр гаргах түвшинд дэмжих хандлага 37.6 хувь болж өмнөх судалгааны үр дүнгээс 20 гаруй хувиар буурсан байна. Харин эсрэгээрээ эмэгтэйчүүд эмэгтэй хүнийг дэмжих хандлага 12 хувиар өсөж 30.9 хувьд хүрчээ (Зураг 3.2.1). Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны хувийн жин нэмэгдэхгүй байгааг “эмэгтэйчүүд нэгнээ дэмждэггүй” гэсэн эрэгтэйчүүдийн хариултыг дээрх үр дүн үгүйсгэж байна.

Эрэгтэй, эмэгтэй улс төрчийн аль алиныг нь дэмжих хандлагатай эрэгтэй оролцогчийн хувийн жин 15 хувиар, харин эмэгтэй оролцогчийн хувийн жин бага зэрэг буурсан дүн харагдаж байна. Эдгээр ялгаа нь статистикийн ач холбогдлын түвшинд илрэв.

Зураг 3.2.1 Эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог дэмжих хандлага, нэгтгэснээр, хүйсээр



Зураг 3.2.2 Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт итгэх байдал, хүйсээр




( $\chi^2 = 39.675, p < .000$ )

Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн

Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт итгэлтэй байна гэж эрэгтэйчүүдийн 87.4 хувь, (2021 онд 80.9 хувь байсан) эмэгтэйчүүдийн 91.7 хувь (2021 онд 87.9 хувь байсан) хариулсан бөгөөд өмнөх судалгаатай харьцуулахад 5-7 хувиар өссөн байна. ФБЯ-аар нийгэм, эдийн засаг, улс төрийн тодорхой салбаруудыг удирдахад эмэгтэйчүүдийн өрөвч зөөлөн, мэдрэмжтэй, энэрэнгүй, уян хатан, өршөөнгүй гэсэн эмэгтэй хүний шинж чанаруудыг аль аль хүйсийнхэн онцлон тэмдэглэжээ. Харин 2021 оны судалгаагаар мэдлэг боловсролтой, шударга, үнэнч, ажил хэрэгч, хариуцлагатай, шийдэмгий, чадвартай зэрэг шинж чанар нь эмэгтэйчүүдэд итгэл үзүүлэх үндэслэл болсныг ганцаарчилсан ярилцлагад оролцсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь илэрхийлжээ.

Матриц 3.2.1 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдэд итгэл үзүүлэх шинж, 2021, 2024



Эх сурвалж: Олон нийтийн асуулгын чанарлаг мэдээлэл

Эх сурвалж: Фокус бүлгийн ярилцлага

Шигтгээ 3.2.1	
ГЯ, эмэгтэй 2021, 47 настай	Их мэдрэмжтэй, чадвартай, хувь хүний хувьд биеэ авч яваа байдал нь үлгэр жишээч.
ГЯ, 2021, эрэгтэй, 34 настай	Зоригтой, шийдэмгий, зөв ярьдаг, даан ч багаа бүрдүүлж чадаагүй, гэхдээ хашир хэрсүү, ярих чадвартай, бодлоготой.
ФБЯ, Орхон аймаг, 2024, эмэгтэйчүүдийн бүлэг	Харилцаан дээр эмэгтэй хүн эелдэг, төлөв даруу байхаас гадна ажилд нягт нямбай, хянамгай, улс орон, хүний төлөө явж чадна.
ФБЯ, Ховд аймаг, 2024, эрэгтэйчүүдийн бүлэг	Эмэгтэй хүн чинь уян хатан, зөөлөн, улс орны төлөө шударга хатуу шийдвэр гаргадаг.

Эрэгтэй хүнд санал өгсөн эрэгтэй хариулагчдын хувийн жин 16.8 хувиар бага, харин эмэгтэй хүнд санал өгсөн эмэгтэйчүүд 66 хувь буюу 2021 оны дүнтэй харьцуулахад 30 гаруй хувиар илүү байна. 2021 оны судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэй ялгаагүй ихэнх нь (66.6-69.6 хувь) эрэгтэй хүнд саналаа өгсөн боловч эмэгтэй хүнд саналаа өгсөн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс бага зэрэг илүү байв. Энэ нь судалгаа явагдсан талбарын тоо нэмэгдэж, зарим аймаг, орон нутаг өөрчлөгдсөнтэй холбоотой тул харьцуулсан дүгнэлт хийх нь учир дутагдалтай.


Адил шинж бүхий нэр дэвшигчээс эмэгтэйчүүдийн 60.6 хувь эмэгтэй хүнийг дэмжсэн байгаа нь өмнөх судалгааны үзүүлэлтээс 3 хувиар өсөж эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэг болохыг дахин илэрхийлж байна.

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дэмжих хандлага 10 гаруй хувиар (2021 онд 28.7 хувиас 2024 онд 40.5 хувь) илүү бол эрэгтэйчүүд эрэгтэйчүүдээ дэмжих хувийн жин 10 гаруй хувиар (2021 онд 71.3 хувиас 2024 онд 59.5 хувь) буурсан байна. Хамаарлын ач холбогдлын түвшнийг тодорхойлж үзэхэд үүнийг баталлаа ( $\chi^2=52.516a$ ,  $p=0.0001$ ). Ерөнхий дүнгээр харвал 2021 онд эрэгтэйг дэмжих хандлага давамгайлсан үр дүн 2024 оны судалгаагаар мөн адил хэвээр байгаа нь эрэгтэйчүүдийн уламжлалт болон жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх




шаардлагатайг харуулж байна.

Зураг 3.2.3 Сонгуульд санал өгсөн байдал, хүйсээр (2020 оны УИХ-ын сонгуульд оролцоогүйг хасаж тооцсоноор)



Зураг 3.2.4 Адил шинж бүхий нэр дэвшигчээс сонгох хандлага, хүйсээр




Статистик ач холбогдлын түвшинд илрээгүй ( $\chi^2=52.516a$ ,  $p=0.0001$ )


Хөрөнгө чинээтэй болон хөрөнгө чинээ бага эрэгтэй, эмэгтэй хүнээс алийг нь сонгох тухай асуухад судалгаанд хамрагдсан оролцогчдын ихэнх нь буюу 53.8 хувь (2021 онд 58.1 хувь) хувь нь хөрөнгө чинээ бага эрэгтэйг харин 56.7 хувь (2021 онд 61.7 хувь) нь хөрөнгө чинээ бага эмэгтэйг сонгожээ. Энэ үзүүлэлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 4-5 хувиар бага байгаа тул хөрөнгөлөг байдлыг чухалчлах төлөв өссөн гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэлээ.

Үүнийг хүйсээр шинжлэхэд 2 судалгаагаар хөрөнгө чинээ багатай эмэгтэйг эрэгтэйчүүд дэмжсэн 55.5 хувиас 56.9 хувь болж бага зэрэг илүү, эмэгтэйчүүдийн дэмжлэг 67.2 хувиас 56.5 хувь болж 10 хувиар буурсан байна. Хөрөнгө багатай эрэгтэйг сонгоно гэж эрэгтэйчүүдийн 60 хувь (2021 онд 38.8 хувь), эмэгтэй оролцогчдын 48.7 хувь (2021 онд 55.3 хувь) дэмжсэнээс харахад эрэгтэй оролцогчид эмэгтэйг бодвол хөрөнгө чинээнд төдийлөн чухал ач холбогдол өгөхгүй байгаа нь илэрлээ.

Зураг 3.2.5 Хөрөнгө багатай эрэгтэй болон баян эмэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар




Зураг 3.2.6 Хөрөнгө багатай эмэгтэй болон баян эрэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар




Сүүлийн 3 жилийн хугацаанд ахмад настай, туршлагатай улс төрч болон шинэ, залуу улс төрч эрэгтэй, эмэгтэй хүнээс алийг нь сонгох олон нийтийн сонголт хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзье.

Шинэ, залуу эмэгтэй улс төрчийг дэмжсэн үзүүлэлт 58.7 хувь болж 16 хувиар өссөн бол ахмад туршлагатай эрэгтэй улс төрчийг дэмжих хувь эсрэгээрээ 41.3 хувь болж 16 хувиар буурснаас харахад шинэ, залуу эмэгтэй улс төрчийг сонгохыг хүсэж байгааг илэрхийлж байна. Үүнийг хүйсээр шинжилбэл, 2021 онд шинэ залуу эмэгтэй улс төрч болон ахмад туршлагатай эрэгтэй улс төрийг сонгох эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн санал 2024 онд бараг өөрчлөгдөөгүй байна. Мөн шинэ, залуу эрэгтэй улс төрч болон ахмад настай туршлагатай эмэгтэй улс төрчийг дэмжих хувь 2021 оноос 2024 он хүртэл төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Гэхдээ залуу эрэгтэй улс төрчийг дэмжих хувь туршлагатай эмэгтэй улс төрчөөс 13 хувиар илүү байна. Үүнээс дүгнэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд судалгаанд оролцогчид хүйсээс үл хамааран шинэ, залуу улс төрчийг сонгохыг илүүд үзэж байна.

Зураг 3.2.7 Шинэ, залуу эмэгтэй улс төрч болон ахмад настай туршлагатай эрэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар



Зураг 3.2.8 Шинэ, залуу эрэгтэй улс төрч болон ахмад настай туршлагатай эмэгтэй улс төрчийг сонгосон байдал, хувиар



2020 оны УИХ-ын сонгуулиар иргэд эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийг яагаад сонгосон шалтгааныг судалж үзвэл 2024 оны судалгаанд оролцогчдын 21 хувь нь мөрийн хөтөлбөр, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа таалагдсан, 15.7 хувь нь шударга, авлигад нэр холбогдоогүй, 10.8 хувь нь залуу шинэ хүн, 9.2 хувь нь орон нутагт их зүйл хийнэ гэж амласан, 8.6 хувь нь өөр сонгохоор хүн байгаагүй гэжээ. Үүнийг хүйсээр харвал эрэгтэй нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн эрэгтэй болон эмэгтэй оролцогчдод ялгаагүй юуны түрүүнд мөрийн хөтөлбөр, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаанд нь үндэслэсэн бол эмэгтэй нэр дэвшигчийг сонгосон эрэгтэй оролцогчид шударга, авлигад нэр холбогдоогүй байдал, эмэгтэй оролцогчид эмэгтэй нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг судалж сонгосноо илэрхийлжээ. Үүнээс дүгнэхэд сонгогчид нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, дэвшүүлсэн зорилт, нэр цэвэр, авлига хээл хахуулийн хэрэгт холбогдоогүй, амласан ажлаа хийх чадвартай, шинэ, залуу хүнийг чухалчлан саналаа өгсөн байна.

Харин 2021 оны судалгаанд оролцогчид эмэгтэйчүүдийн хувь хүний болон институтээс хамаарах шинжүүдийг харгалзан саналаа өгснийг асуулгын судалгааны чанарлаг мэдээллийн үр дүн харуулж байна. Үүнд амьдрал сайн ойлгодог, мэдлэг боловсролтой, шударга, зарчимч, итгэл даах, нэр хүнд цэвэр, ажилсаг, тэвчээртэй, хариуцлагатай зэрэг шинжийг эмэгтэй оролцогчид

чухалчилж, эмэгтэйчүүдийн боловсрол, туршлага, бусдыг ойлгох чадвар өндөр, дайчин, амьдралд ойр, уян хатан, ёс зүйтэй, итгэл даах зэрэг хувь хүний шинжүүдийг эрэгтэй оролцогчид онцолжээ. Харин тойргоо солиогүй, жендэрийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийн төлөөллийг харсан, намын гишүүнчлэл, мөрийн хөтөлбөрийг судалсан гэж институтийн талаас нь эмэгтэйчүүд үзсэн бол эмэгтэйчүүдийн намын гишүүнчлэл, ялангуяа багаар нь дэмжих, хийсэн бүтээсэн туршлага, мөрийн хөтөлбөрийн биелэх бодит байдал зэргийг харах хандлага эрэгтэйчүүдэд илүү давамгайлжээ.

Хүснэгт 3.2.1 УИХ-ын сонгуулиар эрэгтэй болон эмэгтэй нэр дэвшигчдэд саналаа өгсөн үндэслэл, хувиар


Үзүүлэлт	Эрэгтэй нэр дэвшигчийг сонгосон		Эмэгтэй нэр дэвшигчийг сонгосон		Нийт	Эрэмбэ
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй		
Шударга, авлигад нэр холбогдоогүй	28	20	32.7	25.9	15.7	II
Мөрийн хөтөлбөр, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа нь таалагдсан	34.2	36.2	26.9	30.5	21.0	I
Тойрогтоо ажилладаг, хөрөнгө оруулалт, төсөл татчихдаг	14.1	14.6	8.3	9.9	8.1	
Орон нутагт их зүйл хийнэ гэж амласан учраас	13.1	16.9	16	11.1	9.2	IV
Залуу, шинэ хүн	16.6	15.2	19.9	21	10.8	III
Нутгийн хүн, нутаг усаараа мэддэг	9.7	8.4	5.8	9.1	5.4	
Намдаа нөлөөтэй	6.9	6.8	3.2	5.3	3.9	
Хөрөнгө чинээтэй	1.2	0.8	0.6	1.2	0.6	
Эрэгтэй/эмэгтэй хүн	5	4.1	17.3	25.1	6.2	
Өмнө нь нэр дэвшиж байсан, туршлагатай улс төрч учраас	11.4	14.4	7.1	4.9	6.8	
Өмнө нь нэр дэвшиж сонгогдож байсан, туршлагатай улс төрч учраас	5.2	6.6	3.2	4.5	3.4	
Сайн таньдаг, эсвэл найз нөхөд, хамаатны хүн учраас	0.5	1	0	0.4	0.4	
Өөр сонгогчхоор хүн байгаагүй	13.6	17.7	10.3	7.4	8.6	V

Эх сурвалж: ТМЯ, 2024

Шигтгээ 3.2.2	
ГЯ, эмэгтэй 2021, 42 настай	2020 оны сонгуулиар эмэгтэй хүнд саналаа өгсөн. Жендэрийн тэгш байдлыг хангахад анхаарсан. Мөн өмнө нь УИХ-д байгаагүй эмэгтэй хүний хувьд арай шинэлэг санаа, үйлдэл гаргах болов уу гэсэн хүлээлтээр саналаа өгсөн.
ГЯ, 2021, эрэгтэй, 32 настай	Эрэгтэй, эмэгтэй хоёр хүнд өгсөн. Яагаад сонгосон гэвэл орон нутгийн бүтээн байгуулалт аймаг сумын хөгжил дэвшилд нэмэр оруулна гэж бодсон. Мөн мөрийн хөтөлбөр дээр үндэслэн саналаа өгсөн. Манай аймгийн хүмүүс байсан.
ФБЯ, Өвөрхангай аймаг, 2024, эмэгтэйчүүдийн бүлэг	Би сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшсэн хүний тараасан хуудас, сонин материалыг маш сайн уншиж судалдаг. Тэгэхгүй бол энэ хүний талаар яаж мэдээлэл авах билээ. Боловсрол, ажил мэргэжил, хийж байсан ажил төрөл, цаашид хийх ажил гэх мэт маш их мэдээллийг авч, энэ нэр дэвшигчийн талаар ойлголттой болсон. Дараа нь сонголтоо хийсэн.
ФБЯ, Баянгол дүүрэг, 2024, эрэгтэйчүүдийн бүлэг	Сонгуулиар эмэгтэй хүнд саналаа өгсөн. Манай тойрогт боломжийн эмэгтэйчүүд нэр дэвшсэн. Улс орон, орон нутгаа хөгжүүлэх, амьдрал ахуйг дээшлүүлэх байх гэж итгэж сонголтоо хийсэн.

Сүүлийн 3 жилийн хугацаанд олон нийтийн зүгээс улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдэж чадсан гэж нийт ТМЯ-д оролцогчдын 69.3 хувь нь үзсэнийг хүйсээр харвал эмэгтэй улс төрчдийн дийлэнх нь буюу 78.4 хувь, эрэгтэй улс төрчдийн 60 хувь нь эерэг хариулт өгчээ. Судлагдсан эмэгтэй улс төрчдийн дүгнэснээр, олон нийт эмэгтэй улс төрчдөд итгэлтэй байгаа нь ажиглагдлаа. Харин бараг 5 эрэгтэй хүн тутмын нэг нь эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүйг шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн манлайлал сул, оролцоо тааруу байгаагаар тайлбарлалаа.

Зураг 3.2.9 Олон нийтийн зүгээс улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдэж чадсан эсэх, хувиар, 2024



Мөн эмэгтэй улс төрчид УИХ-ын эмэгтэй гишүүдийн манлайлал, нийгэмд эзлэх байр суурь төдийлөн товойж харагдахгүй байгаа, эрэгтэйчүүдийг аялдан дагах хандлагатай, эрэгтэйчүүдийн тоглоомд унадаг, эмэгтэйчүүд өөрийгөө авч явах түвшинд бэлтгэгдээгүй зэрэг өөрсдөөс нь хамаарах шалтгааныг илэрхийлж байна. Эрэгтэй, эмэгтэй улс төрчийн аль аль нь олон нийтийн мэдлэг мэдээлэл,

идэвх оролцоо тааруу байгаа гэж нийгмийн зүгээс учирдаг хүндрэлийг мөн дурджээ. Үүнээс харахад олон нийтийг зохистой мэдээллээр хангах, чадваржуулах шаардлага байна.

Матриц 3.2.2 Олон нийтийн зүгээс шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүй шалтгаан


Эрэгтэйчүүдийн санал	Эмэгтэйчүүдийн санал
<b>Улс төрд эмэгтэйчүүдийн бэлтгэл сул</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтийн зүгээс эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүй байна. Улс төрд манлайлаад явах хүмүүс бэлтгэгдэж чадахгүй байна. Орон нутгийн түвшинд сонгогдсон эмэгтэйчүүд нь тууштай улс төрийн тогоонд ороод явдаггүй.</li> <li>Эмэгтэйчүүдийн оролцоо тааруу.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>УИХ-ын эмэгтэй гишүүдийн манлайлал, нийгэмд эзлэх байр суурь төдийлөн товойж харагдахгүй байна.</li> <li>Эмэгтэйчүүд бие биенээ дэмждэггүй, унагадаг.</li> </ul>
<b>Улс төрд эмэгтэйчүүдийг буруутгадаг</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн ямар нэг асуудал гарахад эмэгтэй гишүүд хаана байна г.м-ээр олон нийт буруутгадаг нь хэвээр байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэй улс төрчдийн үг, үйлдлийг олон нийт маш анхааралтай ажигладаг, буруутгадаг, шүүмжилдэг.</li> </ul>
<b>Эмэгтэйчүүдэд үл итгэдэг</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийдөө эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд ажиллаж чадахгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдийг дорд үзсэн хандлага хэвээрээ байна. Иргэдийн зүгээс эрэгтэй төлөөлөгчдөд илүү найдвар тавиад байх шиг санагддаг.</li> <li>Эмэгтэйчүүд өөрийгөө авч явах түвшний байж чадахгүй байна.</li> </ul>
<b>Олон нийтийн ойлголт тааруу</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Сонгогч руу чиглэсэн мэдлэгжүүлэх, чадваржуулах үйл ажиллагаа хийгдээгүй.</li> <li>Олон нийтийн идэвх оролцоо муудаж байна.</li> <li>Орон нутгийн иргэдийн хандлага өөрчлөгдөхгүй байна.</li> <li>Хүмүүс ойлгох болоогүй байна.</li> <li>Эмэгтэйчүүдийг дэмжих асуудал эрх зүйн хувьд удаашралтай, хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл муу.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтийг сайн бэлдээгүй, мэдлэг мэдээллээр хангаагүй.</li> <li>Иргэдийн жендэрийн ойлголт тааруу хэвээрээ байна.</li> <li>Мэдлэг боловсролтой эмэгтэйчүүдийг эрэгтэй улс төрчдийг дэмждэг шиг дэмждэггүй.</li> </ul>
<b>Эрэгтэйчүүдээс хараат гэж хардаг</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Эрх мэдэл эрчүүдэд байна.</li> <li>Улс төрийн шийдвэрийг эрэгтэйчүүд гаргаж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн намын удирдлагын нөлөөлөл, дэмжлэгээр л гарна.</li> <li>Эрчүүдийг аялдан дагах хандлагатай.</li> <li>Эрчүүдийн тоглоомд унадаг.</li> </ul>
Эх сурвалж: ТМЯ, 2024	

ТМЯ-д оролцсон улс төрч эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн 72.3 хувь нь өнөөдөр Монгол Улсад олон нийтийн зүгээс эмэгтэй улс төрчдийг дэмжих хандлагатай гэж үзсэн нь өмнөх судалгааны дүнгээс 10 гаруй хувиар өссөн байна. Үүнийг хүйсээр авч үзвэл 2024 онд эмэгтэй оролцогчдын 64.7 хувь, эрэгтэй оролцогчдын 80 хувь нь эмэгтэй улс төрчдийг дэмжих хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, 2 судалгаагаар олон нийтийн зүгээс эмэгтэй улс төрчдийг дэмжих хандлага аль

аль хүйсийн хувьд 10 гаруй хувиар өссөн үзүүлэлт ажиглагдлаа.

Харин нэр дэвшээд сурталчилгаагаа хийх явцад эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих олон нийтийн хандлагыг харвал 2024 онд 86 хувь болж өмнөх судалгаанаас 13.7 хувиар илүү, эрэгтэйчүүдийнх 82 хувь болж 4.5 хувиар илүү дэмжсэн байна. Үүнээс харахад эрэгтэйчүүдийг бодвол эмэгтэйчүүдийн дэмжлэгийн хувь харьцангуй илүү байгаа нь эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага өссөнийг харуулж байна.

Зураг 3.2.10 Эмэгтэй нэр дэвшигчийг дэмжих хандлага, хүйсээр



Олон нийтээс эмэгтэй улс төрчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сайшаал магтаал хэлэх, итгэл үзүүлэх, талархал илэрхийлэх, заавар зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, сонгуулийн сурталчилгаанд сайн дураараа ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр дэмжиж байгаа нь 2021, 2024 оны судалгааны үр дүнгээр илэрч байна. Сүүлийн жилүүдэд олон нийт сошиал орчныг ашиглаж эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих нь нэмэгдсэнийг судалгаанд оролцсон улс төрчид илэрхийлж байна.

Аль нэг шатны сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь 10-20 жилийн өмнө эмэгтэй улс төрчийн төлөөх олон нийтийн дэмжлэг тааруу байсан бол харин одоо дэмжлэг харьцангуй сайжирсан бөгөөд эмэгтэйчүүдийн нас, ажлын туршлага, боловсролын түвшин, харилцааны ур чадвар нэмэгдэхийн хэрээр олон нийтээс ирэх дэмжлэг дээшилж байгааг 2 судалгааны ТМЯ-д оролцсон улс төрч эмэгтэйчүүд өгүүлж байна.

Шигтгээ 3.2.4	
ТМЯ, Хан-Уул дүүрэг, 2021, эрэгтэй	10 жилийн өмнө дөнгөж сургуулиа төгссөн үе тул ажлын, улс төрийн ч туршлагагүй байсан. Тэр үед дэмжлэг байгаагүй ээ. Харин одоо бол дүүргийн ИТХ-ын төлөөлөгч гэдэг утгаараа дэмжлэг их болсон. Бүхий л сувгаар дэмжлэг ирж байна. Ялангуяа манай тойрогт бүх төлөөлөгч нарын нэгдсэн групп байдаг түүгээр дэмжлэг их ирдэг.
ТМЯ, Өмнөговь аймаг, 2021, эмэгтэй	20 жилийн өмнө залуу эмэгтэйг үл тоож байсан. Одоо бол харьцангуй дэмжлэг их ирдэг болжээ. Нийт аймгийн хэмжээнд би саналын тоогоороо 3-т орсон. Өнөөдөр намайг нам харгалзахгүй сонгосон гэсэн дүгнэлтийг статистик дээр харж байна.

ТМЯ, Өвөрхангай аймаг, 2024, эмэгтэй	Олон жил доод нэгжээс эхлээд ажиллаж их туршлага хуримтлуулсан гэж боддог. ИТХ-д дараалан 4 удаа сонгогдоод ажиллаж байна. Өнөөдөр шаардлага хангасан эмэгтэйчүүдийг олон нийт сэтгэл харамгүй дэмжиж байна.
ТМЯ, Орхон аймаг, 2024, эрэгтэй	Хэдийгээр уламжлалт хандлага байгаа ч гэсэн жил ирэх тусам эмэгтэйчүүдийг дэмжих хандлага илүү сайжирсаар байгаа. Манай орон нутагт эмэгтэй төлөөлөгчдийн тоо нэмэгдэж байгаа. Эмэгтэйчүүдийг дорд үздэг уламжлалт хандлага багасаж байна.

Эмэгтэй улс төрчийн карьерт олон нийтийн ойлголт, хандлагаас хамаарсан сөрөг хүчин зүйлсийг дурдвал эрэгтэй улс төрчдийн ихэнх нь буюу 62.1 хувь нь эмэгтэй улс төрчийг эрэгтэй улс төрчийн түвшинд бэлтгэгдээгүй гэж үзэх нь эмэгтэйчүүд улс төрд заавал бэлтгэгдэх ёстой гэсэн үзэлтэй эрчүүд давамгайлж байна. Эмэгтэйчүүдийн ихэнх нь (56.8-66.7 хувь) олон нийт эмэгтэй улс төрчийг түрүүлж буруутгаж хатуу ханддаг, дорд үздэг, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс хамааралтай гэж хариулжээ. Харин сонгогчдын мэдлэг боловсрол хангалтгүй гэж эмэгтэйчүүдийн ихэнх нь үзжээ. Иймээс олон нийт рүү чиглэсэн сонгогчийн боловсрол олгох, жендэрийн тэгш эрхийн талаарх мэдлэг мэдээллээр хангах зайлшгүй шаардлага байна.

Зураг 3.2.11 Эмэгтэйчүүдийн улс төрийн карьерт олон нийтийн ойлголтоос хамаарах сөрөг хүчин зүйлс, хувиар, 2024



Эмэгтэй улс төрчийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагаас улбаатай хүндрэл бэрхшээлд уламжлалт хандлага, сонгогчийн боловсрол, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүрэг, эмэгтэйчүүдийн хөрөнгө санхүүгийн чадамж, эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдал, эмэгтэйчүүдэд хандах хандлага зэргийг ТМЯ-д оролцсон эмэгтэй, эрэгтэй улс төрчид илэрхийлсэн байна. Хүндрэлийг нарийвчлан аваад үзвэл өмнөх судалгаагаар илэрч байсан бэрхшээлүүдийг 2024 онд давтан нэрлэсэн.

Матриц 3.2.3 Эмэгтэй улс төрчдөд тулгардаг хүндрэл бэрхшээл

Үзүүлэлт	2021	2024
<b>Уламжлалт соёл</b>	Эрэгтэй хүмүүс төр удирдах ёстой. Эцгийн эрхт ёс давамгайлсан өрөөсгөл хандлага байна.	Жендэрийн хэвшмэл ойлголт Уламжлалт хандлага, зан заншил Олон нийтийн хэвшмэл ойлголт
<b>Сонгогчийн боловсрол</b>	Сонгогчдын боловсрол сул. Иргэд мэдээлэл дутмаг. Жендэрийн мэдлэг тааруу.	Хар PR Сонгогчид мэдээлэл тааруу. Сонгогчид сонголтоо зөв, хариуцлагатай хийх боловсрол сул.
<b>Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүрэг</b>	Хүүхэд төрүүлж эмэгтэй хүнийхээ үүргийг биелүүлэхэд олон нийтийн зүгээс сөргөөр ханддаг. Улс төрд орох цаг завгүй, Эмэгтэй хүн хүүхдээ асарна гэдэг.	Эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх оролцоо муу. Ар гэр, үр хүүхдийн ачаалал их.
<b>Эмэгтэйчүүдийн хөрөнгө санхүүгийн чадамж</b>	Хөрөнгө чинээгээрээ эмэгтэйчүүд сонгуульд ялж чадахгүй. Мөнгөгүй нь сул тал болдог.	Санхүү мөнгөний бэрхшээл тулгардаг. Санхүүгийн далд хүчирхийлэл байдаг.
<b>Гэр бүлийн байдал</b>	Гэр бүлийн зүгээс дургүйцэх хандлагатай. Ар гэр, үр хүүхдээ орхигдуулна.	Ар гэр орхигддог. Гэр бүлийн асуудал, үл ойлголцол Эмэгтэй хүн ар гэрийн ачаалал ихтэй.
<b>Эмэгтэйчүүдийн мэдлэг чадвар, туршлага</b>	Эмэгтэй улс төрчид дээд түвшиндээ сайн ажиллаж чаддаггүй. Идэвх оролцоо муу. Эмэгтэйчүүдэд туршлага дутмаг.	Манлайлах чадвар муу. Танигдаж чадаагүй, хэвлэл мэдээллээр гарч чаддаггүй. Өөртөө итгэлгүй. Хийснээ ярих чадваргүй. Өөрийгөө илэрхийлэх чадвар сул.
<b>Эмэгтэйчүүдэд хандах хандлага</b>	Эмэгтэй улс төрчдөд илүү хатуу ханддаг, шүүмжилдэг. Эмэгтэй улс төрчийн хувийн амьдрал руу өнгийж шүүмжилдэг. Эмэгтэй хүн орон нутгийг удирдах туршлагагүй. Эмэгтэйчүүдийг хэн нэгнээс хараат гэж харддаг. Эмэгтэй улс төрчийн үг яриаг таслах, үл тоох зэргээр ялгаварладаг. Хэвлэл мэдээлэл, нийтийн сүлжээгээр нэр хүндийг нь унагадаг.	Буруутгах хандлага Олон нийтийн итгэл, дэмжлэг сул. Хэн нэгэн даргын хүн гэж харддаг Гадаад дүр төрхийн талаар их хэлэлцдэг. Нам хөөсөн эмэгтэйчүүд гэдэг. Сэтгэл зүйн дарамт, социал орчинд гүтгэдэг. Үл итгэх хандлага Үл ойшоосон хандлага Хов жив хөөцөлддөг.
<b>Нутгийн хүн биш гэх хандлага</b>	Залуу эмэгтэй улс төрч туршлагагүй. Энэ нутгийн хүн биш.	Нутгийн биш хүн гэж гадуурхдаг.

Эх сурвалж: ТМЯ



Судлагдсан улс төрч эмэгтэйчүүд ажлаа сайн хийх, өөрийгөө ойлгуулах, үлгэрлэх, манлайллыг хөгжүүлэх, зөв байх, тууштай, тэвчээртэй, шантаршгүй байх, ар гэрийн дэмжлэг, санхүүгээ сайжруулах, асуудлыг дэврээхгүй ойлголцох, өөртөө итгэлтэй байх, үг ярианы чадвараа сайжруулах, дэмжлэгийн багаа бүрдүүлэх зэргээр улс төрийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг даван туулсан байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд улс төрч эмэгтэйчүүд өөрийн боловсрол, мэдлэг, чадвар, хандлага дээшлүүлэхийн төлөө ажиллаж байгаагаа илэрхийлжээ.

Харин өмнөх судалгаанд хамрагдсан эмэгтэй улс төрчид эдгээр хүндрэл бэрхшээлийг өөрийн мэдлэг боловсрол, сэтгэл зүй, сэтгэлийн хат, шударга ажилч хичээнгүй байдал, зөв үг хэл, үйлдэл, үйл ажиллагаа, ёс зүй, тууштай шийдэмгий байдал, зөв харилцаа хандлага, лобби хэрэглэх, туршлага хуримтлуулах, өөрийгөө зоригжуулах, өмгөөлөх байдлаар даван туулсан гэж хариулжээ.

<b>Шигтгээ 3.2.5</b>	
<i>ТМЯ, Сонгинохайрхан дүүрэг, 2021, эмэгтэй</i>	Намын гишүүн байхдаа улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог. Тэгээд тухайн шатандаа ахиж дэвших үе рүү ороод ирэхээр шүүмжлэгч, дээшээ гаргахгүй, сайн яваагаа дарах ч гэдэг юмуу, эсвэл бүлгүүд шахах зэрэг дарамтад өөрөө ч орж байсан, бусад эмэгтэйчүүдийгээ ч орж байхыг харж байсан. Энэ асуудлыг давахад тэгш харилцаа, хүн бүртэй ойлголцож буулт хийх замаар л давна.
<i>ТМЯ, Дархан-Уул аймаг, 2021, эмэгтэй</i>	Улс төрд орж байгаа эмэгтэй хүн өөртөө итгэлтэй байж, чадна гэдгээ харуулах, өөрөө зорилгодоо хүрэхийн төлөө тууштай байх хэрэгтэй. Цаг хугацааны шалгуураар хүлээцтэй тэвчээртэй байж чадвал амжилтад хүрнэ.
<i>ТМЯ, Орхон аймаг, 2024, эмэгтэй</i>	Миний хувьд манлайллын сүлжээний сургалтад суусан. Тэндээс олон зүйлд суралцсан. Сургалтаас эзэмшсэн арга тактикаа ашиглан заалны гол хэсэгт гарч, хүмүүс рүү харж, заалаа сайн мэдрээд ярьж чадсан.
<i>ТМЯ, Баянгол дүүрэг, 2024, эмэгтэй</i>	Эмэгтэй улс төрчид манлайлах чадвараа хөгжүүлэх, өөрийгөө сайн таниулж, элдэв хор найруулга болон бүлэглэлд орохгүй байх хэрэгтэй.

2 судалгааны ТМЯ-д оролцсон улс төрчдөөс өнөөгийн Монголын эмэгтэй улс төрчдөд буй давуу тал, боломж болон эрсдэлийг тодруулав. Ажил хэрэгч, чамбай, асуудлыг хурцатгахгүйгээр зөөлчилдөг, хүмүүсийн олж хараагүй өнцгийг олж хардаг, амьдрал мэддэг, бусдыг ойлгодог, бүлэг фракц, хуйвалдаанд орох нь бага, зан чанарын төлөвшилтэй, мэдлэг боловсролтой зэрэг эмэгтэй улс төрчдийн хувь хүний зан төлөв, зан үйлийн давуу талыг үзжээ. Харин тэд 2021 оны судалгаагаар авлига авдаггүй, дайчин, хурдтай, зорилготой, үнэнч, буурьтай, зөөлөн, уян хатан, мэдрэмжтэй, амьдралд ойр, цэвэрч нямбай байдлыг дурджээ.

Харин 2021 оны судалгаагаар квотыг баримтлах, намаас дэмжлэг үзүүлэх, төсөв санхүүгийн дэмжлэг, хууль эрх зүйн орчин, хүмүүсийн хүндлэл, 2024 онд квот, жагсаалт зэрэг эрх зүйн шинэчлэлийн үр нөлөө, намын бүтэц, сүлжээ, намын дотоод болон боловсон хүчний бодлого зөв, гэр бүл, ахан дүүсийн болон намын дэмжлэг, эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ, иргэдийн дэмжлэг зэргийг өөрөөс нь үл хамаарах давуу тал гэжээ.

Эндээс дүгнэхэд 2 судалгааны хооронд эмэгтэй улс төрчдийн давуу талууд төдийлөн өөрчлөгдөөгүй байна.

Боловсрол, намын гишүүн, танигдсан байдал, туршлагатай, улс төрийн зориг гаргах, шинэ санаа, олон нийтийн дэмжлэг, нэр цэвэр, мэдрэмж, манлайлал зэргийг эмэгтэй улс төрчдөд байгаа боломж гэж үзжээ. 2021 онд мэдлэг боловсрол, ажил хэрэгч байдал, авлигад автахгүй, квотын арга, нээлттэй байдлыг боломж гэж үзэж байсан байна.

Эрсдэлт хүчин зүйлд гэр бүлдээ бага цаг гаргах, танигдаагүй байдал, санхүүгийн эрсдэл хүлээх, туршлагагүй байдал, гүтгэлэг, стресс, дарамт, хов живд өртөх, эцгийн эрхт ёс, жендэрийн хэвшмэл ойлголт, иргэдийн улс төрийн ухамсрын доройтол, квот бүрэн хэрэгжих эсэх, уламжлалт соёл зэргийг нэрлэжээ. 2021 оны судалгаанд оролцогчид нэр дэвшүүлэх доод түвшин болох квотыг давуу тал, боломж гэж голдуу эрэгтэй оролцогчид үзсэн бол 2024 онд сонгуулийн хууль эрх зүйн шинэтгэл хийсэнтэй холбоотой эмэгтэй улс төрчид квотыг том боломж бололцоо гэж харж байгаагаа олонтоо илэрхийлж байна.

Матриц 3.2.4 Эмэгтэй улс төрчдөд буй давуу тал, боломж болон эрсдэл, 2021, 2024

	Эмэгтэй улс төрчөөс хамаарах	Эмэгтэй улс төрчөөс үл хамаарах
<b>Давуу тал 2021</b>	Асуудлыг олж харах, зөөлөн, уян хатан бусдыг ойлгох, нарийн зүйлсийг маш сайн анхаарч, мэдрэмжтэй ханддаг, ажлыг хойш тавьдаггүй, амьдралд ойр, авлига авдаггүй, дайчин, хурдтай, зорилготой, үнэнч, буурьтай, хор найруулахгүй, бүлэглэл зохион байгуулахгүй, боловсролтой, нарийн нягт нямбай, авлига хээл хахууль авах нь бага.	Квот, намын дэмжлэг, намын нэр хүнд, намын дотоод шинэчлэл, намын бодлого, хууль эрх зүйн орчин, хүмүүсийн хүндлэл
<b>Давуу тал 2024</b>	Ажил хэрэгч, чамбай, асуудлыг хурцатгахгүйгээр зөөлчилдөг, хүмүүсийн олж хараагүй өнцгийг олж хардаг, амьдрал мэддэг, бусдыг ойлгодог, бүлэг фракц, хуйвалдаанд орох нь бага, зан чанарын төлөвшил, мэдлэг боловсрол сайн, нямбай, нэр цэвэр, мэдрэмжтэй, шударга, зарчимч, орон нутагтаа танигдсан, хөдөлмөрч, хүний төлөө тууштай явж чаддаг.	Хууль эрх зүйн орчин, төсөв санхүүгийн дэмжлэг, квот, жагсаалт зэрэг эрх зүйн шинэчлэлийн үр нөлөө, намын бүтэц, сүлжээ, засаглал тогтвортой, намын дотоод болон боловсон хүчний бодлого, гэр бүл, ахан дүүсийн дэмжлэг, намын дэмжлэг, эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээ, иргэдийн дэмжлэг
<b>Боломж 2021</b>	Мэдлэг боловсролтой, багаар ажиллах, ажил хэрэгч, авлигад автахгүй, зоригтой, хариуцлагатай, нээлттэй, квот	Иргэд олон нийтийн дэмжлэг, 30 хувийн квот, ЖЭТБХ тухай хууль
<b>Боломж 2024</b>	Боловсрол, намын гишүүн, танигдсан байдал, туршлагатай, улс төрийн зориг гаргах, шинэ санаа, олон нийтийн дэмжлэг, нэр цэвэр, мэдрэмж, манлайлал	Квот, жагсаалт, намын дэмжлэг, иргэдийн итгэл дэмжлэг, хамтын ажиллагаа, эмэгтэйчүүдийг дэмжих хандлага
<b>Эрсдэл 2021</b>	Гэр бүл орхигдох, санхүүгийн бэрхшээл, ачаалал нэмэгдэх, нөхөн үржихүйн үүргээсээ цаг алдах, сэтгэл зүйн дарамт	Нэр хүндэд халдах, муу хэлүүлэх, хавчигдах, ажлын байрны бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт, гэр бүлийн харилцааны зөрчил

<b>Эрсдэл 2024</b>	Хүүхдийн боловсрол, хүмүүжил орхигдох, гэр бүлдээ бага цаг гаргах, танигдаагүй байдал, санхүүгийн эрсдэл хүлээх, туршлагагүй байдал	Гүтгэлэг, стресс, дарамт, хов живд өртөх, эцгийн эрхт ёс, жендэрийн хэвшмэл ойлголт, иргэдийн улс төрийн ухамсрын доройтол, квот бүрэн хэрэгжих эсэх, уламжлалт соёл сэтгэлгээ
Эх сурвалж: ТМЯ		

2 судалгааны чанарын мэдээллийг шинжлэхэд улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэхийн тулд сонгуулийг шударга явуулах, эмэгтэй улс төрчдөө хөрөнгө санхүүгээр дэмжих, нийгмийн хандлагыг өөрчлөх, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, намын санхүүжилтээс эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй адил хуваарилах, намын бодлогыг өөрчлөх, эмэгтэй хүнд нэр дэвших боломжийг бүрдүүлэх, ард иргэдийн саналыг мөнгөөр авах оролдлогыг хаах, эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлж бодитоор хуулийн дагуу хэрэгжүүлэхийг санал болголоо.

## Дүгнэлт

- Эрэгтэй оролцогчдын хувьд эрэгтэй улс төрчийг дэмжих хандлага нь өмнөх судалгаатай харьцуулахад буурч, харин эрэгтэй, эмэгтэй улс төрчийг аль алиныг нь дэмжих болон эмэгтэй улс төрчийг дэмжих хандлага өссөн байна.
- Эмэгтэй оролцогчдын хувьд эмэгтэй хүнийг дэмжих хандлага өсөж, эрэгтэй улс төрчийг дэмжих хандлага буурсан байна. Хүйсээр шинжилсэн ялгаа 2021 оны судалгааны үр дүнтэй адилаар статистикийн ач холбогдлын түвшинд илэрлээ.
- Эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэсэн дүн эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын дийлэнх олонх нь буюу 87.4- 91.7 хувь болж ойролцоогоор 5-7 хувиар өссөн байна.
- Өмнө судалгаанд судлагдсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн ихэнх нь (66.6-69.6 хувь) эрэгтэй хүнд саналаа өгсөн боловч эмэгтэй хүнд саналаа өгсөн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс бага зэрэг илүү байсан бол энэ удаагийн судалгаанд оролцсон эрэгтэй хүнд санал өгсөн нь 2021 онтой харьцуулахад бага, эмэгтэй улс төрчид саналаа өгсөн оролцогчдын хувийн жин өндөр байгаа нь судалгаа явагдсан орон нутаг өөрчлөгдсөнтэй холбоотой. Ямар хүйсийн нэр дэвшигчид саналаа өгснийг хүйсээр шинжлэхэд эмэгтэй сонгогчид эмэгтэй нэр дэвшигчдийг сонгосон нь өндөр илэрлээ.
- Адил шинж бүхий нэр дэвшигч эмэгтэйчүүдийн ихэнх нь эмэгтэй хүнийг дэмжсэн өмнөх судалгааны үзүүлэлт өссөн байгаа нь эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага хэвээр байгааг харууллаа.
- Хөрөнгө багатай хүнийг дэмжих явдал өмнөх судалгаанаас харьцангуй буурах (4-5 хувь) хандлагатай болж хөрөнгө мөнгийг чухалчлах төлөв байна. Ялангуяа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол илүү хөрөнгө мөнгөний хүчин зүйлд ач холбогдол өгч байна.
- Шинэ, залуу эмэгтэй улс төрчийг дэмжсэн хувь 2021 оны судалгаанаас

16 хувиар, шинэ, залуу эрэгтэй улс төрчийг дэмжсэн хувь 2 орчим хувь өссөнөөс харахад залуу улс төрчийг, ялангуяа залуу эмэгтэй улс төрчийг сонгох хандлагатай байна.


- Сүүлийн 3 жилийн хугацаанд олон нийтийн зүгээс улс төрд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдэж чадсан гэж эмэгтэй улс төрчдийн дийлэнх нь өөдрөг, итгэлтэй байгааг илтгэх дүр зураг ажиглагдлаа. Харин бараг 5 эрэгтэй хүн тутмын нэг нь эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүй гэж үзэхдээ шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тууштай манлайлал сул, оролцоо тааруу байгаагаар тайлбарлаж байна.
- Судалгаанд оролцсон улс төрчдийн олонх нь сонгогчийн боловсрол хангалтгүй, олон нийт эмэгтэй улс төрчдөд илүү хатуу ханддаг, олон нийт эмэгтэй улс төрчийг түрүүлж буруутгадаг нь эмэгтэйн улс төрчдийн карьерт илүүтэй нөлөөлдөг сөрөг хүчин зүйлс гэж дүгнэж байна. Сонгуулийн хууль эрх зүйн шинэтгэл хийсэнтэй холбоотой эмэгтэй улс төрчид хүйсийн квотын хувь нэмэгдсэн болон жагсаалтыг “боломж” гэж харж байна.
- Аль нэг шатны сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь 10-20 жилийн өмнөх үетэй харьцуулахад олон нийтийн дэмжлэг харьцангуй сайжирсныг тэмдэглэж байна. Гэхдээ эмэгтэй улс төрчийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага, хэвшмэл ойлголт, сонгогчийн боловсрол, эмэгтэйчүүдийн хөрөнгө санхүүгийн чадамж, эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдал, эмэгтэйчүүдэд хандах хандлагатай холбоотой хүндрэл бэрхшээлүүдийг судлагдсан эмэгтэй болон эрэгтэй улс төрчид илэрхийлжээ.

### **3.3 Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл, нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх үзэл бодол**

“УИХ-ын 76 гишүүний 17 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа”-г оролцогчдын 50.2 хувь нь хангалтгүй, 31.3 хувь нь боломжийн, 18.5 хувь нь хангалттай гэж дүгнэжээ.

Өмнөх судалгааны адилаар судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь хангалтгүй гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь боломжийн, хангалттай гэж үзсэн бөгөөд төлөөллийн бодит байдлыг дүгнэх үнэлгээ хүйсээс хамаарч ( $\chi^2 = 22.329$ ,  $p < .000$ ) байгаа нь дахин ажиглагдав. Гэхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй гэж үзсэн хувь 8 хувиар, эрэгтэй, эмэгтэй оролцогчдын аль алиных нь хувьд хангалтгүй гэж үзсэн хариулт тус бүр 8 хувиар өссөн байна. Энэ нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх хэвшмэл үзэл буурч байгааг нотлох юм.

Зураг 3.3.1 УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх сэтгэгдэл, хүйсээр болон хувиар



Асуулгын судалгааны дүн, 2021, 2024

УИХ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 17 хувийг эзэлж байгааг “хангалтгүй” гэж хариулсан оролцогчдоос үүний шалтгааныг өмнөх судалгааны адилаар тодруулав. Өмнөх судалгааны дүн давтагдсан бөгөөд 133.4 хувь нь эрэгтэйчүүд давамгайлсан бүтэц, соёлын хүчин зүйлийг гол шалтгаан гэжээ. 2021 оны судалгаанд оролцогчдын 136.2 хувь (давхардсан тоогоор) эцгийн эрхт ёсны бүтэц, соёлтой холбоотой хүчин зүйлсийг гол шалтгаан гэж үзсэн. Тэр дундаа 30.7 хувь хувь нь улс төрийн намын эрх мэдлийн эрэгтэйчүүдэд төвлөрсөн байдал, 24.9 хувь нь хууль, эрх зүйн орчны дэмжлэг сул байдал, 22.9 хувь нь улс төрийн намын эмэгтэйчүүдийг үл дэмжсэн дотоод бүтэц, соёлыг парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн үндсэн шалтгаан гэж үзжээ. 2024 оны судалгаанд оролцогчдын 75.2 хувь нь улс төрийн нам дахь эцгийн эрхт бүтцийг гол шалтгаан гэж үзсэнийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргийн ачаалалтай холбон тайлбарласан оролцогчид тавны нэг хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх судалгаагаар гуравны нэг хувийг эзэлж байсан байна (Хүснэгт 3.3.1).

Судалгаанд оролцогчдын хувьд УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй байгаагийн шалтгааныг тайлбарлахдаа 48.6 хувь (давхардсан тоогоор) нь эцгийн эрхт ёсны бүтэц, соёлоо дэмжсэн, зөвтгөсөн хариулт өгсөн байна. Ийм хариултыг 2021 оны судалгаанд оролцогчдын 118.3 хувь (давхардсан тоогоор) нь өгсөнтэй харьцуулахад 2.4 дахин буурчээ. Ийм хариултыг сонгосон оролцогчид эмэгтэй хүн улс төрд хангалттай хатуу, шийдэмгий, зоригтой байж чаддаггүй, эрэгтэй улс төрдөөс хамааралтай, цөөн эмэгтэйчүүд туршлагатай гэсэн хариултыг илүүтэй сонгожээ. Энэ нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал олон нийтийн хандлага болж чадаагүй болохыг харуулах юм.

Сонгогчидтой холбоотой хүчин зүйлстэй холбон үзсэн оролцогчид 75.9 хувийг эзэлж байна. Тодруулбал, сонгогчдын боловсрол дутмаг гэж 26.4 хувь, сонгогчид эмэгтэй улс төрчийг өндөр албан тушаалд сонгоход бэлэн бус гэж 24.9 хувь, олон нийтийн жендэрийн хэвшмэл ойлголт саад болдог гэж 24.6 хувь нь хариулжээ. Үүнээс үзэхэд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангагдахгүй байгаагийн шалтгааныг нийгмийн бүтэц, улс төрийн намын дотоод бүтэц, соёл, сонгогчдын ойлголт, хандлагатай холбон тайлбарлах нь 2021-2023 оны хооронд нэлээд өсжээ. Гэхдээ судалгаанд оролцогчдын 50 орчим хувьд төлөөллийн түвшнийг хангалтгүй гэсэн атлаа эрэгтэйчүүдийг дөвийлгөх хандлага байсаар байгааг анхаарах нь зүйтэй. Эрэгтэйчүүдийг дөвийлгөсөн хариултыг хүйсээр

шинжлэн үзвэл эрэгтэй оролцогчдын 21.7 хувь, эмэгтэй оролцогчдын 15.9 хувь нь ийм хариулт өгсөн бөгөөд “эрэгтэйчүүд удирдах ажилд ямагт илүү байдаг” гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр, эмэгтэй улс төрчид дорвитой зүйл хийж чадахгүй гэж хариулагчдын хувийн жин эрэгтэйчүүдтэй адил жин дарж байна.

Хүснэгт 3.3.1 УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн шалтгааны талаарх үзэл бодол

Үндэслэл	Тоо	100 хувьд тооцсон хувь	Олон сонголтоор тооцсон хувь
<b>Нийгмийн бүтцийн шалтгаанаар тайлбарласан</b>	<b>805</b>	<b>51.6</b>	<b>133.7</b>
Эмэгтэйчүүдийн гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, ачаалал нь улс төрд оролцох цаг зав гаргадаггүй.	125	8.0	20.8
Улс төрийн намын гол эрх мэдэл нь эрэгтэйчүүдэд байдаг.	185	11.9	30.7
Хууль, эрх зүйн орчны дэмжлэг сул.	150	9.6	24.9
Эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн адил зарцуулах их хэмжээний мөнгө байхгүй.	52	3.3	8.6
Улс төрийн намууд дотоод бүтэц, соёлоороо эмэгтэй улс төрчийг дэмжих орчныг бүрдүүлэхгүй байна.	138	8.9	22.9
Улс төрийн нам баян чинээлэг эрэгтэйчүүдийн санхүүжилтээс хамааралтай байна.	83	5.3	13.8
Улс төрийн намын удирдлага эмэгтэйчүүд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүн г.м нийгмийн бүлгийн төлөөллийг хангахын төлөө ажиллах хүсэл зориг сул.	47	3.0	7.8
Эмэгтэй улс төрчдийн талаар хэвлэлээр саар зүйл л яригддаг.	25	1.6	4.2
<b>Эрэгтэйчүүдийг давууд үзсэн</b>	<b>293</b>	<b>18.8</b>	<b>48.6</b>
Эмэгтэйчүүд улс төрд хангалттай хатуу, шийдэмгий, зоригтой байж чаддаггүй.	70	4.5	11.6
Улс төрд идэвхтэй оролцдог эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс ихээхэн хамааралтай байдаг.	64	4.1	10.6
Эмэгтэй улс төрчид дорвитой зүйл хийж чадахгүй байгаа тул эрэгтэйг нь илүүд үздэг.	35	2.2	5.8
Цөөн тооны эмэгтэйчүүд л өндөр албан тушаалд туршлагатай байдаг.	56	3.6	9.3
Эмэгтэйчүүд амьдралын бүхий л зүйлд илүү ачаалалтай тул улс төрийн ажлыг эрэгтэйчүүд хийх нь зөв.	30	1.9	5.0
Эрэгтэйчүүд удирдах ажилд ямагт илүү байдаг.	20	1.3	3.3
Эрэгтэйчүүд хөрөнгө чинээтэй, хэнээс ч хамааралгүй.	18	1.2	3.0
<b>Сонгогчидтой холбоотой хүчин зүйлс</b>	<b>457</b>	<b>29.3</b>	<b>75.9</b>
Сонгогчид эмэгтэйчүүдийг өндөр албан тушаалд сонгоход бэлэн биш.	150	9.6	24.9
Сонгогчдын боловсрол хангалтгүй.	159	10.2	26.4
Олон нийтийн жендэрийн хэвшмэл ойлголт саад болдог.	148	9.5	24.6

Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2024

Матриц 3.3.1-ээс харахад 2021 оны судалгааны дүнг бараг ижил байдлаар давтаж байгаа бөгөөд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай бус байгаагийн шалтгааныг ФБЯ-ын эрэгтэй оролцогчид дараах хүчин зүйлстэй холбон тайлбарлаж байна. Насны бүлгүүдийн хувьд бага зэрэг ялгаа ажиглагдлаа. Үүнд:

- **Эмэгтэй хүнийг буруутгасан.** Эрэгтэй улс төрчийн адил байж чадахгүй байна, зөөлдөж байна, шийдэмгий бус, ухаалаг бус, авлигад өртөхгүй байж чадахгүй байна, хүлээлтэд нийцэх эмэгтэй улс төрчид гарахгүй байна, боловсрол дутмаг байна, зоримог дуугарч чадахгүй байна гэх мэт яриа бүхий л насны эрэгтэйчүүдийн бүлгийн ярилцлагын үеэр яригджээ.
- **УТН дахь эрх мэдлийн бүтэц.** Энэ санаа бүхий л насны эрэгтэйчүүдийн “улс төрийн нам, эвсэл нь дэмжихгүй байна, нэр дэвшүүлэхгүй байна, дарга нар нь эрэгтэйчүүд байдаг” гэх мэт яриагаар илэрч байв.
- **Дүр үүргийн хүчин зүйлс (нийгмийн бүтцийн).** Үр хүүхдээ өсгөх, гэрийн ажилтай тул гэсэн үндэслэлээр залуу болон дунд насны эрэгтэйчүүд тайлбарлав.
- **Эмэгтэйчүүд л хийж чаддаг, ажлын ачаалал их.** Эмэгтэйчүүд хүүхдээ өсгөх, гэрээ харах гэх мэт яг эмэгтэй хүмүүс л хийж чадах ажлууд их байдаг гэж залуу эрэгтэйчүүд тайлбарлажээ.
- **Сонгогчийн хүчин зүйлс.** Мэдээлэл дутмаг, эмэгтэй улс төрчид байхгүй, цөөн байдаг нь сонгогч сонгохгүй байхад хүргэж байна гэж залуу болон дунд насны эрэгтэйчүүд ярилцлагын үеэр дурджээ.

ФБЯ-аас жендэрийн хэвшмэл үзлээр хандах байдал наснаас төдийлөн хамаарахгүй байгаа нь ажиглагдав. Бүхий л насныхан нэг талаас жендэрийн эрх мэдлийн бүтэц, соёлтой холбон тайлбарлах атлаа нөгөө талаас эмэгтэйчүүдийг өөрсдийг нь буруутгаж, үл итгэсэн яриа газарзүйн байршил ялгаагүйгээр, ажил мэргэжил, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, угсаатны харьяаллаас үл хамааран зэрэгцэн оршиж байна.

Матриц 3.3.1 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эрэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар

Залуу нас	Дунд нас	Ахмад нас
<b>Эмэгтэй хүнийг буруутгасан</b>		
Эмэгтэйчүүд зөөлддөг Нөлөөлөлд автдаг Зоригтой бус Эрэгтэй улс төрч шиг биш	Ухаалаг эмэгтэй цөөн Ард түмнээ доромжилдог, Авлигад адилхан холбогддог	Зүтгэх чадвар дутмаг Бэлтгэл дутмаг, чадвар дутмаг эмэгтэйчүүд улс төрд байна
<b>Дүр-үүргийн хүчин зүйлс</b>		
Эмэгтэй хүмүүс л хийж чадах ажлуудынх нь ачаалал их	Эмэгтэйчүүдийн хэвшмэл үзэл	
<b>УТН дахь эрх мэдлийн бүтцийн хүчин зүйлс</b>		
Нам, эвсэл эмэгтэйчүүдээ дэмждэггүй	Намаас нь дардаг. Нам дотоодод эмэгтэйчүүдийн оролцоо сул Дарга нар нь эрчүүд Квотын хяналт үгүй	Нэр дэвшүүлдэггүй Сонгуулийн хуулиа шинэчлэх хэрэгтэй

Сонгогчийн хүчин зүйлс		
Эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл хомс Эмэгтэй хүн шийдвэр гаргах талдаа сул гэж гэж боддог	Эмэгтэй ерөнхийлөгч, ерөнхий сайдтай байгаагүй тул сонгодоггүй	
Эх сурвалж: ФБЯ, 2024		

Матриц 3.3.2-оос харахад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай бус байгаагийн шалтгааныг ФБЯ-ын эмэгтэй оролцогчид 8 төрлийн хүчин зүйлстэй холбон тайлбарласнаараа эрэгтэйчүүдээс ялгаатай байна. Насны бүлгүүдийн хувьд бага зэрэг ялгаа ажиглагдлаа. Гэхдээ өмнөх судалгаа болон эрэгтэйчүүдийн яриатай хэд, хэдэн санаагаар давхцаж байна. Үүнд:

- **УТН дахь эрх мэдлийн бүтэц.** Энэхүү санаа бүхий л насны эмэгтэйчүүдийн “улс төрийн нам, эвсэл нь эмэгтэйчүүдээ дараад байна, чадалтай эмэгтэйчүүдийг дэмжихгүй байна, удирдлагатайгаа санал зөрсөн эмэгтэйг дэмждэггүй” гэх мэт яриагаар илэрч байв. Эрэгтэйчүүдийн ярианд дурдагдаагүй нэг зүйл бол удирдлагатай санал зөрөх буюу олон ургалч байдал дэмжигдэхгүй намын дотоод орчин (дээрээс доош чиглэсэн бюрократ бүтэц бүхий) нь эмэгтэйчүүдийг улс төрд тууштай оролцож, өндөр албан тушаалд хүрэхэд саад учруулж байна гэжээ.
- **Эмэгтэй хүнийг буруутгасан.** Илтгэх болон шийдвэр гаргах чадвар сул, алсын хараатай биш, эрэгтэй хүмүүсээр удирдуулах уу гэж үл итгэсэн нэг хэсэг байсны зэрэгцээ одоо байгаа эмэгтэй улс төрчид юу хийж байна, бидний итгэлийг дааж чадахгүй байна гэж үзсэн шүүмжлэгч хэсэг байна. Мөн бие биеэ дэмждэггүй, атаархуу, багаар ажиллаж чаддаггүй, нэгдэж чаддаггүй гэсэн сул талыг онцгойлон дурдагсад бас байна.
- **Эмэгтэйчүүдийн өөртөө итгэлгүй байдал.** Бүх насны зарим оролцогч эмэгтэй хүн улс төрийн үйл ажиллагааг эрэгтэй хүнийх гэж хардаг, эрэгтэй улс төрч шиг байж чадахгүй байх гэсэн өөртөө итгэлгүй байдлаасаа улс төрд оролцдоггүй гэж тайлбарлаж байв.
- **Дүр үүргийн хүчин зүйлс.** Ар гэрийн ачаалал, гэр бүл, үр хүүхдээ бодлогоос тууштайгаар улс төрд оролцоотой байж чаддаггүй хэмээн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд тайлбарлаж байв.
- **Бохир улс төр.** Эмэгтэйчүүд хэл амнаас айдаг, зоригтой тууштай байж чаддаггүй, сэтгэл зүйн дарамтыг дийлж чадахгүйгээс улс төрөөс дайждаг гэж залуу болон дунд насны эмэгтэйчүүд дүгнэв.
- **Сонгогчийн хүчин зүйлс.** Эмэгтэй улс төрчийг дуу хоолойгоо илэрхийлж чадах уу гэж хүмүүс эргэлзэж ханддаг, эмэгтэй хүний саналыг доогуур үнэлдэг, эмэгтэйчүүдийг хэл аманд их оруулдаг гэжээ.
- **Эмэгтэйчүүд өөрийгөө дөвийлгөх, илэрхийлэх байдал дутмаг.** Эмэгтэйчүүд гүйцэтгэсэн ажил, олсон амжилтаа илтгэж харуулдаггүй, олны танил болоогүй, нүднээс далд байлгадаг зэрэг олон нийт, удирдлагатай харилцах харилцаанд гаргадаг алдаа, сургамж нь шийдвэр гаргах түвшинд ажиллахад нь саад болж байна гэжээ.
- **Сонгуулийн ээлгүй тогтолцоо.** Сонгуулийн тогтолцоо, том тойрог нь эмэгтэйчүүдийг гарч ирэхэд саад болно гэж үзэж байна.



Эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлагын үеэр эмэгтэйчүүдэд тулгардаг саад бэрхшээлийг илүү дэлгэрэнгүйгээр нарийвчилж танилцуулав. ФБЯ-д эмэгтэйчүүдэд үл итгэх гэхээсээ эмэгтэйчүүдэд учирч буй нийгмийн бүтэц, соёлтой холбогдох саад бэрхшээлийн талаар илүүтэй өгүүлжээ. Ялангуяа залуу болон дунд насны эмэгтэйчүүдийн ярианд өөрчлөлт хийх, сайжруулахад чиглэсэн саналуудыг дурдсан байна.

Матриц 3.3.2 Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эмэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар

Залуу нас	Дунд нас	Ахмад нас
<b>УТН дахь эрх мэдлийн бүтэц</b>		
УТН дэвшүүлдэггүй Эмэгтэйчүүдээ дэмждэггүй.	Эмэгтэйчүүдээ дэмждэггүй Эмэгтэйчүүдэд квот олддоггүй. Чадалтай эмэгтэйчүүдийг гаргадаггүй байх. Эрх мэдэлтэй эрэгтэйчүүдээс дэмжлэг авч чаддаггүй Тэмцэл сул.	Эмэгтэйчүүдээ дэмждэггүй. Хатуу, төв, зоригтой, шаргуу бол дэмжигдэхгүй.
<b>Эмэгтэй хүнийг буруутгасан</b>		
Эрчүүд удирдуулахгүй байх. Одоо байгаа эмэгтэйчүүд ажиллахгүй байна. Шийдвэр гаргах чадвар муу.	Илтгэх чадвар, улс төрч байх шинж, алсыг харах чадвар муу. Одоо байгаа эмэгтэйчүүд ажиллахгүй байна. Зарим эмэгтэй улс төрч нэр хүндийг нь унагадаг.	Эмэгтэйчүүд хэт олон байвал эвгүй 70:30 хувьтай байвал зохимжтой. Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэггүй, атаархуу. Одоо байгаа эмэгтэйчүүд ажиллахгүй байна.
<b>Дүр үүргийн хүчин зүйлс</b>		
Жендэрийн хэвшмэл ойлголт. Эрэгтэй хүн даргын алба хашдаг тул би чадахгүй, би сонгогдохгүй гэж боддог .	Эмэгтэй хүнээр удирдуулж үзээгүй болохоор иргэд сайн мэдэхгүй.	Эрэгтэй хүнийг бүх л салбарт тэргүүн гэж үзэж байна.
Ар гэрийн ачаалал Хувийн амьдралаа бодсоор улс төрөөр тууштай байж чаддаггүй.	Нэр дэвшиж өрсөлдөх идэвх тааруу. Ар гэрийн ачаалал.	
<b>Эмэгтэйчүүдийн өөртөө итгэлгүй байдал</b>		
Сэтгэл зүйн дарамт их Хэл амнаас айдаг, шантардаг учраас.	Бүх юмаа хаяад золиослох зориг дутмаг. Тууштай бус.	
<b>Сонгогчийн хүчин зүйлс</b>		
Сонгогчдын ухамсраас хамаарч байна. Хүмүүс эргэлздэг Эмэгтэй хүний саналыг доогуур үнэлдэг, шүүмжилдэг.	Эрэгтэй хүн удирдаж чадна гэж итгэдэг. Шүүмжилдэг. Улс төрийн боловсролд анхаарахгүй байна.	
<b>Эмэгтэйчүүдийн олон нийттэй харилцах хүчин зүйлс</b>		
Эмэгтэй хүн хийж байгаа. зүйлээ нүдэнд харуулдаггүй.	Олны танил болоогүй. Эмэгтэйчүүд их даруухан.	

<b>Сонгуулийн тогтолцоо</b>	
	Эмэгтэйчүүдэд ээлгүй тогтолцоо, том тойрог эрсдэлтэй.

Олон улсын хэмжээнд хийгдсэн зарим судалгаанд сонгуульд амжилттай оролцоход нөлөөлөх хувийн хүчин зүйлсийг зан чанар, гадаад төрх, бие бялдрын, мэдлэг боловсрол, хөрөнгө санхүүгийн гэсэн дөрвөн хүрээнд судалсныг энэхүү судалгаанд дахин ашиглав. Сонгуульд ялалт байгуулахад хүргэсэн, зан чанар, гадаад төрх, мэдлэг боловсрол, хөрөнгө санхүүгийн давуу талыг ялалт байгуулж байсан улс төрч эрэгтэй, эмэгтэйчүүдээс тодруулав. Тэдний дунд сонгуульд ялалт байгуулахад хувийн зан чанар, мэдлэг боловсролын туршлагын давуу талыг илүүтэй онцлон тэмдэглэж байв. Хувийн зан чанарын хувьд харилцааны ур чадвар, хувийн зохион байгуулалттай, сахилга баттай, үнэнч, шударга ёсыг дээдэлдэг байдлаа сонгуульд ялалт байгуулахад эергээр нөлөөлсөн гэж үзжээ.

Гадаад дүр төрх, бие бялдрын хүчин зүйлсийн хувьд “чухал биш, нөлөөлөөгүй” гэсэн хариулт нэлээд байсан ч, өндөр жингийн тохирсон байдал, “спортлог” буюу биеийн тамираар хичээллэдэг байхыг эрэгтэй, эмэгтэй улс төрчид хоёул, харин гадаад байдал, өнгө үзэмж, хувцаслалт, үсний засалтдаа анхаардаг хэмээн эмэгтэй улс төрчид илэрхийлсэн болно.

Мэдлэг боловсролын хувьд давуу талтай гэдгээ томоохон сонгуульд ялалт байгуулагчдын хувьд гол онцлог гэж онцолж байлаа. Мөн багш, эмч, хуульч, банк, санхүүгийн ажилтан зэрэг олон нийтэд үйлчилдэг ажил мэргэжилтэй, олон нийтэд тусалдаг, хүмүүнлэгийн ажил зохион байгуулснаа давуу тал хэмээн онцолсон нэлээд тооны эрэгтэй, эмэгтэй улс төрчид байв.

ИНХ, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хувьд зардал бага тул хөрөнгө санхүү нөлөөлөөгүй, иргэдтэйгээ адил түвшинд тул чухал үүрэг гүйцэтгээгүй гэж хариулж байсан бол дүүрэг, аймаг, Нийслэл болон УИХ-ын хувьд сонгуулийн зардлаа өөрөө даадаг байх, олон хүн ажлын байраар хангаж байсан зэргээ үндэслэж эерэг нөлөөтэй болохыг хүлээн зөвшөөрч байв.

Бодит байдалд хөрөнгө чинээ чухал үүрэгтэй байгаа ч “сонгуульд ялахад “хөрөнгө чинээ чухал үүрэгтэй байсан” хэмээн шууд дүгнэх улс төрчид бараг таарсангүй. Мөн сонгуулийн зардал өсдөг учраас дараагийн шатны сонгуульд өрсөлдөхөөс татгалздаг тохиолдол орон нутгийн улс төрчдийн дунд цөөн бус байв. Сонгуулийн зардлаас гадна тойргийн дэмжигчдэд (намын гишүүдэд) сонгуулийн бус үеэр ч мөнгө зарцуулах чадавхтай байсан нь сонгогдоход давуу тал болсон гэдгээ орон нутгийн бүх нэгжид гишүүнчлэл бүхий намын улс төрчдөөс дурдаж байв.

Орон нутгийн хүчин зүйлс чухал нөлөөтэй байгаагүй гэж зарим хэсэг дүгнэсэн хэдий ч а) Тухайн нутагтаа төрж өсөж, амьдран сууж байгаа, б) Тэр нутагт төрж өсөөгүй ч олон жил ажилласан, в) Тэр нутагтаа төрсөн, амьдран суудаггүй ч ах дүүс, найз нөхөд олонтой, олон хүн ажлын байраар хангадаг зэрэг нийгмийн сүлжээ чухал үүрэгтэй байсныг дийлэнх хэсэг онцлон дурдсан. Судалгаанд оролцогч улс төрчид ялалтын давуу талаа цогцоор харж буй тал хэсэг, зарим хүчин зүйлсийг орхигдуулдаг, анхаардаггүй гэсэн хоёр хэсэгт хуваагдаж байна.

Матриц 3.3.3 Сонгуульд ялахад хүргэсэн хүчин зүйлс, эмэгтэй оролцогчдын өгсөн хариултаар

Хувийн зан чанарын хүчин зүйлс	Гадаад төрх, бие бялдрын хүчин зүйлс	Мэдлэг боловсролын хүчин зүйлс	Хөрөнгө санхүүгийн байдал	Нутаг ус, танил тал
<ul style="list-style-type: none"> <li>Харилцаа сайтай</li> <li>Багшилж байсан тул</li> <li>Нийтэч, нээлттэй</li> <li>Хувийн зохион байгуулалт сайтай</li> <li>Сахилга бат сайтай</li> <li>Мэдээлэл сайтай, мэдээлэл түгээдэг</li> <li>Хүнийг хүндэтгэдэг</li> <li>Тууштай</li> <li>Шударга ёсыг эрхэмлэдэг</li> <li>Үнэнч</li> <li>Иргэдтэйгээ ойр байдаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цэвэрч, нямбай</li> <li>Эрүүл харагддаг, өндөр, жин тохирсон</li> <li>Хувцаслалт төв, албаны, дээл өмссөн</li> <li>Ажил хэрэгч, зарчимч имиж бүрдүүлсэн</li> <li>Гоё, ганган хувцасладаг</li> <li>Нүдэнд дулаахан, зөөлөн харцтай, инээмсэглэсэн</li> <li>Спортлог буюу биеийн тамираар хичээллэдэг</li> <li>Үсээ тайруулсан, үсний нэг төрхөө хадгалж байгаа</li> <li>Энгийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өндөр боловсролтой</li> <li>Гадаадад сурч төгссөн</li> <li>Дээд боловсролтой</li> <li>Хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн</li> <li>Доктор, магистрын зэрэгтэй</li> <li>Англи, орос хэлтэй</li> <li>Багш, эмч, хуульч, банкны ажилтан, инженерээр олон жил ажилласан</li> <li>Их, дээд сургуульд багшилж байсан</li> <li>Олон нийтийн төлөө ажилладаг</li> <li>Орон нутагтаа сурлагатай гэдгээрээ алдартай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гэр бүлийн болон хувийн бизнестэй</li> <li>Сонгуулийн зардлаа болон тойргийн дэмжигчдэд мөнгө зарцуулах чадамжтай</li> <li>Орон нутаг бага зардалтай</li> <li>Дундаж гэдгээрээ дэмжигдсэн</li> <li>Зардал ихсэх тул дээд шатны сонгуульд нэр дэвшихээс татгалзсан</li> <li>Адуугаараа болгож байгаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нутагтаа дэвшсэн</li> <li>Ах дүү, хамаатан садан, найз нөхөд бүгд бий</li> <li>Олон жил ажилласан</li> <li>Олон хүнийг ажлын байраар хангасан</li> </ul>

Эх сурвалж: ТМЯ, 2024

ТМЯ-д оролцсон эрэгтэй, эмэгтэй улс төрчдийн өгсөн хариултаар хүйсийн хувьд ялгаа бага ажиглагдсан ч, хувийн зан чанарын талаас өөртөө итгэл муутай, сулбагар, олон нийттэй харилцаж сураагүй, өөрийн хүрээллээс гараагүй, биеийн хэлэмжээ тооцоогүй, үнэнч, шударга, хэт залуу гэж тооцогдсон зэргийг дурджээ.

Гадаад дүр төрх бүрдүүлэлт талаас сул тал байгаагүй гэж бараг бүгд хариулсан бөгөөд зөвхөн нэг оролцогч олон нийтийн өмнө өөрийгөө илэрхийлэх тал сул байсан гэж дүгнэв. Өмнөх судалгаагаар гадаад дүр төрх бүрдүүлэлтэд сул ханддаг хандлага энэхүү судалгаагаар бас ажиглагдав.

Мэдлэг боловсролын хүчин зүйлсийн хувьд ялагдлын шалтгааныг улс төрийн мэдлэг боловсрол, туршлагын дутмаг, сонгуулийн практик чадамжийн дутмаг байдалтай холбов. Эмэгтэй улс төрчдийн хувьд нийтлэг байдлаар хөрөнгө санхүүгийн дутмаг байдлыг ялагдлын шалтгаан гэж үзлээ.

Тухайн нэр дэвшсэн орон нутагтаа сайн танигдаагүй, угсаатны болон овгийн нөлөө ихтэй газар, сайн мэдэхгүй тойрогт түлхэгдэн нэр дэвшсэн, нам дотоодын зөрчил, баг болж ажиллаж чадаагүй зэрэг орон нутаг, танил талын хүчин зүйлсийг нэрлэжээ (Матриц 3.3.2).

Намын дотоодын зөрчил эмэгтэй, залуу улс төрчдөд илүү хүнд тусдаг хэмээн судалгаанд оролцогчид онцолсон. Сонгуулийн үеэр эрэгтэй нэр дэвшигч нь баг болж ажиллахгүй байх, намын удирдлага төдийгүй гишүүд, дэмжигчид тодорхой эрэгтэй улс төрчид хамаатуулан гадуурхах, танигдаагүй тойрогт нэр дэвшихээс аргагүйд хүргэх, гишүүд, дэмжигчдэд хангалттай хэмжээний мөнгө зарцуулж чадахгүй, үйлчилж дэмжлэг үзүүлж чадахгүй бол “ашигтай нэр дэвшигч биш” хэмээн нэр зүүн сонгуульд ялагдахад хүргэдэг тал бий гэснийг дурдах нь зүйтэй.

Иймд орон даяар нэгж бүхий улс төрийн намуудын хувьд нэг талаас дээрээс доош чиглэсэн бюрократ бүтэц, нөгөө талаас мөнгө, ашиг, дэм түшсэн “хөлсний” шинжтэй гишүүд, дэмжигчээс тогтсон бүтэц бүхий байвал эрх мэдэл, мөнгө ихтэй, олонд танигдсан улс төрч л амжилт олох нөхцөл бүрдээд байна. Хэрэв эмэгтэй хүн хөрөнгийн чадавх сул, олонд танигдаагүй бол намын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцоотой, ачаалал үүрдэг атлаа “үл үзэгдэгч”-ийн дүрд олон жилийг өнгөрөөдөг, улмаар залхсандаа улс төрөөс гарах эсвэл идэвхтэй оролцохоос татгалзах үр дагавартайг анхаарах шаардлагатай.

Матриц 3.3.4 Сонгуульд ялагдахад хүргэсэн хүчин зүйлс, эмэгтэй оролцогчдын өгсөн хариултаар, 2024

Хувийн зан чанарын хүчин зүйлс	Гадаад төрх, бие бялдрын хүчин зүйлс	Мэдлэг боловсролын хүчин зүйлс	Хөрөнгө санхүүгийн байдал	Орон нутаг, танил талын хүчин зүйлс
<ul style="list-style-type: none"> <li>• Өөртөө итгэлгүй</li> <li>• Сулбагар</li> <li>• Өөрийн хүрээллээр хэт түгжигдсэн</li> <li>• Олон нийттэй харилцаж сураагүй</li> <li>• Нам дотроо ойлголцоогүй</li> <li>• Хэт даруу</li> <li>• Биеийн хэлэмжээ тооцоогүй</li> <li>• Хэт шударга зан</li> <li>• Залуу</li> <li>• Зоригтой биш</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сул тал байсан гэж харахгүй байна</li> <li>• Зөвлөхтэй байсан сул тал гараагүй</li> <li>• Олон нийтийн өмнө хэрхэн гарах, өөрийгөө илэрхийлэх бэлтгэл сул байсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрийн туршлага дутмаг</li> <li>• Улс төрийн боловсрол дутмаг</li> <li>• Улс төрийн асуултад бүдрэлгүй хариулдаг болтол бэлтгэх</li> <li>• Олон нийттэй харилцах мэдлэг, боловсрол дутмаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө мөнгө дутсан</li> <li>• Мөнгө тараагаагүй</li> <li>• Тойрог томсоод зардал өссөн</li> <li>• Намын гишүүдэд өгөөд байх мөнгөөр дутмаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сайн танигдаагүй</li> <li>• Улс төрийн туршлагагүйгээс огт мэдэхгүй тойрогт нэр дэвшсэн</li> <li>• Угсаатны нөлөө нөлөөлсөн</li> <li>• Овгийн нөлөө нөлөөлдөг</li> <li>• Нэг намын хамтрагч баг болж ажиллаагүй</li> <li>• Намын дотоод зөрчилтэй тул намын гишүүдийн дэмжлэг сул</li> <li>• Нам бус</li> <li>• Намын эмэгтэйчүүдийн холбооны дэмжлэг сул</li> <li>• Тодорхой эрэгтэй улс төрчид хамаатуулан гадуурхах</li> </ul>
Эх сурвалж: ТМЯ, 2024				

ТМЯ-д оролцсон улс төрчид эмэгтэй улс төрчийн сул талыг дараах байдлаар тодорхойлсныг өөрөөс нь хамаарах хийгээд үл хамаарах гэсэн хоёр хүрээнд авч үзье.

Хувийн сул талд:

Зориггүй, тууштай биш, өөртөө итгэлгүй, идэвхгүй, ямар нэг нэр хоч зүүх вий (эрэгтэй улс төрчтэй холбох вий) гэсэн айдас, болгоомжлол зэргийг 2021 оны судалгааны адил нэрлэснээс гадна улс төрийн мэдлэг боловсрол, туршлага дутмаг, нэгдмэл баг болж ажиллаж чаддаггүй хэмээн онцолсон. Мөн цөөн тооны эмэгтэй улс төрчдийн хувь хүний алдааг бүх эмэгтэй улс төрчид нааж, дараа үе болон бусдын нэр хүндийг тодорхойлоход хүргэдэг гэж дүгнэж байв.

Хэдийгээр эмэгтэй сонгогчид эмэгтэйчүүдээ дэмжих хандлагатай байгаа ч “Эмэгтэйчүүд эмэгтэйгээ дэмждэггүй” гэсэн яриа улс төрч эмэгтэй, эрэгтэйчүүдийн ярианд нийтлэг дурдагдсан. Мөн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага сонгуулийн үеэр дэм болоогүй гэж хариулагсад цөөн бус удаа таарсан. Ялангуяа эмэгтэйчүүдийн холбоод хүчтэй нөлөө бүхий байгууллага болж чадахгүй байгаагийн шалтгаан бол эрэгтэйчүүд нэгнийхээ манлайллыг хүлээн зөвшөөрч, тойрон хүрээлж баг болж бүгдийнхээ карьерыг өсгөж чаддаг бол эмэгтэйчүүд хэн нэгнийхээ манлайллыг хүлээн зөвшөөрч

чаддаггүй, өөрт давуу тал бүрдүүлсэн бол бусдынхаа төлөө удирдлагатай зөрчилдөхөөс айдаг явдал гэж эрэгтэй улс төрчид, цөөн тооны эмэгтэй улс төрчид өгүүлэв.

Эмэгтэй улс төрчдийн дунд түгээмэл буй айдас, болгоомжлол нь “хэн нэгэн эрэгтэй улс төрчийн хүн” болж харагдах вий гэсэн болгоомжлол бодитоор оршин буй. Үүнтэй холбоотойгоор өөрийгөө илэрхийлэх, өөрийн хийснээ манлайлагч хэн нэгэн эрэгтэй улс төрчид таниулахад эмэгтэй улс төрчдийн хувьд том бэрхшээл болж байгаа тухай өмнө дурдсан. Иймд улс төрийн намууд гишүүдийн идэвх оролцоо, хичээл зүтгэлийг шударгаар үнэлэх, айдас болгоомжлолгүйгээр таниулах суваг, боломжийг нээлттэй болгох нь эмэгтэй улс төрчөө дэмжих нэгэн хэрэгсэл болох юм. Өөрөөр хэлбэл, дээрээс доош чиглэсэн тогтолцоог халах нь эмэгтэйчүүд, залуучууд гэх мэт нийгмийн олон талт байдлыг тэгш хамруулахад чухал ач холбогдолтой юм.

**Өөрөөс нь үл хамаарсан институтийн хүчин зүйлс:**

Эрэгтэй давамгайлсан улс төрийн намын бүтэц, санхүү, мөнгөний хүчин зүйлс, ар гэрийн ачаалал, дэмжлэг сул байдал, олон нийтийн ойлголт хандлага зэрэг хүчин зүйлсийг эмэгтэйчүүдээс өөрсдөөс нь үл хамаарсан институтийн хүчин зүйлс хэмээн тодорхойлсон. Эрэгтэй улс төрчдийн зүгээс институтийн хүчин зүйлсийг дурдаж, анхаарал хандуулах болсон нь 2024 оны судалгаагаар илэрсэн онцлог байв (Матриц 3.3.5).

Матриц 3.3.5 Эмэгтэй улс төрчийн сул тал

### Эмэгтэй улс төрийн сул тал (хувийн)


- Сул, идэвхгүй, зориггүй, тууштай биш:
  - Болж байна гэж өөрөө боддог.
  - Итгэмтгий.
  - Заргач, шүүмжлэгч биш.
  - Өөрийгөө үнэлдэггүй, өөрийгөө илэрхийлдэггүй.
  - Удирдлагадаа өөрийн ажлаа зарлаж, нэр төр хөөдөггүй.
  - Аймхай, хэн нэгэн хүний татаас гэж харагдах вий гэж айдаг.
  - Сэтгэл хөдлөлөө барих чадвар сул.
- Улс төр, эрх зүйн боловсрол дутмаг
  - Аль ч салбарын асуудалд тооцоо судалгаатай, анхаарлаа хандуулж ярьж чаддаггүй.
  - УТ-ын үзэл баримтлалаа сайн мэдэхгүй байна.
  - Үнэт зүйлээ гол зорилгоо болгодоггүй.
  - Алсын хараа, төрийн бодлого ярьдаггүй.
  - Бэлтгэлгүй, бодлогогүй ярьдаг.
  - Төлөөллийн үүргээ хангалтгүй биелүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд анхаарахгүй.
  - Асуудлаа мэдэхгүй албан тушаалд зүтгэдэг хэр нь ажиллаж чадахгүй.
- Багаар ажиллаж чаддаггүй.
  - Баг болж чадахгүй байна, бусадтайгаа хамтарч чадахгүй.
  - Удирдлагад таалагдах үг хэлж чаддаггүй.
  - Хов жив ярьдаг, бусадтайгаа муудалцдаг.
  - Эмзэглэх нь амархан, нэгдэх нь сул.
- Нийтэд түгсэн нэр хочийг батлахуйц алдаа гаргадаг:
  - Хэл ам, хов живд ордог.
  - Хэн нэгнээс хамааралтай байдаг.
  - Мэдлэг мэдээлэл муу.
  - Авлигад өртөж байна.
- Гэр бүлийн ачаалал
  - Гэр бүлийн ачааллаа давхар үүрдэг.

### Эмэгтэй улс төрчийн сул тал (өөрөөс нь үл хамаарах)

- Нам дахь эрэгтэйчүүд давамгайлсан бүтэц
  - Хөрөнгө чинээтэй эмэгтэйчүүдийг дэмждэг.
  - Далд байдлаар тохиролцож танил бус тойрог хуваарилдаг.
  - Нам дотоодын фракцын зөрчил, ялгаварлал байдаг.
  - Эмэгтэйчүүдээ бэлтгэхгүй байна.
  - Намын эмэгтэйчүүдийн байгууллагын тэргүүлэгч нар хувиа боддог.
  - Намын дотоод ардчилал сул, ил тод байдал сул, олон ургалч байдлыг үл дэмждэг, өөр санаа бодолтой хүнийг хавчдаг.
  - Дарга төвт буюу дээрээс доош чиглэсэн засаглалын бүтэцтэй.
  - Чадварлаг эмэгтэйчүүдийг гаргаж ирэх сонирхолгүй, олж элсүүлдэггүй.
- Санхүү мөнгөний дутмаг байдал.
- Ар гэрийн ачаалал их.
- Ээлтэй бус, мөнгө шаардсан сонгуулийн тогтолцоотой.
  - Тойрог томсгосон.
  - Шударга бус сонгуулийн үйл явц: Мөнгө тараадаг.
- Улс төр дэх нөлөө бүхий сүлжээний гадна байдаг.
  - Хүрээнд нь орох боломж хомс
  - Нэр хоч зүүлгэдэг.
- Эмэгтэй улс төрчид цөөхүүлээ байна.
- Олон нийтийн дарамт, хүлээлт их, шошго зүүлгэдэг.
  - Сонгогчид бэлтгэгдээгүй.
  - Сэтгүүлч нарын харлуулалт их.
  - Эрэгтэй хүн ард нь байдаг гэж харддаг.
  - Улс төрийн ажлыг эрэгтэйчүүдийнх гэж үздэг.

2021 оны асуулга судалгаанд оролцогчдын дунд эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаарх сайн, муу холимог мэдээлэл авах нь давамгайлж байсан бол эрэгтэй улс төрчийн талаар сөрөг мэдээлэл авсан гэж хариулсан хувь эмэгтэй улс төрчөөс бараг 10 хувиар илүү байсан юм. 2024 оны судалгааны энэхүү дүн дахин давтагдаж байна. Учир нь, сонгогчид эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар холимог мэдээлэл авч байна. Түүнчлэн эрэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл сөрөг байсан гэх хариулт эмэгтэй улс төрчөөс 7 хувиар илүү, харин эерэг мэдээлэл авсан нь эмэгтэй улс төрчийн хувьд эрэгтэй улс төрчийнхөөс 2 орчим хувиар өндөр байна (Зураг 3.3.2).

Зураг 3.3.2 Эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар авсан мэдээллийн хэв шинж, хувиар, 2024



Фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын өгсөн мэдээлэл агуулгын хувьд 2021 оны үр дүнг давтаж байна. Асуулгын судалгаанаас ялгаатай нь эрэгтэй, эмэгтэй оролцогчдын дийлэнх эмэгтэй улс төрчдийн мэдээлэл сөрөг, холимог мэдээлэл давамгайлдаг, мөнгө санхүүгийн хувьд чадамж дутмагаас хэвлэлээр харьцангуй бага гардаг тухай өгүүлж байв. Мөн эрэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл ч сөрөг байдаг тухай олон оролцогчид нэмж дурдсан. Энэ нь эрэгтэй улс төрчид олон байдагтай холбоотой. Цагаан сарын дараахан, зудын хүндрэлийн үед мэдээлэл цуглуулсантай холбоотойгоор оролцогчдын дунд эрэгтэй улс төрчдийн малчдад тусалж буй үйл ажиллагааны талаар нэлээд мэдээлэл авснаа дурдаад сайшаахаас илүүтэй сонгуулийн ажил эхэлсэн хэмээн шүүмжлэх нь нийтлэг байв.

Сайд, байнгын хорооны дарга, Засаг дарга эмэгтэйчүүдийн төрөөс батлан гаргасан шийдвэр, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг эерэг мэдээлэл хэмээн хүлээн авсан байгаа бөгөөд ийн дурдаж буй оролцогчид цөөн хувийг эзэлж байна. Эндээс хэвлэл мэдээллээр гарах эсэх, ямар мэдээллээр хүрэх вэ гэдэгт улс төрчийн эрхэлж буй албан тушаал чухал үүрэгтэй байгаа нь харагдаж байна.

Бүх ярилцлагад эмэгтэй гишүүдийн талаарх сөрөг мэдээллийг ерөнхий ба тодорхой утгаар өгүүлж байсан. Тэр дундаа гэр бүлийн хэрүүл маргаан, ард иргэдээ доромжилсон тухай нийтлэг яригдсан болно. Дийлэнх ярилцлагад хүйсээс үл хамааран хүлээн авсан сөрөг мэдээллийг шүүн тунгаахаас илүүтэй, санал нэгдэж, шүүмжлэх өнгө аяс давамгайлж байв (Матриц 3.3.6).



Матриц 3.3.6 Эмэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл хүлээн авсан байдал, хариу үйлдэл, үнэлгээ,

	Эмэгтэй улс төрчийн тухай
Мэдээлэл хангалттай гардаг эсэх	Үгүй Тоо цөөхөн тул хангалттай гардаггүй Эмэгтэй улс төрчид мөнгө муутай тул хэвлэл мэдээллээр гарч чаддаггүй
Эерэг мэдээлэл	Аймгийн онцгой комиссын хуралдааны шийдвэр Тэтгэвэр нэмсэн тухай, халамжийн тухай Малчдын нийгмийн даатгалын тухай
Сөрөг мэдээлэл	Нарийвчилсан мэдээлэл бүхий түүх, яриа дурдсан
Мэдээллийг хүлээн авсан байдал	Мэдээлэлтэй санал нэгдсэний зэрэгцээ эсэргүүцэж, шүүмжилсэн Үндэслэл муутай мэдээлэл их гэж дүгнэсэн Муу мэдээн дээр дөрөөлдөг гэж үзсэн
Эерэг мэдээлэл давамгайлдаг эсэх	Үгүй
Сөрөг мэдээлэл давамгайлдаг эсэх	Тийм
Мэдээлэл аваагүй	Улс төр сонирхдоггүй, улс төрийн мэдээлэл авдаггүй
Эх сурвалж. ФБЯ, 2024	

## Дүгнэлт

- Одоогийн УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь хангалтгүй гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь боломжийн болон хангалттай гэж үзсэн бөгөөд ийнхүү төлөөллийн бодит байдлыг дүгнэх үнэлгээ хүйсээс хамаарч ( $X^2 = 22.329$ ,  $p < .000$ ) байна. Гэхдээ парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй гэж үзсэн оролцогчдын хувь өсөж байгаа нь шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх хэвшмэл үзэл буурч байгааг илтгэж байна.
- Хангалтгүй байгаа шалтгааныг эцгийн эрхт ёсны бүтэц, соёлын хүчин зүйл гэж үзэж байна. Тодруулбал, улс төрийн намын эрх мэдэл эрэгтэйчүүдэд төвлөрсөн, хууль, эрх зүйн орчны дэмжлэг сул, улс төрийн намын эмэгтэйчүүдийг үл дэмжсэн дотоод бүтэц, соёлыг парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн үндсэн шалтгаан гэж үзэж байна. Харин эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргийн ачаалалтай холбон тайлбарласан оролцогчдын жин буурчээ.
- УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй байгаагийн шалтгааныг эцгийн эрхт ёсны бүтэц, соёлоо дэмжсэн, зөвтгөсөн хандлага бүхий оролцогчдын тоо 2.4 дахин буурсан байна. Гэхдээ судалгаанд оролцогчдын тал орчим хувьд ийм хандлага байсаар байгаа тул жендэрийн мэдлэг, ойлголтыг түгээх хэрэгцээ байгааг харуулж байна. Асуулгын судалгааг чанарын судалгааны мэдээлэл давхар баталсан бөгөөд эрэгтэй, эмэгтэйчүүдийн ярианд олон нийтлэг зүйл илэрч байгаа ч эмэгтэй оролцогчдын хувьд эмэгтэйчүүдэд үл итгэх гэхээсээ илүүтэйгээр учирч буй нийгмийн бүтэц, соёлтой холбогдох саад бэрхшээлийг илүү олон төрөлтэйгөөр нарийвчлан нэрлэж байна.
- ТМЯ-д оролцсон улс төрчид эмэгтэй улс төрчийн хувийн сул талд зориггүй,

тууштай биш, өөртөө итгэлгүй, идэвхгүй, ямар нэг нэр хоч зүүх вий (эрэгтэй улс төрчтэй холбох вий) гэсэн айдас, болгоомжлол зэргийг өмнөхийн адил нэрлэснээс гадна улс төрийн мэдлэг боловсрол, туршлага дутмаг, нэгдмэл баг болж ажиллаж чаддаггүй байдалд түлхүү анхаарав. Институтийн хүчин зүйлсэд эрэгтэй давамгайлсан улс төрийн намын бүтэц, дээрээс доош чиглэсэн “дарга төвт” засаглалын харилцаа, санхүү, мөнгөний хүчин зүйлс, ар гэрийн ачаалал, дэмжлэг сул байдал, олон нийтийн ойлголт хандлага зэргийг багтаав.


- Өмнөх судалгааны адилаар иргэд эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар холимог мэдээлэл авах нь түгээмэл байна. Түүнчлэн, эрэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл сөрөг байсан гэх хариулт эмэгтэй улс төрчийнхөөс илүү байна. Гэхдээ фокус бүлгийн ярилцлагын үеэр эмэгтэй улс төрчийн хувийн болон ажил хэргийн амьдрал, үйл ажиллагааны талаарх олон янзын сөрөг мэдээ дурдаж байснаараа онцлог.

### 3.4. Квот (түр тусгай арга хэмжээ) тогтоох аргын талаарх мэдлэг, хандлага

Судалгаанд оролцогчдын 37.2 хувь нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд квот тогтоох арга хэрэглэдгийг мэдэж байна. Эндээс дүгнэхэд квотын арга хэрэглэдгийг мэддэг иргэдийн эзлэх хувь 3.2-р өсжээ. Эрэгтэйчүүд квотын аргыг илүү мэдэж байгааг 2 судалгааны дүн харуулж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад квотын арга хэрэглэдгийг мэддэг эмэгтэйчүүд 3.8 хувиар өссөн дүнтэй гарчээ. (Зураг 3.4.1).

Иргэдийн 62.8 хувь нь квотын арга хэрэглэхийг мэдэхгүй байгаа нь сонгогчдын боловсролыг системтэйгээр дээшлүүлэх шаардлагатай болохыг илэрхийлж байна. Ялангуяа 18-24 насныхан болон хөдөө орон нутгийн хүн ам, баруун бүсийн угсаатны бүлгийн хүн амд квотын аргыг мэдэх нь хамгийн бага хувьтай илэрч байна.

Зураг 3.4.1 Квотын арга хэрэглэдгийг мэдэх үү? хүйсээр болон хувиар



( $\chi^2 = 6.045, p < .014$ )

Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2021.


( $\chi^2 = 2.504, p < .0114$ )

Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн, 2024

Квотын аргыг мэддэг иргэдийн 80.7 хувь нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд хүйсийн квот тогтоохыг дэмжиж байна. Квотын аргыг мэддэг эмэгтэйчүүдийн 87 хувь, эрэгтэйчүүдийн 74 хувь квот тогтоох аргыг дэмжжээ. 2021 онд эрэгтэйчүүдтэй харьцуулахад квот тогтоох

аргыг хэрэглэхийг дэмжих байдал эмэгтэйчүүдэд 8.6 хувиар илүү байсан бол 2024 онд 15 хувьд хүрч, хоёр дахин өссөн онцлох үр дүн юм (Зураг 3.4.2).

Зураг 3.4.2 Квотын аргыг дэмждэг үү?, хувиар болон хүйсээр



Квотын талаарх мэдлэгийг хот болон хөдөөгөөр харьцуулан шинжлэхэд 2021 онд орон нутгийн эрэгтэйчүүдийн 54.5 хувь мэднэ, орон нутгийн эмэгтэйчүүдийн 56.8 хувь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. 2024 онд квотын аргыг мэддэг орон нутгийн хүн амыг хүйсээр шинжлэхэд 48.2 хувь (n=123) нь эрэгтэй, 51.8 хувь (n=132) нь эмэгтэй, мэдэхгүй орон нутгийн хүн амд 44 хувь нь (n=180) эрэгтэй, 56 хувь нь (n=229) эмэгтэй байна.

Квотын талаарх мэдлэгтэй Улаанбаатарын оролцогчдын 48.2 хувь (n=92) эрэгтэй, 51.8 хувь (n=99) нь эмэгтэйчүүд, мэдэхгүй оролцогчдын 42.9 хувь нь (n=148) эрэгтэй, 57.1 хувь нь (n=197) эмэгтэй байна. 2021 онтой харьцуулахад нийслэл, орон нутагт квотын аргыг мэддэг хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 50-иас давж, мэдлэг нэмэгдсэн үр дүн ажиглагдаж байна.

Хүснэгт 3.4.1 Квотын аргыг хэрэглэхийг мэдэх байдал, байршлаар болон хүйсээр

Байршил	2021				2024				Нийт
	Мэднэ		Мэдэхгүй		Мэднэ		Мэдэхгүй		
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	
Улаанбаатар	49.2	50.8	44.2	55.8	48.2	51.8	42.1	57.1	100.0
Орон нутаг	54.5	44.5	43.2	56.8	48.2	51.8	44.0	56.0	100.0

Өмнөх судалгаагаар хотын эмэгтэйчүүдийн 55.2 хувь дэмжиж харин эрэгтэйчүүдийн 65 хувь дэмжээгүй үр дүн үзүүлсэн нь эрэгтэйчүүдийн дэмжлэг болон эсэргүүцэл ойролцоо байгаа үр дүн үзүүлсэн. 2024 онд квотыг дэмждэг оролцогчдыг байршлаар шинжлэхэд хотын эмэгтэйчүүдийн 57 хувь, орон нутгийн эмэгтэйчүүдийн 55 хувь дэмжиж, хотын эрэгтэйчүүдийн 66.7 хувь, орон нутгийн эрэгтэйчүүдийн 63.6 хувь дэмжихгүй байна. 2021 оны судалгааны дүнтэй харьцуулан байршлаар шинжлэхэд эрэгтэйчүүд хүйсийн квот тогтоохыг эсэргүүцэх хандлагатай хэвээр байгааг судалгааны дүн харуулж байна.


Хүснэгт 3.4.2 Квотын аргыг хэрэглэхийг дэмжих байдал, байршлаар болон хүйсээр

Байршил	2021				2024				Нийт
	Дэмжинэ		Дэмжихгүй		Дэмжинэ		Дэмжихгүй		
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	
Улаанбаатар	44.8	55.2	65.0	35.0	43.0	57.0	66.7	33.3	100.0
Орон нутаг	53.8	46.2	56.2	43.8	45.0	55.0	63.6	36.4	100.0

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх квот тогтоохыг дэмждэг оролцогчдын 69.9 хувь одоогийн квотын түвшнийг ахиулах, 26.7 хувь нь хуулиар баталгаажсан 30 хувийн квотыг барих, 5 хувь нь одоогийн квотын бууруулсан хэмжээг санал болгосон үр дүнтэй гарчээ. (Зураг 3.4.5). Квотыг дэмждэг оролцогчдын хувьд дунджаар 40 хувийн квотын хэмжээг санал болгосныг тоон судалгааны дүн харуулж байна.

Харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30.2-т, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 29.2-т нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байхаар хуульчилсан хууль хүчин төгөлдөр үйлчилж байсан 2021 онд судалгаанд оролцогчдын 83.3 хувь нь 20 хувиас илүү квот, 10.6 хувь нь 20 хувийн квот, 3 хувь нь 20-иос бууруулсан квотыг санал болгож байжээ.

Зураг 3.4.3 Судалгаанд оролцогчдын санал болгосон квотын хэмжээ, хувиар




**Шигтгээ 3.4.1**

ФБЯ, Завхан аймгийн Идэр сумын малчин залуу, дунд насны эрэгтэйчүүд	Квот гэж сонсож байгаагүй. Квот гэж анх удаа л сонсож байна.
ФБЯ, Дархан-Уул аймаг, холимог насны эмэгтэйчүүд	50/50 хувьтай байх хэрэгтэй. 10 хувь гаргаад байвал эрэгтэй хүн давамгайлсан хэвээрээ л байна. Эмэгтэйчүүдээ дарангуйлдаг. Эрх тэгш байх үүднээсээ, сайн сайхан тал руу явах үүднээс тэгш байх
ФБЯ, Улаанбаатар хот, БЗД, эрэгтэйчүүд	Эмэгтэйчүүд эрэгтэйчүүддээ дарагдаад байгаа учраас квот тогтоох нь зөв
ФБЯ, СХД-ийн холимог насны эрэгтэйчүүд	Хуулийн өөрчлөлтөөр эмэгтэйчүүдийн тоог хүчээр өсгөх юм байна даа.

Оролцогчдын 70 хувь нь 30 хувийн квотын хэмжээг нэмэгдүүлэх санал гаргасныг хүйсээр шинжлэхэд эмэгтэйчүүдийн 76.8 хувь, эрэгтэйчүүдийн 61.1 хувь нь болж байна. Үлдсэн 26.7 хувь нь 2023 онд хуульчилсан 30 хувийн квотыг хэвээр хадгалах (эрэгтэй 36.3 хувь, эмэгтэй 19.2 хувь), 3.3 хувь нь (эрэгтэй 2.5 хувь, эмэгтэй 3.9 хувь) 30 хувиас бууруулахаар квотын хэмжээг санал болгожээ. 2021 онд квотын түвшнийг одоогийнхоос ахиулах саналтай эмэгтэй оролцогчдын эзлэх хувь (48.8 хувь) эрэгтэйчүүдээс (51.2 хувь) илүү байхад харин 5-15 хувиар бууруулах санал гаргасан хариулагчдад эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэй оролцогчдоос өндөр байв. 2 судалгааны дүнгээр, эмэгтэйчүүд тухайн онуудад хуульчилсан квотын хэмжээг ахиулахыг санал болгосон хувийн жин өндөр байна.

Квот тогтоохыг дэмждэг хариулагчдын санал болгосон квотын хэмжээг дундажлан тооцоход өмнө судалгааны 36.67 хувиас өсөж 42.27 хувьд хүрч, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх байр суурьтай байна. Хүйсээр шинжлэхэд эмэгтэйчүүд 43.78, эрэгтэйчүүд 40.34 хувьд хүргэхээр зорьжээ (Хүснэгт 3.4.4). Эндээс дүгнэхэд, олон нийтийн дунд квот тогтоохыг дэмжих хандлага өсөж, улс төрийн шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэрийг 40:60 гэсэн харьцаагаар хангахыг дэмжиж байна.

Зураг 3.4.4. Олон нийтээс санал болгосон квотын дундаж түвшин, хүйсээр болон хувиар



### Квотыг дэмжих хандлага

- 50/50** хувийн квотоор тэнцвэржүүлнэ.
- Улс төрд **эмэгтэйчүүдийн** төлөөлөл **цөөн** тул квотоор дэмжинэ.
- 21-р зуунд эмэгтэйчүүд** идэвхтэй улс төр хийж, шийдвэр гаргах түвшинд **олноороо** гарч ирэх хэрэгтэй.

### Квотыг дэмжихгүй хандлага

- Анхнаасаа **тэгш байх** ёстой.
- Тэгш байх зарчмыг зөрчиж** байгаа тул эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь өрсөлдөөд гараад ирэхэд болохгүй зүйлгүй.
- Квотын талаар ойлголт, мэдээлэлгүй: **квотын арга хэрэглэдгийг мэдэхгүй, сонссон, анх удаа сонслоо, тодорхой мэдээлэлгүй**

Эх сурвалж: ФБЯ-ын үр дүн 2021, 2024

**Квотыг дэмжих хандлага.** Эмэгтэйчүүд оролцсон ФБЯ-аар, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүдийн давамгайллыг 50:50 хувийн квотоор тэнцвэржүүлэх, улс төрд эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн тул квотоор дэмжих, уламжлалт соёлын нөлөө хэвээр тул квот тогтоох, 21-р зуунд эмэгтэйчүүд идэвхтэй улс төр хийж, шийдвэр гаргах түвшинд олноороо гарч ирэхийг дэмжих хандлагатай байна. 50:50 гэсэн хувь эрэгтэй, эмэгтэйчүүдийн ФБЯ-аар давтамж өндөртэйгөөр эшлэгдсэнийг тэмдэглэе.

**Квотыг дэмжихгүй хандлага.** ФБЯ-ын дүнгээр, хүйсийн квотыг эсэргүүцэхээсээ дэмжих нь давтамжийн хувьд өндөр ч цөөн тооны УИХ-ын эмэгтэй гишүүнийг 30 хувийн квотоор нэр дэвшүүлэхийг дэмжээгүй болно. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь хүчээр квот тогтоож, эмэгтэйчүүдийн тоог өсгөхийг дэмжихгүй гэсэн байр суурьтай байна. Эрэгтэй оролцогчид УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалттай гэж хариулсан бол эмэгтэй оролцогчид чадалтай эмэгтэйчүүд нь өрсөлдөөд гарч ирнэ, 70:30 квотоо хэрэгжүүлэх нь чухал байгааг онцолсон. Эрэгтэй, эмэгтэй оролцогчдын аль аль нь хүүхэд, гэр бүлдээ хүлээх үүргээсээ шалтгаалж эмэгтэйчүүд улс төрөөр явдаггүй гэжээ. ФБЯ-д оролцсон казак эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхээр квот тогтоох нь зөв ч шашин, уламжлалт соёлд эмэгтэйчүүд гэрийн ажил хийж, хүүхэд төрүүлэх, асрахад илүү анхаарч, эмэгтэйчүүдийн үүргийг тогтоосон байдаг гэж тайлбарлалаа.

Баруун аймгийн эрэгтэйчүүд оролцсон ФБЯ-ын дүнгээр, 70:30 хувьтай байхад болно гэсэн саналыг дэвшүүлсэн.

ФБЯ-д оролцсон олон нийт квотыг дэмжихгүй байх үндэслэлүүдийг дэвшүүлэхдээ эерэг өндгөөр тайлбарлах хандлага ажиглагдсан. Үүнд:

- Анхнаасаа тэгш байх ёстой юм.  
*Хүйсийн хувьд эмэгтэй нь арай илүү байгаа тул 50/50 байвал тэнцвэртэй болно. ФБЯ, БЗД, ажилгүй, гэртээ хүүхдээ асардаг холимог бүлэг*  
*50/50: эрх тэгш байх үүднээсээ ч, сайн сайхан тал руу явах үүднээс ч тэгш байх хэрэгтэй. ФБЯ, БЗД, гэр хорооллын эмэгтэйчүүдийн бүлэг*
- Тэгш байх зарчмыг зөрчиж байгаа тул эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль аль нь өрсөлдөөд гараад ирэхэд болохгүй гэх зүйлгүй  
*Заавал квот тогтоох албагүй, чадалтай нь гарч ирэг. ФБЯ, Дархан-Уул аймаг, уурхайчдын холимог бүлэг*
- Квотын талаар ойлголт, мэдээлэл байхгүй. Нийгмийн бүлгүүдээр ангилан ФБЯ-уудыг зохион байгуулсан ба оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн дунд квотын арга хэрэглэдгийг мэдэхгүй, сонссон, анх удаа сонслоо, тодорхой мэдээлэлгүй гэж хариулах нь цөөн бус илэрч байна.  
*Квотыг сайн ойлгохгүй болохоор дэмжиж чадахгүй хэрэггүй гэж хэлж чадамгүй байна. ФБЯ, Орхон аймаг, эрэгтэйчүүдийн бүлэг*  
*Хүйсийн квотыг сонсож байсан боловч сайн учрыг нь мэдэхгүй*  
*ФБЯ, Өвөрхангай аймаг, малчин эмэгтэйчүүдийн бүлэг*  
*Квот гэж сонсож байгаагүй. 50/50 байвал зүгээр. Хүчээр квот тогтоолоо гээд өөрсдөө орохгүй бол яах вэ? Квот нь тэгээд яг хэрэгтэй юу? квот гэж анх удаа л сонсож байна. ФБЯ, Завхан аймаг, малчин эрэгтэйчүүдийн бүлэг*

Баруун болон хангайн бүсийн алслагдсан аймгуудын малчин эмэгтэй, эрэгтэйчүүд, угсаатны бүлгийн эмэгтэйчүүдтэй хийсэн ФБЯ-аар, квотын талаар анх удаагаа сонсож байна, квотын талаар мэдээлэлгүйгээс үзэл бодлоо илэрхийлэхэд хязгаарлагдмал байгаагаа илэрхийлсэн.

Орон нутгийн ФБЯ-д оролцогчдын өгсөн мэдээллээр, квотыг дэмжих ч квот зааж өгч байгаагаараа эмэгтэйчүүдээ дэмждэггүй болохыг харуулж байна гэсэн байр суурийг илэрхийлсэн нь онцлох үр дүн юм.

<b>Шигтгээ 3.4.2</b>	
<i>ФБЯ, Хэнтий аймаг, хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийн бүлэг</i>	Квот байхгүй бол эмэгтэйчүүд маш бага нэр дэвшинэ. 50 хувиар тогтоож өгөхгүй бол 20, 30 хувь бол маш бага. Гэхдээ квот тогтоогоогүй байсан үеэ бодвол арай дээр юм даа. Намууд хариуцлагатай байж сайн дураараа 50 болон түүнээс дээш нэр дэвшүүлнэ гэдэг бараг байхгүй л болов уу. Маш том ашиг сонирхлын зөрчил гарч ирэх тул бараг боломжгүй. Хүчээр квот тогтоож байж эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлж байвал манай улс эмэгтэйчүүдээ дэмждэггүй хандлага байна аа л гэсэн үг. Бас иргэдээс ихээхэн шалтгаална эмэгтэйчүүд өөрсдөө сонгогдсон ч зөв зүйтэй зүйлс хийдэггүй.

Үндэстний цөөнхийн бүлгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ФБЯ-аар квотыг дэмжихгүй байх үндэслэлээ шашин, уламжлалт зан заншлын хүчин зүйлээр тайлбарлаад хүчээр квот тогтоохыг дэмжихгүйгээ илэрхийлжээ. Квотыг хүчээр тогтоохыг дэмжихгүй гэсэн байр суурь 2021 онд эрэгтэйчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын дүнгээр илэрснийг тэмдэглэе.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг ахиулахад улс төрийн намуудын дэмжлэг эмэгтэйчүүдэд санхүүгийн асуудал дээр гарч ирнэ, тэгш төлөөллийг бий болгоход намууд хүчин чармайлт гаргах ёстой, УТН-ууд эмэгтэйчүүдээ зөв PR-аар бэлтгэж таниулах, “зөв эмэгтэйчүүд”-ээ (олон нийтийн хэлснээр) нэр дэвшүүлэхийг санал болгосон нь өндөр давтамжтай илэрч байна. Энэхүү үр дүнг өмнөх судалгааны ФБЯ-ын үр дүнг давхар баталгаажуулж байна. ФБЯ-д оролцогчид бусдын нөлөөнд автдаггүй, шударга, ард түмний төлөө дуугардаг, нийгмийн асуудлыг шийддэг, байр сууриа илэрхийлдэг эмэгтэйчүүдийг “зөв эмэгтэйчүүд” хэмээн үзэж байна.

ФБЯ-д 7 аймаг 5 дүүргийн нийгмийн бүлгүүдийн төлөөлөл нийт 169 эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хамрагдсан. УИХ-ын сонгуулийн тухай, Улс төрийн намын тухай хуульд “Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна” гэсэн зохицуулалтыг ФБЯ-д оролцогчдын 29 хувь нь мэдэж байна. Эндээс дүгнэхэд ФБЯ-ын үр дүн нь тоон судалгааны үр дүнг давхар баталгаажуулж буй хэрэг юм. Гэхдээ ФБЯ-ын үеэр оролцогчид квотын зохицуулалтыг мэдэж, энэ нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг төлөөллийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлнө гэсэн байр суурийг илэрхийллээ.

Матриц 3.4.1 Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх зохицуулалтын талаарх иргэдийн мэдээлэлтэй байдал (n=169)

Аймаг		Сум, дүүрэг	Категори	Мэдээлэл авсан	Мэдээлэл аваагүй
1	Ховд	Жаргалант	Дунд насны эрэгтэй	16.7	83.3
		Мянгад	Угсаатны бүлгийн эмэгтэй	16.7	83.3
2	Дархан-Уул	Дархан	Ажил эрхэлдэг, хүүхдээ асардаг эмэгтэй	0	100.0
		Шарын гол	Уурхайчин, эрэгтэй, эмэгтэй холимог	0	100.0
3	Орхон	Жаргалант	Залуу ажил эрхэлдэг эмэгтэй	0	100.0
		Баян-Өндөр	Эрэгтэй холимог	0	100.0
4	Өвөрхангай	Арвайхээр	Эрэгтэй	33.3	66.7
		Ёсөнзүйл	Малчин эмэгтэй	16.7	83.3
5	Хэнтий	Хэрлэн	Дунд насны эмэгтэй	60.0	40.0
		Батноров	Залуу эмэгтэй	33.3	66.7
6	Завхан	Улиастай	Дунд насны эрэгтэй	0	100.0
		Идэр	Залуу эрэгтэй	0	100.0
7	Баян-Өлгий	Өлгий	Казак эрэгтэй	62.5	37.5
		Толбо	Казак эмэгтэй	28.6	74.4
8	СХД	10-р хороо	Эрэгтэй холимог	33.3	66.7
		41	Эмэгтэй холимог	66.6	33.4
9	БЗД	2	Ажил эрхэлдэг холимог	66.6	33.4
		20	ХБ-тэй эмэгтэй	0	100.0
10	Налайх	8-р хороо	Ажил эрхэлдэг эмэгтэй	12.5	87.5
		3-р хороо	Бичил уурхайчин эрэгтэй	50.0	50.0
11	БГД	11	Өрх толгойлсон эмэгтэй	33.3	66.7
		21	Залуу эрэгтэй	0	100.0
12	ХУД	3	Ахмад эмэгтэй	2	100.0
		8	Олон хүүхэдтэй эмэгтэй	28.6	74.4
13	Багануур	1	Эрэгтэй	83.3	16.7
		1	Эмэгтэй	66.6	33.4

Эх сурвалж: ФБЯ-ын дүн, 2024

Хотын дунд болон ахимаг насны эмэгтэйчүүд дунд хэдийгээр квот тогтоосон ч улс төрийн намууд нэр дэвшүүлэлтэд хариуцлагагүй ханддаг, боловсрол мэдлэгтэй, доороос өгсөж ирсэн эмэгтэйчүүдээ нэр дэвшүүлэхгүй байгааг шүүмжлээд, чадварлаг ч хөрөнгө чинээ бага эмэгтэйчүүдийг дэмжихийг санал болгосон.

Судалгаанд оролцогчдын 32.1 хувь нь 30 хувийн квотыг хангалттай, 33.3 хувь хангалтгүй, 34.3 хувь мэдэхгүй гэжээ. Энэхүү үр дүнг хүйсээр шинжлэхэд эрэгтэйчүүдийн 40 хувь хангалттай, эмэгтэйчүүдийн 36.5 нь хангалтгүй гэсэн хариултыг өгчээ. Сургуульд сурч байгаагүй, бага боловсролтой хүн ам болон хөдөөгийн багт аж төрдөг хүн ам холбогдох хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн



талаар мэдээлэлгүй байна. Сургуульд сурч байгаагүй хүн амын 40 хувь, бага боловсролтой хүн амын 53.3 хувь нь хуулиар баталгаажсан 30 хувийн квотыг мэдэхгүй байгаа нь бусад боловсролын түвшинтэй хүн амтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Хөдөөгийн багт аж төрдөг нийт хүн амын 41.9 хувь нь 30 хувийн квотыг мэдэхгүй байна.

*Хүснэгт 3.4.2 Нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар зохицуулсан зохицуулалтын талаарх олон нийтийн үзэл бодол, хувиар*

Сонгосон үзүүлэлтээр	Хангалттай	Хангалтгүй	Мэдэхгүй
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	40	25.3	32.3
Эмэгтэй	29.8	36.5	33.5
<b>Боловсрол</b>			
Сургуульд сурч байгаагүй	20	40	40
Бага	26.9	19.2	53.3
Бүрэн бус дунд	33.8	32.5	33.8
Бүрэн дунд	30.5	33.5	35.9
Тусгай дунд	42.9	24.5	32.7
Дээд	31.8	36.5	31.8
<b>Засаг захиргааны харьяалал</b>			
Улаанбаатар	30.4	33	36.6
Баян-Өлгий	43	34.2	22.8
Ховд	25.6	41.1	33.3
Завхан	27.5	27.5	45
Өвөрхангай	32.5	38.5	29.1
Дархан-Уул	34.8	35.9	29.3
Орхон	39.6	26.4	34.1
Хэнтий	30	31.3	38.8
<b>Байршил</b>			
Аймгийн төвийн сум/дүүргийн гэр хороолол	31.3	30.2	36.7
Аймгийн төв сум/дүүргийн байшин хороолол	34.4	34	33.2
Сумын төвийн баг	34.3	35.7	30.1
Хөдөөгийн баг	32.4	25.7	41.9
Бүгд	32.3	33.5	34.3

## Дүгнэлт

- Судалгаанд оролцсон иргэдийн 62.3 хувь нь шийдвэр гаргах түвшинд оролцоог төлөөллийг дэмжихэд квотын арга хэрэглэхийг мэдэхгүй байна. Квот тогтоохыг мэдэхгүй хүн амд ялангуяа хүйсийн хувьд эмэгтэйчүүд, залуу насны хүн ам, хөдөөгийн хүн ам, баруун бүсийн угсаатны бүлгийн хүн амд квотын аргыг мэдэх нь хамгийн бага хувьтай илэрлээ. 2 судалгаагаар квотыг мэдэхгүй хүн амын эзлэх хувь өндөр ч өмнөх судалгаатай харьцуулахад мэддэг хувь нэмэгдэж, чанарын судалгааны дүнгээр мэдэх хүсэл эрмэлзэлтэй байгаа үр дүн ажиглагдаж байна.

- Квотын хэмжээг дээд тал нь 100 хувь (2021 онд 80 хувь), дундаж квотын түвшинг 42.27 хувьд (2021 онд 36.67 хувь) хүргэж нэмэгдүүлэхийг олон нийт санал болгосон үр дүн харуулж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад судалгаанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн санал болгосон квотын хэмжээ өсөж, ялангуяа эмэгтэйчүүд тухайн онуудад хуульчилсан квотын хэмжээг ахиулахыг санал болгосон хувийн жин өндөр илэрлээ.
- Квотын аргыг мэддэг иргэд дунджаар 40 хувийн квот, чанарын судалгааны дүнгээр, хүн амын 50-иас илүү хувийг эзэлдэг, тэгш эрхийн зарчмыг хангах үүднээс 50/50 хувийг квотыг дэмжсэн нь нийтлэг ажиглагдлаа. Тоон болон чанарын судалгааны үр дүнд тулгуурлан дүгнэхэд 40:60 хувийн квотыг дэмжиж байна.

### 3.5 Улс төрийн манлайлагчаас хүлээх хүлээлт

Тоон болон чанарын судалгааны дүнд тулгуурлан олон нийт манлайлагчаас ямар тодорхой чанаруудыг хүсэн хүлээдэг, эдгээрээс аль чанарыг эрэгтэйд, эмэгтэйд түлхүү хамаатуулж байгаагаар шинжиллээ.

Эрэгтэйд давуутай хамаатуулсан байгууллага, хамт олныг удирдах, бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах чанарыг жендэрийн хэвшмэл ойлголтын үүднээс эрэгтэйд давуутай хамаатуулдаг онцлох үр дүн үзүүлж байна. Өмнөх судалгаанд манлайллын шинж чанаруудыг аль ч хүйсэд адил илрэх хувилбар зонхилсон бол энэ судалгаагаар аль аль хүйсэд хамаарах хувийн жин буурч, манлайллын 7 шинж чанарыг эмэгтэй хүйсэд хамаатуулсан хувилбарын хувийн жин өсжээ. Тодруулбал нийт 9 манлайллын 7-г эмэгтэй хүнд хамаатуулсан нь давуутай илэрсэн гэсэн үг.

Сэтгэх бодох чадварыг эрэгтэйд түлхүү хамаатуулах хандлага ажиглагдаж байгаа ч эмэгтэйчүүдэд хамаатуулсан хувь өмнөх судалгаатай харьцуулахад 2 дахин (2021 онд 17.9 хувь, 2024 онд 29.4 хувь) өссөн байна.

Ерөнхийдөө бусдыг ойлгож уян хатан байх, хариуцлагатай байх чанарыг эмэгтэйчүүдэд оногдуулж байгаа нь 2 судалгааны үр дүнгээр тэргүүлэх байр суурьтай илэрч байна.

Манлайллын чанаруудыг эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алинд нь хамаатуулах дундын хувилбарыг чухалчлахаасаа илүүтэйгээр 2 зах руугаа тэмүүлсэн буюу эмэгтэй нь илүү гэх хандлагын эзлэх хувь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нэмэгдсэн байна.

Энэхүү үр дүнг хүйсээр шинжлэхэд аливаад хариуцлагатай хандах, бусдыг ойлгож уян хатан байх чанараар эмэгтэй нь илүүг хүйсийн ялгаагүйгээр хүлээн зөвшөөрсөн, сэтгэн бодох чадварыг эрэгтэйд илүү гэдгийг эрэгтэй, эмэгтэй оролцогчдын аль аль нь зөвшөөрчээ. Харин байгууллага удирдах, итгэл үнэмшил, үнэт зүйлс, мэдлэг, ур чадвараараа бусдыг дагуулах, бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах, бусдад хийж бүтээх эрмэлзлийг төрүүлж, боломж олгох, шинийг санаачилж, өөрчлөлтийг авчрах чанаруудыг эмэгтэй оролцогчдын зүгээс эмэгтэйд илүү, харин эрэгтэй оролцогчдын зүгээс эрэгтэйд илүү гэсэн эсрэгцсэн байр суурийг илэрхийлж байна.

Хариуцлагатай, бусдыг ойлгож, уян хатан байх гэсэн хоёр чанараас бусад долоо чанарт эрэгтэй оролцогчид “эрэгтэй нь илүү” гэж хариулсан нь өндөр хувьтай илэрсэн бөгөөд үүний эсрэгээр эмэгтэй оролцогчид “эмэгтэй нь

илүү” гэсэн хариултыг түлхүү өгснийг 2021 оны судалгааны дүн харуулсан. Үүнийг статистикийн хувьд хэр зэрэг ач холбогдолтойг шинжлэхэд хүйсээс ач холбогдлын түвшинд хамаарч байгааг харууллаа.


*Хүснэгт 3.5.1 Манлайллын чанаруудыг эрэгтэй, эмэгтэй хүнд хамааруулах хандлага, хувиар*

Манлайллын чанар	2021			2024		
	Эрэгтэй илүү	Адил	Эмэгтэй илүү	Эрэгтэй илүү	Адил	Эмэгтэй илүү
Байгууллага, хамт олныг удирдах	37.2	38.6	24.2	26.7	43.1	30.3
Итгэл үнэмшил, үнэт зүйлс, мэдлэг, ур чадвараараа бусдыг дагуулах	26	43.9	30	29.1	31.6	39.3
Бусдыг нэгдмэл зорилго, үйл хэрэгт нэгтгэх, дагуулах	33.3	40.2	26.5	29.4	34	36.6
Аливаад хариуцлагатай байх	19.2	38.2	42.6	32	25	43
Бусдад хийж бүтээх эрмэлзлийг төрүүлж, боломж олгох	23	46.3	30.6	33	29.5	37.5
Шинийг санаачилж, өөрчлөлтийг авчрах	29.7	44.6	25.6	31.9	33.4	34.7
Аливаад шударга хандаж, бусдад үлгэрлэх	23	46.7	30.2	33.6	29.9	36.5
Сэтгэн бодох	33.1	48.9	17.9	34	36.6	29.4
Бусдыг ойлгож уян хатан байх	9.3	31.8	58.9	26.8	16	57.2
Хариултын нийт дүн (давхардсан хариултаар)	233.8	379.2	286.5	276.5	279.1	344.5

Тоон судалгаагаар, улс төрийн манлайлагч хүнд байх ёстой гэж үзэж буй чанаруудыг олон сонголттой хариултын хувилбараар тодорхойлсон. Иргэдийн сонгосон хариултаар, улс төрийн манлайлагчаас шийдэмгий (83.4 хувь) чанарыг хүссэн нь хамгийн өндөр давтамжтай илэрсэн өмнөх судалгааны үр дүн 2024 онд дахин давтагдаж 78 хувийг эзэлжээ.

Шийдэмгий чанарын дараа тэмцэгч (59.5 хувь), бусдыг ойлгодог (59.1 хувь), зоригтой (56.5 хувь) байхыг чухалчилсан байна. Эндээс дүгнэхэд, олон нийт ихэвчлэн эрэгтэй улс төрчид илүүтэй хамаарах шийдэмгий, тэмцэгч, зоригтой чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээдэг буюу улс төрчийг эрэгтэй дүрээр харж байгааг 2 судалгааны дүн бататгаж байна. Гэхдээ дараах ялгаа илэрлээ. Тодруулбал, 2021 оны судалгаагаар шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанарыг, 2024 оны судалгаагаар шийдэмгий, тэмцэгч, бусдыг ойлгодог чанарыг улс төрч хүнд байх хамгийн гурван чухал чанар гэж үзжээ. Эндээс тэмцэгч дүрийг хүлээх байдал өссөн нь харагдаж байгаа бөгөөд фокус бүлгийн ярилцлагын үеэр жишээ авч тайлбарласан улс төрчдийн нэрийг нэрлэснээр давхар баталгаажиг байна.

Зураг 3.5.1. Улс төрийн манлайлагчаас хүлээх чанарууд, хүйсээр



Улс төрийн манлайлагч хүнд байх ёстой гэж үзэж буй чанаруудыг эрэгтэй болон эмэгтэй улс төрчдөд хэр зэрэг илэрвэл зохимжтой эсэхийг оролцогчдын хүйсээр шинжлэв. 77.5-80.5 хувь шийдэмгий, 58.4-60.4 хувь тэмцэгч, 57.8-60.1 хувь бусдыг ойлгодог чанаруудыг улс төрч хүнд илүү байх ёстой чанаруудаар нэрлэсэн. Энд хүйсийн ялгаа ажиглагдсангүй.

Эрэгтэй улс төрчөөс шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанарыг хүлээж буйгаа илэрхийлжээ. Харин эмэгтэй улс төрчөөс шийдэмгий, бусдыг ойлгодог, тэмцэгч чанарыг хүлээж байна. Олон нийт жендэрийн хэвшмэл үзлийн үүднээс эрэгтэй улс төрчдөд хамаатуулдаг шийдэмгий, тэмцэгч, зоригтой байх чанаруудыг хүлээхийн зэрэгцээ бусдыг ойлгодог байх чанарыг эмэгтэй улс төрчөөс хүсэн хүлээж байна. Эрэгтэй, эмэгтэй улс төрчөөс аль алианаас нь “бусдыг ойлгох чанар”-ыг хамгийн чухал гурван чанарт багтааж байгаа нь нэгд, улс төрчийн хэвшмэл дүр өөрчлөгдөж байгааг, хоёрт, нийгмийн бүлгүүдийн олон талт байдлыг ойлгох чадамжтай улс төрч хэрэгцээтэй болж буйг харуулж байна (Хүснэгт 3.5.2).

Хүснэгт 3.5.2 Эрэгтэй, эмэгтэй улс төрчдөд илэрч байх зохимжтой чанарууд, хувиар

	2021		2024	
	Маш их	Огт шаардлагагүй	Маш их	Огт шаардлагагүй
<b>Эрэгтэй улс төрч</b>				
Энэрэнгүй	28.9	3.8	36.2	4.7
Зоригтой	71.9	0.4	65.5	1.3
Шийдэмгий	81.5	0.5	77.3	0.9
Тэмцэгч	67.9	0.5	64.3	1.7
Зөөлөн	21.6	1	22.7	6.5
Бусдыг ойлгодог	60.8	1.9	65	1.9
<b>Эмэгтэй улс төрч</b>				
Энэрэнгүй	40.6	4.2	50.7	2.5
Зоригтой	71.6	0.8	59.4	1.8
Шийдэмгий	82.3	0.6	73.5	1.8
Тэмцэгч	71.3	1.3	60.2	2.3
Зөөлөн	30.2	8.6	45.8	4.8
Бусдыг ойлгодог	61.1	2.4	71.2	2.3

Тайлбар: Бага зэрэг, дунд зэрэг гэсэн хариултыг хасаж 2 захын буюу маш их, огт

шаардлагагүй гэсэн хариултын хувилбараар шинжилгээг хийв.

ФБЯ-ын дүнгээр, эмэгтэй улс төрчөөс өндөр боловсрол, бусдыг ойлгодог, нийгмийн олон талт асуудлыг шийдэхийн төлөө зүтгэдэг, хүний төлөө, хүмүүнлэг чанаруудыг хүлээж байгаагаар илэрхийллээ. Энэ нь эмэгтэй улс төрчөөс шийдэмгий, тэмцэгч зэрэг эрэгтэй улс төрчид илүү хамаатуулдаг чанаруудыг хүлээхийн зэрэгцээ эмэгтэй улс төрчдөд түлхүү хамаатуулдаг бусдыг ойлгодог, нийгэм, хүний төлөө хүнлэг чанаруудыг давхар хүлээж байгаа нь олон нийтээс илүү өндөр шаардлага тавьдаг болохыг илтгэж байгаа юм.

Мөн эмэгтэй улс төрчдөөс нийгэмд шударга ёс тогтоох, авлигыг бууруулах үйл хэрэгт эмэгтэй улс төрчид манлайлал үзүүлэн, итгэл хүлээлгэх хандлага илэрлээ. Жишээ нь, эрэгтэйчүүд л засаг удирдаж ирсэн, эмэгтэйчүүдэд өгөөд үзье, авлига том хэргээс хол байдаг тул өөрчлөлт авчирч магад хэмээн эмэгтэй улс төрчдөд итгэл үзүүлж буйгаа илэрхийлсэн. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлагад оролцсон зарим эрэгтэй улс төрчийн тайлбарласнаар, шийдвэртээ эзэн болж хатуу зогсох, бусдын ятгалаг, хов жив, уруу таталтад автахгүй байх, албан ажилд хувийн харилцаагаа хутгахгүй байх, эмэгтэйчүүд нэгнийхээ манлайллыг хүлээн зөвшөөрч нэгдэж, хүрээлж чаддаггүй нь шийдвэрт хүчтэй нөлөөлөх чадамжтай бүлэг болоход нь хүргэхгүй байна гэжээ.

Матриц 3.5.1 Эмэгтэй улс төрчийг манлайлагчаар үзэж буй үндэслэл

## 2021

- ✦ Шийдэмгий,
- ✦ Шударга,
- ✦ Дайчин,
- ✦ Зоригтой, гал цогтой,
- ✦ Тууштай: гуйвж дайвдаггүй, бууж өгдөггүй,
- ✦ Зарчимч,
- ✦ Ажил хэрэгч,
- ✦ Амьдралд ойр, амьдрал үзсэн,
- ✦ Ил тод нээлттэй,
- ✦ Хөдөлмөрч,
- ✦ Бага ууж иднэ.

- ✦ Үнэн, зөв, шударга ярьдаг, шүүмжилдэг, үгээ зоригтой хэлдэг, ойлгомжтой ярьдаг,
- ✦ Эх оронч, идэвх санаачилгатай, зүтгэлтэй, иргэдийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө зүтгэдэг.

- ✦ Хийж бүтээсэн зүйлтэй, сайн ажилласан, амлалтаа биелүүлдэг, сайд байхдаа ихийг хийсэн, сайн ажилласан, дарга, удирдагчийн албыг хаших чадвараа харуулсан, Ковид-19 цар тахлаар сайн ажилласан, буянтай, гавьяатай,
- ✦ Эмэгтэйчүүд, эх хүүхдийн асуудалд анхаардаг, шийдэхэд хувь нэмэр оруулсан,
- ✦ Ерөнхийлөгчид нэр дэвшсэн, сайд байсан,
- ✦ Хүний эрхийн төлөө тэмцэгч,
- ✦ Туршлагатай.

## 2024

- ∞ Шийдэмгий,
- ∞ Асуудлыг шийдэхдээ нягт нямбай,
- ∞ Хүний нөлөөнд ордоггүй,
- ∞ Шударга,
- ∞ Нухацтай,
- ∞ Хүнлэг,
- ∞ Хөрвөх чадвартай.

- ∞ Мэдрэмжтэй,
- ∞ Тууштай,
- ∞ Хөдөлмөрч,
- ∞ Бодож хийдэг,
- ∞ Хүлээцтэй,
- ∞ Бусдыг ойлгодог,
- ∞ Асуудлыг детальчилж хардаг,
- ∞ Арай бага иднэ.

- ∞ Асуудлын цаана гарч тууштай явдаг,
- ∞ Иргэдтэй ойр харилцдаг.

- ∞ Олон ажлыг зэрэг амжуулдаг,
- ∞ Зарим салбарыг сайн удирдаж байна,
- ∞ Нийгмийн салбарыг удирдаж байна,
- ∞ Эмэгтэйчүүд олон талаас нь бодож хийдэг,
- ∞ Үлгэрлэн дагуулахдаа сайн.



## 2021

- ✦ Мэдлэг боловсрол, чадвартай,
- ✦ Удирдах чадвартай,
- ✦ Өөрчлөлтийг хийх чадвартай,
- ✦ Асуудлыг зөв талаас нь хардаг, бодлого тодорхойлох чадвартай, системээр нь хардаг,
- ✦ Биеэ даасан хэнээс ч хараат биш,
- ✦ Бусадтай сайн ойлголцож чаддаг, харилцааны соёлтой,
- ✦ Бизнесийн ухаантай.
- ✦ Дэмждэг намын гишүүн,
- ✦ Ардчилсан үзэлтэй.
- ✦ Биеэ зөв авч явдаг, чадалтай,
- ✦ Гоо сайхны мэдрэмжтэй, үлгэр жишээч,
- ✦ Ярианы өнгө нь уярмаар, зарчимч, хүлээцтэй,
- ✦ Улс төрчийн дүр төрхтэй,
- ✦ Даруу, хэл амд ордоггүй, төлөв төвшин.
- ✦ Манай тойргоос сонгогдсон, таньдаг нь,
- ✦ Телевизээр гардаг, нэвтрүүлэг хөтөлдөг, сэтгүүлч.



## 2024

- ∞ Боловсролтой,
- ∞ Эмэгтэйчүүд өндөр боловсролтой тул зарим салбарыг удирдаж байна.
- ∞ Ажил хэрэгч имиж бүрдүүлдэг,
- ∞ Биеэ зөв авч явдаг
- ∞ Үс засалт, гадаад байдалдаа анхаардаг,
- ∞ Даруу төлөв.

Матриц 3.5.2 Эрэгтэй улс төрчийг манлайлагчаар үзэж буй үндэслэл

## 2021

- ✦ Шударга,
- ✦ Шийдэмгий,
- ✦ Зоригтой,
- ✦ Дайчин, тэмцэгч,
- ✦ Ноён нуруутай,
- ✦ Хариуцлагатай,
- ✦ Манлайлагч,
- ✦ Зарчимч,
- ✦ Үлгэр дуурайлалтай,
- ✦ Алсын хараатай,
- ✦ Зорилготой, санаачилгатай,
- ✦ Хөдөлмөрч,
- ✦ Эд хөрөнгийн шуналгүй.
- ✦ Үнэн, зөв, гоё зүйл ярьдаг, зөв шүүмжилдэг,
- ✦ Эх оронч, улс орон, ард түмний төлөө.
- ✦ Хийсэн бүтээсэн зүйлтэй, амлалтдаа хүрдэг,
- ✦ Боловсролын асуудлыг шийдэхээр дорвитой ажилласан,
- ✦ Сайн хуульч, сайн хууль боловсруулдаг,
- ✦ Сайн ерөнхийлөгч байсан, төрийн тэргүүн, ерөнхий сайд байсан,
- ✦ Ардчиллыг Монгол Улсад авчирсан,
- ✦ Авлигатай тэмцсэн,
- ✦ Спортыг дэмжсэн,
- ✦ Туршлагатай.



## 2024

- ∞ Шийдэмгий, түс тас харилцаатай,
- ∞ Шийдвэр гаргадаг төрлийн хүмүүс тул,
- ∞ Ноён нуруутай, алсын хараатай холыг хардаг,
- ∞ Зоригтой,
- ∞ Тууштай явдаг,
- ∞ Гүрийдэг,
- ∞ Хэлье гэснээ хэлдэг,
- ∞ Удирдах чадвараар илүү,
- ∞ Эрчүүд сэтгэн бодох чадвар илүү,
- ∞ Хурдан шуурхай шийдвэр гаргадаг,
- ∞ Өөрийгөө илэрхийлж чаддаг.
- ∞ Эрэгтэй хүн бүх салбарт манлайлах чадвар өндөр,
- ∞ Улс орон, засаг төр, орон нутаг, цэрэг армийг удирдаж байна,
- ∞ Логик дүгнэлт, гарц гаргалгааг олж хардаг.

## 2021

- ☼ Мэдлэгтэй, чадвартай,
- ☼ Удирдагч,
- ☼ Харилцааны соёлтой, ялгаварладаггүй,
- ☼ Уран илтгэдэг,
- ☼ Хараат бус, өөрийн гэсэн бодолтой,
- ☼ Хөрөнгө чинээтэй, бизнесийн ухаантай,
- ☼ Асуудлыг зөв талаас нь хардаг, бодлогыг оновчтой тодорхойлох чадвартай, системээр нь хардаг,
- ☼ Өөрчлөлтийг хийх чадвартай.

- ☼ Намын хүн тул, намынхаа манлайлагч,
- ☼ Залуу гишүүн, шинэ хүн
- ☼ Жинхэнэ Монгол.

- ☼ Хатуу удирдагч байж чадна,
- ☼ Бүх тоглолтын ард байдаг.

- ☼ Арай дээр,
- ☼ Таньдаг нь, нэр нь их дуулддаг.

## 2024

- ∞ Өрхийн тэргүүн гэдэг утгаараа манлайлагч,
- ∞ Төрөлхийн манлайлах чадвартай,
- ∞ Нийгэмд эрчүүд илүү хүлээн зөвшөөрөгддөг,
- ∞ Эрэгтэйчүүд удирдах чадвартай,
- ∞ Эр зориг, тууштай байдал, өөрийгөө илэрхийлэх нь илүү.

- ∞ Ажил хэрэгч, зарчимч имиж бүрдүүлдэг,
- ∞ Биеэ зөв авч явдаг,
- ∞ Албаны хувцасладаг,
- ∞ Монгол эр хүн.



Олон нийтийг оролцуулсан ФБЯ-ын үр дүнд тулгуурлан улс төр дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн манлайллыг хэд хэдэн үндэслэлээр тайлбарлаж байна. Үүнд:

**Уламжлалт соёл, хэм хэмжээ.** Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн манлайллыг ахиулахад жендэрийн хэвшмэл үзэл нөлөөтэй хэвээр байгаа нь эрэгтэй хүн төрөлхийн манлайлах чадвартай, өрхийн тэргүүн тул эрэгтэй хүн манлайлагч гэх хэвшмэл үзэл ФБЯ-д оролцсон эрэгтэйчүүд, ахимаг насныханд илэрч байна. Үүний зэрэгцээ хоёрдмол байр суурьтай оролцогчдын хувьд хэдийгээр орчин үед эрэгтэй эмэгтэй ялгаагүй манлайлагч байж чадна гэж үзэж байгаа ч уламжлалаараа эрэгтэйчүүд манлайлж ирсэн гэх өнцгөөр тайлбарлаж байна. Эмэгтэй, залуу оролцогчдын хувьд уламжлалт соёлын нөлөөгөөр хүүхдээ асрах, хүмүүжүүлэх, гэр бүлдээ илүү үүрэг хүлээдэг учраас эрэгтэйчүүд улс төрд оролцдог, эмэгтэйчүүд улс төрөөр явдаггүй гэсэн үндэслэлээр тайлбарлалаа. Түүхэн хандлагын хувьд ч, уламжлалын хувьд ч Монгол Улсын Ерөнхийлөгчөөр эрэгтэй хүн байна, өрхийн тэргүүн эрэгтэй хүн байдгийн адил төрийн тэргүүн эрэгтэй хүн байна гэсэн тайлбарыг ФБЯ-д оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүд өгсөн нь нийтлэг илэрсэн.

**Эрх мэдэл эрэгтэйчүүдэд байна.** ФБЯ-аар ерөнхийдөө эрэгтэйчүүдэд улс төр, эдийн засгийн эрх мэдэл төвлөрсөн, бүх эрх мэдэл эрэгтэйчүүдэд төвлөрсөн, бүхий л дээгүүр албан тушаалыг хашдаг учраас эрэгтэйчүүд манлайлж байна. Эрэгтэйчүүдийн давуу манлайлалтай улс төрийн намуудын удирдлага эмэгтэйчүүдээ дэмжих тал дээр сул анхаардаг, боловсрол мэдлэгтэй, хийж бүтээсэн зүйлтэй эмэгтэйчүүдээ гаргадаггүй учраас эмэгтэйчүүдийн манлайлал доогуур байна гэж тайлбарлалаа.

**Эмэгтэйчүүд ашиг сонирхлоос ангид, шударга.** Шийдвэр гаргах түвшинд тэр дундаа УИХ-д эмэгтэйчүүд олноороо сонгогдвол улс оронд нүүрлэсэн авлига, хээл хахууль буурна, бусдын халаасанд орохгүй, ашиг сонирхолд хөтлөгдөж хуйвалдаанд оролцохгүй, нийгмийг өөрчлөхөд хувь нэмэр оруулна гэсэн хүлээлт иргэдийн дунд байна.

**Эмэгтэйчүүд өндөр боловсролтой.** Хэн юу хийх чадвартай, боловсролтой байгаагаараа манлайлна, нийгмийн салбарыг эмэгтэйчүүд удирдаж байна.

**Манлайлалд хүйсийн ялгаа үгүй.** Манлайлагч хүн бол боловсрол, мэдлэг, ухаанаар тэргүүлэгч гэсэн үзэл ФБЯ-аар нийтлэг илэрсэн. Улс төрд эрэгтэйчүүд дангаараа засагласнаар улс орон хөгжихгүй, тэгш эрхийг хангах үүднээс эмэгтэйчүүдийн оролцоо шаардагдаж байна. ФБЯ-д оролцогчдын өгсөн мэдээллээр, эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль аль нь манлайлах боломжтойг тэмдэглээд манлайлалд хүйсээс илүүтэйгээр боловсрол, хувийн харизм чухал болохыг онцолсон.

Эмэгтэй манлайлагчид эрэгтэйчүүдээс хүлээдэг чанарууд, улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан, нэр дэвшсэн, нийтийн төлөөх тодорхой (имиж бүрдүүлсэн) үйл хэрэгт манлайлан оролцдог, ажил хэрэгч-эмэгтэйлэг дүр төрх бүхий, амьдрал сайн мэддэг, нээлттэй ил тод эмэгтэй улс төрчийг олон нийт хүсэн хүлээж байна. Энэхүү үр дүн нь өмнөх судалгааны үр дүнг давтаж байна.

**Мөн шударга, одоогийн Монголын нийгмийн асуудлуудыг шийдэхэд, өөрчлөлт хийхэд эмэгтэйчүүдийг сонгоод үзвэл гэсэн хүлээлт олон нийтэд байна.** 2021 онд ФБЯ-д оролцогчид эмэгтэй улс төрчийг манлайлагч гэж үзэхдээ өөрчлөлтийг хийх чадварт үндэслэн тайлбарласан.

## Дүгнэлт

- Эрэгтэй, эмэгтэй “аль аль нь” манлайлагч гэсэн төвийг сахисан хандлага давамгайлсан үр дүн илэрлээ.
- Бусдад үлгэрлэх, сэтгэн бодох чанарыг эрэгтэйд, бусдад үлгэрлэх, хариуцлагатай байх, боломж олгох, бусдыг ойлгох, шударга хандах чанаруудыг эмэгтэйд хамаатуулснаас харахад манлайлагчдад байх олон чанарыг эмэгтэйд илүү гэж олон нийт дүгнэж байна. Хэдийгээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиныг нь ерөнхий утгаараа манлайлагч гэж итгэх хандлага давамгайлсан ч, эрэгтэйг ерөнхий утгаар манлайлагч гэж үнэлэх нь арай илүү байна. Мөн эрэгтэй нь эрэгтэйгээ, эмэгтэй нь эмэгтэйгээ “илүү” гэж хүлээн зөвшөөрсөн хүйсийн хамаарал ажиглагдав.
- Шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээж байна. Эрэгтэй улс төрчөөс шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанаруудыг, эмэгтэй улс төрчөөс шийдэмгий, тэмцэгч, бусдыг ойлгодог чанаруудыг илүүтэй хүлээх болжээ. Эрэгтэй, эмэгтэй улс төрчөөс хүлээж буй гурван чухал чанарт бусдыг ойлгох чанарыг багтаах болсон нь нэгд, улс төрчийг эршүүд хэвшмэл дүрээр хүлээх нь өөрчлөгдөж байгааг, хоёрт, нийгмийн бүлгүүдийн олон талт байдлыг ойлгох чадамжтай улс төрч хэрэгцээтэй болж буйг харуулж байна.
- Эмэгтэй улс төрчөөс эрэгтэйлэг чанар, улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан, нэр дэвшиж байсан зэргээр туршлагатай, нийтийн төлөөх тодорхой (имиж бүрдүүлсэн) үйл хэрэгт манлайлан оролцдог зэргээр танигдсан, ажил хэрэгч-эмэгтэйлэг, амьдрал сайн мэддэг, нээлттэй гэсэн дүр төрхийг олон нийт хүсэн хүлээж байна.
- “Одоогийн Монголын нийгмийн асуудлуудыг шийдэхэд, авлигыг бууруулж шударга ёсны төлөө өөрчлөлт хийх үйл хэрэгт эмэгтэй улс төрчийг сонгоод үзвэл” гэсэн хүлээлт байгаагаа олон нийт илэрхийлж байна.



## Дүгнэлт

# НЭГ. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

Гурван хувьсагчийн нэгтгэсэн дүнгээр эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо, төлөөллийг дэмжих хандлагатай оролцогчдын тоо (арван хүний долоо) зонхилж байна. Тодруулбал, эрэгтэй оролцогчдын хувьд эрэгтэй улс төрчийг дэмжих хандлага нь буурч, харин эрэгтэй, эмэгтэй улс төрчийг аль алиныг болон эмэгтэй улс төрчийг дэмжих хандлага өссөн байна. Эмэгтэй оролцогчдын хувьд мөн адил эмэгтэй хүнийг дэмжих хандлага өсөж, эрэгтэй улс төрчийг дэмжих хандлага буурсан байна.

Олон нийтийн зүгээс эмэгтэйчүүдийг төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох түвшинд ажиллаж чадна гэдэгт эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн дийлэнх олонх буюу 87.4- 91.7 хувь нь итгэлтэй байна.

2021 онд судлагдсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүд ялгаагүй ихэнх нь (66.6-69.6 хувь) эрэгтэй хүнд саналаа өгсөн. Харин 2024 оны судалгааны дүнгээр эрэгтэй хүнд саналаа өгсөн хэмээн хариулсан оролцогчдын тоо 2021 онтой харьцуулахад буурсан байгаа нь судалгааны зорилтот орон нутаг өөрчлөгдсөнтэй холбоотой хэмээн үзэж байна. Ямар хүйсийн нэр дэвшигчдэд саналаа өгснийг хүйсээр шинжлэхэд эмэгтэй сонгогчид эмэгтэй нэр дэвшигчдийг сонгосон байдал өндөр илэрлээ. Энэ нь 2021 оны судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн ихэнх нь адил шинж бүхий нэр дэвшигчээс эмэгтэй нэр дэвшигчийг дэмжинэ хэмээн хариулсан дүнгээс 2024 оны судалгааны дүн өссөн байгаа тул эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжих хандлага хэвээр байгааг харууллаа.

2021 оны судалгаанд оролцогчдын ихэнх нь хөрөнгө мөнгийг чухалчлаагүй бол 2024 онд энэ хандлага бага зэрэг (4-5 хувь) өссөн. 2024 оны судалгаагаар, эмэгтэйчүүдийн дунд хөрөнгө чинээг чухалчлах хандлага бага зэрэг өссөн төлөв ажиглагдаж байна. 2024 оны судалгаагаар шинэ, залуу улс төрч эмэгтэйг дэмжсэн хувь 2021 оны судалгаанаас 16 хувиар, шинэ, залуу улс төрч эрэгтэйг дэмжсэн хувь 2 орчим хувь өссөнөөс харахад залуу улс төрчийг, ялангуяа залуу эмэгтэй улс төрчийг сонгох хандлагатай байна.

2021 оны судалгаагаар УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг судалгаанд оролцогчдын 42 хувь нь хангалтгүй гэж үзсэн бол 2024 оны судалгаагаар 50.2 хувь (8 хувиар өндөр) нь ийн дүгнэсэн байна. Өмнөх судалгааны адилаар УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 56.3 хувь нь хангалтгүй гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 57.3 хувь нь боломжийн, хангалттай гэж үзсэн бөгөөд ийнхүү төлөөллийн бодит байдлыг дүгнэх үнэлгээ хүйсээс хамаарч ( $\chi^2 = 22.329$ ,  $p < .000$ ) байна. Гэхдээ сүүлийн гурван жилийн хугацаанд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй гэж үзсэн оролцогчдын хувь өсөж байгаа учраас шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийн талаарх хэвшмэл үзэл буурч байна.

Хангалтгүй байгаа шалтгааны талаарх 2021 оны судалгааны дүнг 2024 оны судалгааны дүн дахин давтсан бөгөөд эцгийн эрхт ёсны бүтэц, соёлын


болон улс төрийн хүчин зүйлсийг тодруулбал, улс төрийн намын эрх мэдэл эрэгтэйчүүдэд төвлөрсөн байдал, хууль, эрх зүйн орчны дэмжлэг сул байдал, улс төрийн намын эмэгтэйчүүдийг үл дэмжсэн дотоод бүтэц, соёлыг парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байгаагийн үндсэн шалтгаан гэж үзэж байна. Харин эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргийн ачаалалтай холбон тайлбарласан оролцогчдын жин 2021 оны судалгаатай харьцуулбал буурчээ. Ийнхүү жендэрийн харилцаанд далд байдлаар нөлөөлөгч хүчин зүйлсийг олон нийт ойлгож хүлээн авах болсон байна. УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг хангалтгүй байгаагийн шалтгааныг эцгийн эрхт ёсны бүтэц, соёлоо дэмжсэн, зөвтгөсөн хариулт өгөгсөд 2021 оны судалгаагаар жин дарж байсан бол энэ удаагийн судалгаагаар ийм хандлага бүхий оролцогчдын тоо 2.4 дахин бага түвшинд илэрлээ.

Жендэрийн хэвшмэл үзэлтэй судалгаанд оролцогчид эмэгтэйчүүдийн улс төр, шийдвэр гаргах түвшин дэх оролцоог үл дэмжих хандлагатай болох нь 2021 болон 2024 оны судалгаагаар давхар батлагдаж байна. Судалгаанд оролцогчдын дунд 2021 оны судалгааны дүнгийн адилаар жендэрийн дүр үүргийн төсөөлөлд хэвшмэл үзэлгүй байдал талаас илүү хувьд илэрч байна. Гэхдээ гэрийн ажлын үүргийг эмэгтэйд, тэжээх үүргийг эрэгтэйд оноох хэвшмэл үзэл хамгийн олон хүнд амь бөхтэй байсаар байгааг 2 судалгааны дүн давхар нотолж байна. Олзуурхууштай нь, өрхийн хөдөлмөрийн хуваарь, нийгэм-улс төрийн үйл ажиллагаан дахь оролцооны тухай төсөөлөлд 2021 онтой харьцуулбал хэвшмэл үзлээр хандагсдын хувийн жин буурчээ. Гэсэн ч эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнх ялгаагүйгээр өрхийн хөдөлмөрийн жендэрийн хуваарьт хэвшмэл үзлээр хандаж байгаа бөгөөд гэхдээ хүүхэд асрах үүргийг эмэгтэйд оногдуулах хандлага эмэгтэйчүүдэд, тэр дундаа боловсрол багатай эмэгтэйчүүдийн дунд хүүхэд асрах үүргийг эмэгтэйд бүрэн хамаатуулах хэвшмэл үзэл түлхүү байна.

Судалгаанд оролцогчдын гуравны нэг нь эрэгтэй, эмэгтэй хүний улс төрийн оролцооны талаар хэвшмэл үзэлтэй байна. Энэхүү хандлага тоон судалгааны баримтаар хүйсийн хувьд ялгаатай илэрсэнгүй. Мөн удирдах ажил эрхлэх, манлайлагчаар эмэгтэй хүн байж болно гэдэгт хэвшмэл бус үзлээр хандагсад зонхилж байгаа бөгөөд эмэгтэй хүнд үл итгэх хандлага 2021 оны дүнтэй харьцуулахад 2.5-8 хувиар бага байна. Гэхдээ эмэгтэйчүүдэд үл итгэх байдал эрэгтэйчүүдэд үл итгэхээс ямагт өндөр байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд олон нийтийн зүгээс улс төрд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдэж чадсан гэж эмэгтэй улс төрчдийн дийлэнх нь эерэг хариулт өгснөөс харахад эмэгтэй улс төрчдийн хувьд нэлээд өөдрөг, итгэлтэй байгаа дүр зураг ажиглагдлаа. Харин бараг 5 эрэгтэй хүн тутмын нэг нь эмэгтэйчүүдийг дэмжих суурь бэлтгэгдээгүй гэж үзэхдээ шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тууштай манлайлал сул, оролцоо тааруу байгаатай холбожээ. 2024 оны судалгаанд оролцсон улс төрчдийн олонх нь сонгогчийн боловсрол хангалтгүй, олон нийт эмэгтэй улс төрчдөд илүү хатуу ханддаг, олон нийт эмэгтэй улс төрчийг түрүүлж буруутгадаг нь эмэгтэйн улс төрчийн карьерт илүүтэй нөлөөлдөг сөрөг хүчин зүйлс хэмээн дүгнэж байна.

2021, 2024 оны судалгаагаар аль нэг шатны сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь 10-20 жилийн өмнөх үетэй харьцуулахад олон нийтийн дэмжлэг харьцангуй сайжирсныг тэмдэглэж байна. Гэхдээ эмэгтэй улс төрчийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагаас улбаатай хүмүүсийн хэвшмэл ойлголт, сонгогчийн боловсрол, эмэгтэйчүүдийн хөрөнгө санхүүгийн чадамж, эмэгтэйчүүдийн гэр бүлийн байдал, эмэгтэйчүүдэд хандах хандлагатай



холбоотой хүндрэл бэрхшээлүүд байгааг судалгаанд оролцсон эмэгтэй болон эрэгтэй улс төрчид аль аль нь илэрхийлсээр байна.

2021 оны судалгааны адилаар иргэд эрэгтэй, эмэгтэй улс төрчийн талаар холимог мэдээлэл авах нь давамгайлж байна. Түүнчлэн, эрэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл сөрөг байсан гэх хариулт эмэгтэй улс төрчийнхөөс илүү байна. Гэхдээ бүлгийн ярилцлагын үеэр эмэгтэй улс төрчийн хувийн болон ажил хэргийн амьдрал, үйл ажиллагааны талаарх олон янзын сөрөг мэдээ дурдаж байснаараа онцлог.

## ХОЁР. КВОТ ТОГТООХ АРГЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА

Квот тогтоохыг мэдэхгүй хүн амд хүйсийн хувьд эмэгтэйчүүд, залуу насны хүн ам, хөдөөгийн хүн ам, баруун аймгийн угсаатны бүлгийн хүн амд квотын аргыг мэдэх нь хамгийн бага хувьтай илэрлээ. Хоёр судалгаагаар квотыг мэдэхгүй хүн амын эзлэх хувь өндөр ч 2021 онтой харьцуулахад мэддэг хувь нэмэгдэж, чанарын судалгааны дүнгээр мэдэх хүсэл эрмэлзэлтэй байгаа үр дүн ажиглагдаж байна.

2021 оны судалгаанд оролцогчдын санал болгосон квотын дээд түвшин 80 хувь байсан бол 2024 онд 100 хувийн түвшинг санал болгожээ. 2021 оны судалгаанд оролцогчдын санал болгосон квотын түвшинг дундажлан тооцоолбол 36.67 хувь, 2024 онд 42.27 (голч 40) хувь болж өссөн байна. Эмэгтэй оролцогчид 2021 онд дунджаар 39.14 хувийн, 2024 онд 43.78 хувийн квот санал болгосон. 2021, 2024 онуудын судалгааны дүнгээр, эрэгтэй, эмэгтэйчүүдийн санал болгосон квотын хэмжээ өсөж, ялангуяа эмэгтэйчүүд тухайн онуудад хуульчилсан квотын хэмжээг ахиулахыг санал болгосон хувийн жин өндөр илэрч байна.

2021 болон 2024 оны тоон судалгааны дүнгээр квотын аргыг мэддэг иргэд 40:60 гэсэн харьцаагаар квот тогтоохыг дэмжсэн бол чанарын судалгааны дүнгээр, хүн амын 50-иас илүү хувийг эзэлдэг, тэгш эрхийн зарчмыг хангах үүднээс 50/50-ыг дэмжиж байна.

2021 онд нэр дэвшүүлэх доод түвшин болох квотыг давуу тал, боломж гэж голдуу эрэгтэй оролцогчид үзэж байсан бол 2024 онд сонгуулийн хууль эрх зүйн шинэтгэл хийсэнтэй холбоотой эмэгтэй улс төрчид квот нэмэгдсэн болон жагсаалтыг “боломж” гэж харж байна.

## ГУРАВ. ЭМЭГТЭЙ УЛС ТӨРЧИЙН МАНЛАЙЛЛЫН ТАЛААР

2021 онд тоон судалгааны дүнгээр эрэгтэй, эмэгтэй “аль аль нь” манлайлагч гэсэн төвийг сахисан хандлага давамгайлж байсан дүн 2024 онд мөн адил илэрлээ. 2021 онд байгууллага удирдах, бусдад нөлөөлөх чанарууд, шударга хандах, шинийг санаачлах, сэтгэн бодох чанаруудыг эрэгтэйд, хариуцлагатай байх, бусдад үлгэрлэх, боломж олгох, шударга хандах, бусдыг ойлгох чанаруудыг эмэгтэйд, 2024 онд бусдад үлгэрлэх, сэтгэн бодох чанарыг эрэгтэйд, бусдад үлгэрлэх, хариуцлагатай байх, үлгэрлэх, боломж олгох, бусдыг ойлгох, шударга хандах чанаруудыг эмэгтэйд хамаатуулснаас харахад манлайлагчид байх олон чанарыг эмэгтэйд илүү гэж олон нийт дүгнэж байна. Хэдийгээр судалгаагаар эрэгтэй, эмэгтэй хүнийг аль алиныг нь ерөнхий утгаараа манлайлагч гэж итгэх хандлага давамгайлж байсан ч, эрэгтэйг ерөнхий утгаар манлайлагч гэж үнэлэх нь арай илүү жин дарж байна. 2021, 2024 онуудад эрэгтэй нь эрэгтэйгээ, эмэгтэй нь эмэгтэйгээ “илүү” гэж хүлээн зөвшөөрсөн хүйсийн хамаарал ажиглагдав.

2021 онд олон нийт шийдэмгий, зоригтой, тэмцэгч, бусдыг ойлгодог чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээж, улс төрчийг эрэгтэй чанараар тодорхойлж, эрэгтэй, эмэгтэй улс төрчийн аль алинаас нь эрэгтэй улс төрчдөд хамаатуулдаг шийдэмгий, зоригтой, тэмцэгч гэсэн чанаруудыг илүү ихээр хүсэж байв. 2024 онд шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанарыг улс төрийн манлайлагчаас хүлээж байна. Эрэгтэй улс төрчөөс шийдэмгий, зоригтой, бусдыг ойлгодог чанаруудыг, эмэгтэй улс төрчөөс шийдэмгий, тэмцэгч, бусдыг ойлгодог чанаруудыг илүүтэй хүлээх болжээ. 2021 онтой харьцуулахад бусдыг ойлгох чанарыг эрэгтэй, эмэгтэй улс төрчөөс хүлээж буй гурван чухал чанарт багтаах болсон нь нэгд, улс төрчийг эршүүд хэвшмэл дүрээр хүлээх нь өөрчлөгдөж байгааг, хоёрт, нийгмийн бүлгүүдийн олон талт байдлыг ойлгох чадамжтай улс төрч хэрэгцээтэй болж буйг илтгэх юм.

2021 онд эмэгтэй манлайлагчид эрэгтэйчүүдээс хүлээдэг чанарууд, улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан, нэр дэвшсэн, нийтийн төлөөх тодорхой (имиж бүрдүүлсэн) үйл хэрэгт манлайлан оролцдог, ажил хэрэгч-эмэгтэйлэг дүр төрх бүхий, амьдрал сайн мэддэг, нээлттэй ил тод эмэгтэй улс төрчийг олон нийт хүсэн хүлээсэн үр дүн гарсан. 2024 онд 2021 оны судалгааны үр дүнг давтсанаас гадна шударга, одоогийн Монголын нийгмийн асуудлуудыг шийдэхэд, авлигыг бууруулж шударга ёс тогтоох өөрчлөлт хийхэд эмэгтэйчүүдийг сонгоод үзвэл гэсэн хүлээлт олон нийтэд байна.

Чанарын судалгааны 2024 оны мэдээллээс харахад эрэгтэйчүүдийн дунд эмэгтэй хүнийг манлайлагч гэж хүлээн зөвшөөрөхөөсөө эрэгтэйчүүд манлайлагч гэх үзэл бодол давамгайлж, “эрэгтэй хүнийг дөвийлгөн магтсан атлаа эмэгтэй хүйсийг дорд үзэх” зэргээр хэвшмэл үзэл илүү илэрч байна. Харин эмэгтэй оролцогчдын дунд эрэгтэйчүүдийг манлайлагч болохыг хүлээн зөвшөөрсний зэрэгцээ нас, үндэс угсаа, байршлаас үл хамааран эмэгтэй хүнийг манлайлагч гэдгийг хүлээн зөвшөөрч буйгаа илтгэх, хүлээн зөвшөөрүүлэхээр чармайсан үндэслэлүүд дэвшүүлсэн зэргээр хүйсээр ялгаатай байдал илэрсэн. Мөн салбарын хувьд ялгаатайгаар жендэрийн хэвшмэл үзэл бүхий хандлагаар удирдлага, манлайллыг авч үзэж буй нь эрүүл мэнд, боловсролоос бусад салбарт, тэр дундаа өндөр албан тушаал, шатлалын оройд байх албан тушаалыг

эрэгтэй хүнд хамаатуулж байгаагаар нотлогдож байна. Гэхдээ удирдлага дахь эмэгтэйчүүдийн тоон өсөлт, бодит кейс, туршлага нь улс төр дэх оролцоонд илрэх жендэрийн хэвшмэл үзлийн хязгаарлалтыг бууруулахад чухал нөлөөтэй байна. Манлайлагчийн чанараар задалж асуухад эмэгтэйчүүдэд тэдгээр чанар давамгайл гэдгийг хүлээн зөвшөөрөх атлаа ерөнхийлөн асуухад эрэгтэй хүнд хамаатуулан хандлага байгаа нь жендэрийн хэвшмэл үзлээр дүрийг ерөнхийлөн тодорхойлж байгаатай холбоотой юм.

ТМЯ-д оролцсон улс төрчид эмэгтэй улс төрчийн хувийн сул талд зориггүй тууштай биш, өөртөө итгэлгүй, идэвхгүй, ямар нэг нэр хоч зүүх вий (эрэгтэй улс төрчтэй нэр холбогдох вий) гэсэн айдас, болгоомжлол зэргийг өмнөхийн адил нэрлэснээс гадна улс төрийн мэдлэг боловсрол, туршлага дутмаг, нэгдмэл баг болж ажиллаж чаддаггүй байдалд түлхүү анхаарав. Институтийн хүчин зүйлсэд эрэгтэй давамгайлсан улс төрийн намын бүтэц, дээрээс доош чиглэсэн “дарга төвт” засаглалын харилцаа, санхүү, мөнгөний хүчин зүйлс, ар гэрийн ачаалал, дэмжлэг сул байдал, олон нийтийн ойлголт хандлага зэргийг багтаав. Эрэгтэй улс төрчдөд эмэгтэй улс төрчид тээг болдог институтийн хүчин зүйлсийг дурдаж, анхаарал хандуулах болсон дэвшил гарчээ.

## Зөвлөмж

**Нэг. Олон нийтийн дундах жендэрийн хэвшмэл үзлийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулж, хууль тогтоомж, тэр дундаа хуулиар тогтоосон хүйсийн квотын хэрэгжилтийг хангахад салбар дундын, үр дүнтэй, олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:**

### 1. Хэвлэл мэдээллийн оролцоо:

- Хэвлэл мэдээллийн бүтээлийн агуулга болон эх сурвалжид жендэрийн тэгш, тэнцвэрт байдлын үнэлгээг тогтмол хийж тайлагнадаг механизмыг бий болгох,
- Жендэрийн хэвшмэл үзлийг дэвэргэхгүй байж, хүйсээр ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, хүний эрхийг дээдлэх хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагатай хамтран ажиллах, байгууллагын чадавхыг бэхжүүлэх,
- Хэвлэл мэдээллийн бүтээлийн агуулгад жендэрийн хэвшмэл ойлголтыг өөгшүүлэхгүй байх зарчмыг хэвлэл мэдээллийн байгууллагын редакцын бодлогод тусган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох,
- Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч, уран бүтээлчдийг энэ чиглэлд уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх бүх арга хэрэгслүүдийг дэмжих. Үүнд чадавхжуулах сургалт, уулзалт хэлэлцүүлэг, мэдлэг, сайн туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулах.

### 2. Чадавх бэхжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ:

- Жендэрийн хариуцлагатай шийдвэр гаргах үйл явцыг дэмжих, бодлогын хэрэгжилтийн уялдаа холбоог хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага олон нийтийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх олон талт арга хэмжээ- туршлага судлах, санал солилцох уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг бүх түвшинд тогтмол зохион байгуулах,
- Нийгмийн харилцааны тэр дундаа хөдөлмөрийн хуваарь, гэр бүлийн болон улс төрийн харилцаанд хүн бүр эрх тэгш оролцоотой байх манлайллыг бэхжүүлэх, ур чадварыг бий болгоход чиглэсэн сургалт, менторшип хөтөлбөрүүдийг зохион байгуулах.

### 3. Нөлөөллийн кампанит ажил:

- Жендэрийн хэвшмэл үзэл, түүний нийгэм, улс төрд үзүүлэх нөлөөлөл, хууль тогтоомжийн хэрэгжилт тэр дундаа хуулиар тогтоосон хүйсийн квотын ач холбогдлын талаар олон нийтэд таниулах ойлгуулах зорилго бүхий хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээний томоохон кампанит ажил тогтмол өрнүүлэх,
- Уламжлалт жендэрийн үүргийн талаарх хэвшмэл үзлийг халах, нийгмийн харилцааны бүх салбарт жендэрийн тэгш байдлын ач холбогдлыг харуулсан цогц кампанит ажлыг төр, хувийн хэвшил төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд тогтмол хэрэгжүүлэх. Тухайлбал, төр хувийн хэвшлийн хэрэгжүүлж буй сайн туршлага санаачилга, нийгмийн бүлгүүдийн нөлөө бүхий, танил, эерэг дүрүүдийн бодит түүх, сайн жишээ туршлагыг түгээн дэлгэргүүлэх.

#### 4. Талуудын хамтын ажиллагаа:

- Жендэрийн хэвшмэл үзлийг бататгасан эсхүл дэвэргэсэн бодлого, арга хэмжээг халах, жендэрийн нийгмийн хэм хэмжээг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн кампанит ажлуудыг ТББ, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон бусад оролцогч талуудтай хамтран зохион байгуулах,
- Хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагын санаачилга, сайн туршлагыг дэмжиж хамтран ажиллах замаар жендэрийн тэгш байдлыг хангахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх хөшүүрэг, арга механизмыг бий болгох,
- Жендэрийн хэвшмэл үзлийг халах, хүйсийн квотыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн байгууллага, хувийн хэвшлийн компани, ТББ-уудын хамтарсан санаачилга, хөтөлбөр төслүүдэд дэмжлэг үзүүлэх.

**Хоёр. Хууль эрх зүйн шинэчлэлийн хэрэгжилтийг хангаж, улс төрийн намын дотоод ардчилал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг дэмжих соёлыг бэхжүүлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:**

##### 1. Эрхзүйн шинэчлэлийн хэрэгжилтийг хангах механизмыг бий болгох;

- Улс төрийн намын жендэрийн тайланг жил бүр хүлээн авдаг, олон нийтэд мэдээлэх механизмыг Жендэрийн Үндэсний хороо бүрдүүлэх,
- Улс төрийн намуудад жендэрийн тайланг үндэслэн дүгнэлт, арга зүйн зөвлөмжөөр Жендэрийн үндэсний хороо хангах,
- Нам иргэдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэх үйл ажиллагаандаа жендэрийн хэвшмэл үзэл, өрөөсгөл хандлагыг өөрчлөх зорилго бүхий агуулга нэвтрүүлэх.

##### 2. Улс төрийн намын дотоод ардчиллыг бэхжүүлэх;

*Бүтэц, тогтолцоо:*

- Намын бүх гишүүдэд нээлттэй, ил тод оролцоог хангах, олон ургалч байдлыг дэмжих бүтэц, механизмыг бэхжүүлэх,
- Намын бодлого, үйл ажиллагаа нь хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдалд нийцэж байгаа эсэхийг тодорхой давтамжаар жендэрийн өөрийн үнэлгээ, жендэрийн аудит гэх мэт аргачлалыг ашиглан үнэлэх чиг үүрэг бүхий бүтцийн нэгж /түр байж болох/ байгуулах, эсвэл механизмыг бэхжүүлэх.

*Дүрэм журам, бодлого:*

- Нам өөрийн дотоод бүтэц, албан тушаалуудад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангах түр арга хэмжээг /суудал хадгалах, квот, “тархины ангуучлал”(headhunting) хийх гэх мэт/ авч хэрэгжүүлдэг байх,
- Намын дүрэм, журамд үйл ажиллагааг эдийн засгийн болон бусад бүлэглэлээс ангид, нийгмийн олон талт байдлыг хангах, хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй байхаар шинэчлэн найруулах,
- Сонгуульд болон төрийн өндөр албан тушаалд нэр дэвшүүлэх, намын





удирдлагын бүтцэд томилох үйл явцыг тодорхой, хүртээмжтэй, ил тод болгох.

- Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, аливаа төрлийн хүчирхийллээс ангид байж, урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэх хүртээмжтэй, ил тод механизмыг бүрдүүлэх.

### **3. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг дэмжсэн соёлыг бэхжүүлэх:**

- Эрэгтэй давамгайлсан улс намын дотоод соёлыг эерэгжүүлэх олон талт арга хэмжээ, санаачилга, нөлөөллийн ажлыг нам дотроо хэрэгжүүлэх. Үүнд: Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих, сурталчлан таниулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, намын жендэрийн манлайлагчдыг тогтмол бэлтгэх гэх мэт,
- Намын гишүүдэд жендэрийн тэгш эрх, нийгмийн олон талт төлөөллийн ач холбогдол, үүний талаарх мэдлэг, хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг чадавхжуулах, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд: Менторшип, коучинг, манлайллын сургалт гэх мэт,

## Хавсралтууд

Хавсралт 1. Асуулгын судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт, хувиар

	Улаанбаатар	Баян-Өлгий	Ховд	Завхан	Өвөрхангай	Дархан-Уул	Орхон	Хэнтий	Бүгд
Төрийн байгууллагад	25.6	54.4	35.6	17.5	31.6	13	46.2	46.3	31.3
Хувийн хэвшлийн байгууллагад	23.9	14.9	6.7	16.3	23.1	28.3	18.7	10	20.2
ОУБ	0.4	0	0	0	0	3.3	0	0	0.5
ТББ	2.2	0	1.1	2.5	2.6	1.1	0	1.3	1.7
Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	14	12.3	12.2	32.5	15.4	27.2	11	3.8	15.2
Өндөр насны тэтгэвэрт	14	6.1	11.1	16.3	6.8	15.2	9.9	32.5	13.5
Нийгмийн халамжийн тэтгэмж авагч	2.4	0.9	1.1	0	2.6	2.2	2.2	0	1.8
Малчин	1.3	4.4	21.1	11.3	9.4	2.2	3.3	1.3	4.8
Оюутан	4.5	3.5	5.6	1.3	0.9	2.2	1.1	0	3.2
Ажилгүй	7.1	3.5	5.6	2.5	5.1	4.3	5.5	2.5	5.5
Хүүхэд, гэр бүлийн гишүүнээ асардаг	4.7	0	0	0	2.6	1.1	2.2	2.5	2.8
Нийт	100	100	100	100	100	100	100	100	100

Хавсралт 2. Асуулгын судалгаанд оролцогчдын яс үндэс, нас, хүйс болон хувиар

	Халх	Казак	Өөлд	Урианхай	Дөрвөд	Буриад	Захчин	Баяд	Мянгад	Бусад
Насны бүлэг										
18-24	76.1	12	0.9	0	1.7	0	6.8	0	1.7	0.9
25-29	73.8	9.2	1.5	1.5	2.3	1.5	2.3	1.5	4.6	1.5
30-34	74.8	13.5	0.6	0	3.1	1.8	3.1	1.8	0	1.2
35-39	74	17.5	0	2.6	1.3	1.3	1.9	0.6	0	0.6
40-44	77.4	9.6	1.7	1.7	2.6	0.9	3.5	0	1.7	0.9
45-49	73.8	6.6	0.8	3.3	1.6	2.5	5.7	2.5	1.6	1.6
50-54	74.1	14.7	1.7	0.9	0.9	2.6	2.6	0	1.7	0.9
55-59	75.8	10.5	1.2	1.1	2.1	1.1	3.2	1.1	2.1	2.1
60-64	84.1	8.5	1.2	1.2	1.2	0	1.2	1.2	1.2	0
65-69	81.6	0	2	0	4.1	6.1	4.1	2	0	0
70+	75.4	10.5	0	0	7	3.5	0	3.5	0	0
Хүйс										
Эрэгтэй	73.3	12.2	1.3	1.7	3.1	1.8	3.7	1.3	0.9	0.7
Эмэгтэй	77.9	10.4	0.8	0.9	1.5	1.5	2.9	1.1	1.8	1.2
Нийт	75.8	11.2	1.0	1.2	2.3	1.7	3.3	1.2	1.4	1.0

Хавсралт 3. Хэн нь манлайлагч вэ? (хүйс, насаар)

		Эрэгтэй хүн бол манлайлагч	Эмэгтэй хүн бол манлайлагч	Ялгаагүй
Эр	Залуу	<ul style="list-style-type: none"> <li>■ Нөхрийгөө Та гэж хүндэтгэдэг, уламжлалтай</li> <li>■ Өрхийн тэргүүн</li> <li>■ Байгалиасаа эрэгтэйчүүд манлайлах чадвартай</li> <li>■ Түшиг тулгууртай</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>■ Аль ухаантай нь манлайлдаг</li> <li>■ Мэдлэг боловсрол, харизмаараа манлайлдаг</li> </ul>
	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>■ Шийдэмгий,</li> <li>■ Зоримог</li> <li>■ Зорилготой</li> <li>■ Тууштай</li> <li>■ Хэлье гэснээ хэлчихдэг</li> <li>■ Ар гэрээ авч явдаг</li> <li>■ Сэтгэн бодох чадвар илүү</li> <li>■ Засгийн газар, орон нутгийн удирдлагад тохиромжтой.</li> <li>■ Өөрийгөө илэрхийлэх чадвартай</li> <li>■ Туршлагатай</li> <li>■ Удирдах чадвартай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэй хүн жижгээр детальчилж хардаг</li> <li>■ Сайн манлайлагч эмэгтэйчүүд олон боловч улс төрийн тавцанд өөртөө итгэлгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Манлайлал хүйсээс хамаарахгүй</li> <li>■ Боловсролтой бол манлайлна</li> <li>■ Уламжлалаас болоод эрэгтэйчүүд манлайлдаг гэж үзээд байгаагаас бус эрэгтэй эмэгтэй ялгаагүй</li> <li>■ Хувь хүн талаас харж байж хэлэх ёстой</li> <li>■ Чадвараар л тодорхойлогдоно</li> </ul>
	Ахмад	<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэйчүүдээс тулга тойрсон хэрүүл салахгүй тул</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэйчүүд боловсролтой</li> <li>■ Эмэгтэйчүүд олноороо гарвал арай бага иднэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Аль аль нь манлайлах чадвартай.</li> <li>■ Ард түмний төлөө явж чадах нь</li> </ul>
Эм	Залуу	<ul style="list-style-type: none"> <li>■ Дээгүүр албан тушаалд эрчүүд л байдаг</li> <li>■ Шийдэмгий</li> <li>■ Тууштай</li> <li>■ Итгэл үнэмшилдээ бат зогсож чаддаг</li> <li>■ Бусадтай харилцах чадвар сайтай</li> <li>■ Бусдыг нэгтгэж чаддаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Шударга</li> <li>■ Тууштай</li> <li>■ Хөдөлмөрч</li> <li>■ Цаг наргүй, тоймлож биш нягталж хийдэг</li> <li>■ Юмсыг нарийн хардаг</li> <li>■ Бусдыг илүү ойлгодог</li> <li>■ Нягт нямбай байдаг</li> <li>■ Хойш суудаггүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Хувь хүний хөгжил, боловсролоос шалтгаална</li> </ul>
	Дунд	<ul style="list-style-type: none"> <li>■ Ноён нуруутай</li> <li>■ Холыг хардаг</li> <li>■ Эрт дээр үеэсээ эрэгтэйчүүд манлайлдаг</li> <li>■ Цаг зав гаргадаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Нягт нямбай</li> <li>■ Хайнга биш</li> <li>■ Шийдвэртээ бат бөх</li> <li>■ Хүний нөлөөнд орохгүй</li> <li>■ Шударга</li> <li>■ Олон ажлыг зэрэг амжуулдаг</li> <li>■ Хөрвөх чадвартай</li> <li>■ Тэвчээртэй</li> <li>■ Нухацтай</li> <li>■ Ул суурьтай</li> <li>■ Хүнлэг</li> <li>■ Бүх хүрээнд ачаалалтай</li> <li>■ Боловсролтой</li> <li>■ Үлгэрлэн дагуулдаг</li> <li>■ Арчаатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Юм хийж бүтээсэн хүн манлайлагч</li> <li>■ Хүйсээс хамаарахгүй</li> </ul>

	Ахмад	<ul style="list-style-type: none"> <li>Улс төр, эдийн засгийн эрх мэдэл эрэгтэйчүүдэд байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Давуу тал ихтэй ч илтгэж чаддаггүй</li> <li>Ар гэрээ авч явдаг</li> <li>Ачаалал дааж чаддаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдийн манлайлах чадвар илүү ч улс төрд цөөн байгаа нь хэвшмэл ойлголтын үр дагавар</li> </ul>
--	-------	--	---	---

Хавсралт 4. Эмэгтэй улс төрчдөд үзүүлэх олон нийтийн дэмжлэг. 2021, 2024

	2021	2024
Сэтгэл зүйн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> <li>Сэтгэл санаагаар дэмжин, урам зориг өгдөг.</li> <li>2016 онтой харьцуулахад дэмжлэг сайжирсан, мессеж бичнэ, нүүр тулж уулзана, утсаар ярьж дэмжлэгээ илэрхийлдэг.</li> <li>Жигд дэмжиж ирсэн. Үг яриа, хандлагаас харагддаг. Хашаандаа сайхан амьдрах орчныг дэмжих, ЖДҮ-г дэмжих орон нутгийн төсөвт суулгах гэх мэт.</li> <li>Олон нийтийн сүлжээгээр дэмждэг, эмэгтэйчүүдийн төлөөлөл, нүүр царай болж байна.</li> <li>Эмзэг эрсдэлт бүлгийн болон захын гэр хорооллын иргэдтэй ажилладаг учраас маш их дэмждэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Ард иргэд уулзалт, хурал, ярилцлагын үеэр дэмжиж байгаагаа илэрхийлдэг.</li> <li>Үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулах санал болгоно.</li> <li>Дэмжиж, хамтран ажиллах санал тавьдаг.</li> <li>Фэйсбүүкийн хандалтаар дэмжиж байгаагаа хэлдэг.</li> <li>Бодлого үйл ажиллагааг дэмждэг, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг.</li> <li>Иргэдийн сэтгэл санааны дэмжлэг, урам их ирдэг.</li> </ul>
Итгэл үзүүлсэн	<ul style="list-style-type: none"> <li>Итгэл үзүүлсэн.</li> <li>Итгэснээрээ сонгуульд ялах нэг үндэслэл болсон.</li> <li>Итгэл хүлээлгэж санал бодлоо нээлттэй хуваалцдаг.</li> <li>Дөрвөн удаагийн сонгуулиар нэгээр гарч ирсэн. Мөрийн хөтөлбөр сайн байсан. Итгэж байгааг харуулж байна. Иргэдтэй сайхан харилцдаг. хүндэлдгийн ач буян юм.</li> <li>Эмэгтэй хүний орон зай үгүйлэгддэг. Эмэгтэйчүүдийг ажлын байраар хангахад итгэл хүлээлгэж байгаа шүү гэдэг.</li> <li>Иргэд утсаар холбогддог, эргэх холбоотой байдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Амлалтдаа хүрсэн тул иргэд дахин итгэл хүлээлгэсэн.</li> <li>Үйл ажиллагаа, зорилгыг ойлгоод хамтраад, дэмжээд явна.</li> <li>Анхнаасаа итгэл өгч байсан одоо ч хэвээрээ байгаа.</li> <li>Мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж чадсан тул дэмжлэг өндөр.</li> <li>Олон нийтийн дэмжлэг сонгуулийн үр дүнд нөлөөлж сонгогдсон.</li> <li>Эрүүл шүүмжлэл, алдаагаа засахад тусалж байсан дэмжлэг сайн байсан.</li> <li>Итгэж байгаагаа фейсбүүк, хурал, цуглаан дээр илэрхийлдэг.</li> </ul>
Сайшаал магтаал захиас хэлэх	<ul style="list-style-type: none"> <li>Иргэд их дэмждэг, урмын үг их хэлдэг, амжилт хүсдэг, сайн ажиллаж байгааг хэлдэг, биднийг сайн төлөөлж ажиллаарай гэж захидаг.</li> <li>Уул уурхай, экологийн чиглэлээр зөв ярихад олон нийт маш сайнаар дэмждэг, хөндөх асуудлыг хөндөж зөв дуугарч байна гэж сайшаадаг.</li> <li>Залуу эмэгтэй хүнийг дэмжсэн, амжилт хүссэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Амьдрал мэдэх эмэгтэй хүн илүү амьдралтай шийдвэр гаргана гэж магтдаг.</li> <li>Сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн.</li> <li>Сошиал хандалтад эерэг сэтгэгдэл, санал бичнэ.</li> <li>Тойргийн иргэдээс дэмжсэн санал ирүүлнэ.</li> </ul>

Талархал илэрхийлэх	<ul style="list-style-type: none"> <li>■ Шударга зан чанар талаас нь дэмждэг. Эмэгтэйчүүдийн дуу хоолой болж байгаа учраас олон нийт хүлээн зөвшөөрч талархлаа илэрхийлдэг.</li> <li>■ Иргэдийн тавьсан хүсэлт өргөдлийг өөрийн боломж бололцоонд тулгуурлан шийдвэрлэн ажиллаж талархал хүлээсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Сошиал орчинд, уулзалт, үйл ажиллагаа дээр талархал илэрхийлнэ.</li> <li>■ Баярласнаа утсаар, мессежээр илэрхийлдэг.</li> </ul>
Санхүүгийн дэмжлэг	<ul style="list-style-type: none"> <li>■ Хөрөнгө санхүүгийн хувьд тодорхой хэмжээнд итгэж дэмжлэг үзүүлсэн.</li> <li>■ Зарим тохиолдолд сонгуулийн зардалд хандив өргөдөг.</li> <li>■ Сайн дураараа сонгуулийн сурталчилгаанд ажиллах, санхүүгийн хувьд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлдэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Ухуулга сурталчилгаанд явсан, материал тараасан, цалин аваагүй</li> <li>■ Санхүү, хандив өгсөн.</li> </ul>
Эх сурвалж: ТМЯ		

Хавсралт 5. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эрэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар

Залуу нас	Дунд нас	Ахмад нас
<b>Эмэгтэй хүнийг буруутгасан</b>		
<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэйчүүд зөөлдөөд буулт хийдэг</li> <li>■ Нөлөөлөлд автдаг</li> <li>■ Зоригтой шийдвэр гаргаж чадахгүй байна</li> <li>■ Эрэгтэй улс төрч шиг байхыг хүсэж байна.</li> <li>■ Буруу шийдвэр гаргаж байгаа хүний өөдөөс дуугардаг, улс орны төлөө шийдвэр гаргадаг байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Улс төрийн нам нь дэмждэг ч шийдвэр гаргах ухаантай эмэгтэй цөөн</li> <li>■ Гарч гарч ирсэн улс төрч эмэгтэй нь .... гэж ард түмнээ доромжилдог, олигтой байдаггүй</li> <li>■ Авлигад адилхан холбогдож байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Улс төрд зүтгэх чадвар дутмаг</li> <li>■ Эмэгтэй боловсон хүчнээ бэлтгэх хэрэгтэй.</li> <li>■ Боловсрол тааруу хүмүүс төрд гарч ирээд байгаа</li> <li>■ Сонгохоор эмэгтэйчүүд бас өрсөлдөхгүй байна</li> </ul>
<b>Дүр-үүргийн хүчин зүйлс</b>		
<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэйчүүд хүүхдээ өсгөх, гэрээ харах гэх мэт яг эмэгтэй хүмүүс л хийж чадах ажлууд их</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэйчүүд эрчүүд л намын лидерүүд болох ёстой гэж бодоод намд ордоггүй.</li> </ul>	
<b>УТН дахь эрх мэдлийн бүтцийн хүчин зүйлс</b>		
<ul style="list-style-type: none"> <li>■ Нам, эвсэл цаанаасаа эмэгтэйчүүдийг хумих бодлоготой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Намаас нь гаргахгүй байгаа байх, өөдөөс нь өөр эрэгтэй дэвшүүлэх гэх мэтээр дарж байгаа гэж бодож байна. Намын дотоод бодлогод эмэгтэйчүүдийн оролцоо сул</li> <li>■ Дарга нар нь эрчүүд байна. Квотыг хангахад хяналт тавьдаггүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эмэгтэй хүмүүсийг нэр дэвшүүлэхгүй байгаад гол асуудал байна</li> <li>■ Сонгуулийн хуулиа шинэчлэх хэрэгтэй</li> </ul>

Сонгогчийн хүчин зүйлс		
<ul style="list-style-type: none"> <li>■ Сонгогчдод эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл хомс</li> <li>■ Эмэгтэй хүн шийдвэр гаргах талдаа сул гэж гэж боддог учраас илүү эрэгтэйчүүд байгаа.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Анхнаасаа эмэгтэй ерөнхийлөгч, ерөнхий сайдтай байгаагүй болохоор эмэгтэйчүүдийг сонгохгүй байна</li> </ul>	

Хавсралт 6. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн байгаагийн шалтгааныг эмэгтэйчүүдийн тайлбарласан байдал, насаар

Залуу нас	Дунд нас	Ахмад нас
УТН дахь эрх мэдлийн бүтэц		
<p>Нам нь дэвшүүлдэггүй УТН эмэгтэйчүүдээ дэмждэггүй Манайд цүнх баригч нар эрчүүд тул.</p>	<p>Улс төрийн нам эмэгтэйгээ дараад байна Эмэгтэйчүүдэд квот олддоггүй Чадалтай эмэгтэйчүүдийг гаргадаггүй байх Намын бодлогоор дэмжихгүй байна Эмэгтэй хүмүүс шийдвэр гаргаж байгаа хүмүүстэйгээ санал нийлэхгүй байгаа учраас эрэгтэйчүүдээс дэмжлэг авч чаддаггүй Олигтой тэмцэхгүй байгаа нь саад болоод байна</p>	<p>Нам дотроо дийлэнх нь эрэгтэйчүүд байдаг учраас эрэгтэйчүүдээ дэмждэг Эмэгтэйчүүд эрчүүд шиг хатуу, төв, зоригтой, шаргуу бол дэмжигдэхгүй</p>
Эмэгтэй хүнийг буруутгасан		
<p>Эрчүүд эмэгтэйчүүдийн үгэнд орж удирдуулахгүй байх. Зарим улс төрд байгаа эмэгтэйчүүд нь олигтой ажиллахгүй байна Зарим тохиолдолд эмэгтэйчүүд шийдвэр гаргах чадвар муу байдаг тул хүмүүс итгэдэггүй</p>	<p>Эр хүнийг бодвол эм хүний илтгэх чадвар, өөрийгөө илэрхийлэхдээ муу Улс төрч байх шинж, алсыг харах чадвар муу Одоо байгаа 17 эмэгтэй нөлөөлөхөөр юм хийгээгүй Эмэгтэй улс төрчийн нэр хүндийг зарим улс төрч эмэгтэйчүүд унагадаг</p>	<p>Дан эмэгтэйчүүд байвал улс орон эвгүйтэх байх 70:30 хувьтай байвал зохимжтой Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэггүй, атаархуу. УИХ-д байгаа гишүүд юу хийгээд байна аа, байгаа, үгүй нь мэдэгдэхгүй байна.</p>
Дүр үүргийн хүчин зүйлс		
<p>Жендэрийн хэвшмэл ойлголт Эрэгтэй хүн даргын алба хашдаг тул би чадахгүй, би сонгогдохгүй гэж боддог</p>	<p>Манай эмэгтэйчүүд их даруухан Эмэгтэй хүнээр удирдуулж үзээгүй болохоор давуу тал нь юу байх, хэрхэн өөрчлөлт хийж гарч ирэхийг иргэд сайн мэдэхгүй</p>	<p>Эрэгтэй хүнийг өрхийн тэргүүн гэх мэт бүх л салбарт хүндлээд, тэргүүн гэж үзэх нь эмэгтэйчүүдийг өндөр албан тушаалд ажиллахад нь сөрөг нөлөөтэй байна</p>
<p>Ар гэрийн ачааллаас болоод хийдэггүй байх. Эмэгтэйчүүд хувийн амьдрал, үр хүүхдээ илүү бодсоор улс төрөөр тууштай байж чадахгүй байна</p>	<p>Эмэгтэйчүүд сонгуульд нэр дэвшиж өрсөлдөх идэвх тааруу байна. Гэр бүлийн амьдрал нь нөлөөлж байна.</p>	

Эмэгтэйчүүдийн өөртөө итгэлгүй байдал		
Эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн асар их дарамт, гэр бүлийн дарамт, Эмэгтэйчүүд хэл амнаас айдаг, шантардаг учраас	Эмэгтэйчүүд төрд ажиллахад бүх юмаа хаяад золиослох зориг дутмаг, Тууштай бус	
Сонгогчийн хүчин зүйлс		
Сонгогчдын ухамсраас их шалтгаалж байна Эмэгтэй хүнийг нэр дэвшихээр юу хийх билээ, эрэгтэй хүний өөдөөс олигтой дуугарч чадах уу гэж хүмүүс эргэлзэж ханддаг Эмэгтэй хүний саналыг доогуур үнэлдэг Хүчирхийлэл энээ тэрээ гээд ярихаар гэнэт дуугарлаа гэнэ	Хүмүүсийн ойлголтод түлхүү эрэгтэй хүн удирдаж чадна гэсэн үзэл их Эмэгтэйчүүдийг хэл аманд их оруулдаг Иргэдийнхээ улс төрийн боловсролыг ахиулах ажил хийхгүй байна	
Эмэгтэйчүүдийн олон нийттэй харилцах хүчин зүйлс		
Эмэгтэй хүн өөрийгөө дөвийлгөдөггүй, хийж байгаа зүйлээ нүдэнд харуулдаггүй	Орон нутагт эмэгтэйчүүд олны танил болоогүй	
Сонгуулийн тогтолцоо		
	Сонгуулийн тогтолцоо нөлөөлж байна. Эмэгтэйчүүдэд ээлгүй. Том тойрог эрсдэлтэй	

Хавсралт 7. Квотын аргын талаарх олон нийтийн хандлага

Байршил	Квотын аргыг дэмжих хандлага	
	Эрэгтэй	Эмэгтэй
Нийслэл	<ul style="list-style-type: none"> <li>■ Эрэгтэйчүүд давамгайлж байгаа тул 50/50 хувиар тэнцвэржүүлнэ</li> <li>■ Эмэгтэйчүүд цөөнх учраас квотыг нэмэх хэрэгтэй</li> <li>■ Квотыг хуульчилснаар эмэгтэйчүүд гарч ирэх боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Хүн амд эмэгтэй нь илүү тул 50/50-иар тэнцвэртэй болно</li> <li>■ Эмэгтэйчүүд эрэгтэйчүүддээ дарагддаг тул квот тогтоох зөв</li> <li>■ 50 хувьд хүрч байж эмэгтэйчүүд нэмэгдэнэ</li> <li>■ Уламжлалт соёл нөлөөтэй хэвээр тул квот тогтоох зөв</li> <li>■ 70/30 квот байхад болно</li> <li>■ 50/50 байж хүйсийн ялгаа гарахгүй</li> <li>■ Хуулиар хамгийн багадаа 50 хувьд хүргэснээр эмэгтэйчүүд олноор гарч ирэхэд нөлөөлнө.</li> </ul>
Төвийн бүс	<ul style="list-style-type: none"> <li>■ 40/60 байх хэрэгтэй</li> <li>■ Квотыг ижил түвшинд байлгах хэрэгтэй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Улс төрд эрэгтэйчүүдийн давамгайллаас 50/50 байж тэнцвэржинэ</li> <li>■ Улс төрд эмэгтэйчүүд цөөн тул 50 хувийн квот тогтоох нь зөв</li> <li>■ Квот байснаар улс төрд эмэгтэйчүүд дэмжигддэг</li> <li>■ Эмэгтэйчүүд олноороо улс төрд орж ирэх хэрэгтэй</li> <li>■ 21-р зуунд эмэгтэйчүүд гарч ирж байна, идэвхтэй улс төрөөр явах хэрэгтэй</li> <li>■ Эрэгтэй, эмэгтэйчүүд тэнцүү байх ёстой</li> </ul>

Баруун бүс	<ul style="list-style-type: none"> <li>■ 50/50 байвал зүгээр</li> <li>■ 70/30 гэж бодож байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Хуулиар квотыг 50/50-аар нь тогтоовол эмэгтэйчүүд нэмэгдэнэ</li> <li>■ Шинэ салхи оруулах хэрэгтэй</li> <li>■ Сонгуулиар эрэгтэй, эмэгтэйчүүдийг тэнцүү сонгосноор адил тэгш болно</li> </ul>
Зүүн бүс		<ul style="list-style-type: none"> <li>■ Квот биш, парламентын гишүүн нь 50:50 байх ёстой</li> <li>■ 60/40 байх хэрэгтэй, ядаж 40 хувь байх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй</li> </ul>
Байршил	Квотын аргыг дэмжихгүй хандлага	
	Эрэгтэй	Эмэгтэй
Нийслэл	<ul style="list-style-type: none"> <li>■ Квотоор байр сууриа илэрхийлдэггүй, гарвал хэцүүднэ.</li> <li>■ Хуулиар эмэгтэйчүүдийг хүчээр өсгөх юм байна</li> <li>■ УТН-ууд эмэгтэйчүүд цөөн гэсэн хэл амнаас айж квот тогтоодог.</li> <li>■ Квотгүй байсан ч болно</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Юуны өмнө 70/30 квотоо хэрэгжүүлэх нь чухал байна</li> </ul>
Төвийн бүс	<ul style="list-style-type: none"> <li>■ -Үр хүүхэд, гэр бүлийн ачааллаас эмэгтэйчүүд улс төрөөр явж чадахгүй</li> <li>■ - УИХ-д 13 эмэгтэй гишүүн байгаа нь хангалттай</li> <li>■ -Уг нь 50:50-ийн тэгш байх ёстой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Хүчээр квот тогтоох албагүй, чадалтай нь өрсөлдөөд гарч ирэг</li> <li>■ Хүчээр квот тогтоож эмэгтэйчүүдийг улс төрд оруулах юм байна</li> <li>■ Улс төрөөр явахад ар гэр, хүүхэд орхигдоно</li> </ul>
Баруун бүс	<ul style="list-style-type: none"> <li>■ Шашин, уламжлалт соёлд эмэгтэйчүүд гэрийн ажил хийж, хүүхэд төрүүлэх, асрахад илүү анхаардаг.</li> <li>■ Зөв ч уламжлалт шашинд эмэгтэйчүүдийн үүргийг тогтоосон байдаг.</li> <li>■ Хүчээр квот тогтоохыг дэмжихгүй</li> </ul>	
Зүүн бүс	<ul style="list-style-type: none"> <li>■ Хүчээр квот тогтоогоод эмэгтэйчүүд улс төрд орохгүй бол яах вэ?</li> </ul>	



Хавсралт 8. Манлайлагчаар үзэж буй үндэслэл, харьцуулсан онуудаар

2021	2024	2021	2024
Эрэгтэй улс төрч		Эмэгтэй улс төрч	
<ul style="list-style-type: none"> <li>■ Шударга</li> <li>■ Шийдэмгий</li> <li>■ Зоригтой</li> <li>■ Дайчин, тэмцэгч</li> <li>■ Ноён нуруутай</li> <li>■ Хариуцлагатай</li> <li>■ Манлайлагч</li> <li>■ Зарчимч</li> <li>■ Үлгэр дуурайлалтай</li> <li>■ Алсын хараатай</li> <li>■ Зорилготой, санаачилгатай</li> <li>■ Хөдөлмөрч, бага наснаасаа хөдөлмөрлөсөн</li> <li>■ Эд хөрөнгийн шуналгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Шийдэмгий: түс тас харилцаатай</li> <li>■ Шийдвэр гаргадаг төрлийн хүмүүс тул</li> <li>■ Ноён нуруутай, алсын хараатай холыг хардаг</li> <li>■ Зоригтой</li> <li>■ Тууштай явдаг</li> <li>■ Гүрийдэг</li> <li>■ Хэлье гэснээ хэлдэг</li> <li>■ Удирдах чадвараар илүү</li> <li>■ Асуудлыг томоор хардаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Шийдэмгий</li> <li>■ Шударга</li> <li>■ Дайчин</li> <li>■ Зоригтой, гал цогтой</li> <li>■ Тууштай: гуйвж дайвадгүй, бууж өгдөггүй,</li> <li>■ Зарчимч</li> <li>■ Ажил хэрэгч</li> <li>■ Амьдралд ойр, амьдрал үзсэн</li> <li>■ Ил тод нээлттэй</li> <li>■ Хөдөлмөрч</li> <li>■ Бага ууж иднэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Шийдэмгий,</li> <li>■ Асуудлыг шийдэхдээ нягт нямбай</li> <li>■ Хүний нөлөөнд ордоггүй</li> <li>■ Шударга</li> <li>■ Нухацтай</li> <li>■ Хүнлэг</li> <li>■ Хөрвөх чадвартай</li> <li>■ Мэдрэмжтэй</li> <li>■ Тууштай</li> <li>■ Хөдөлмөрч</li> <li>■ Бодож хийдэг</li> <li>■ Хүлээцтэй</li> <li>■ Бусдыг ойлгодог</li> <li>■ Асуудлыг нарийвчлан хардаг</li> <li>■ Арай бага иднэ</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>■ Үнэн, зөв, гоё зүйл ярьдаг, зөв шүүмжилдэг</li> <li>■ Эх оронч, улс орон, ард түмний төлөө</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эрчүүд сэтгэн бодох чадвар илүү</li> <li>■ Хурдан шуурхай шийдвэр гаргадаг.</li> <li>■ Өөрийгөө илэрхийлж чаддаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Үнэн, зөв, шударга ярьдаг, шүүмжилдэг, үгээ зоригтой хэлдэг, ойлгомжтой ярьдаг</li> <li>■ Эх оронч, идэвх санаачилгатай, зүтгэлтэй, иргэдийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө зүтгэдэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Асуудлын цаана гарч тууштай явдаг</li> <li>■ Иргэдтэй ойр харилцдаг</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>■ Хийж бүтээсэн зүйлтэй, салбартаа сайн ажилласан, аймаг, орон нутаг, дүүрэгтээ хийсэн, бүтээсэн ажилтай, залуучууд руу анхаарсан хийсэн бүтээсэн ажилтай, амлалтдаа хүрдэг</li> <li>■ Боловсролын асуудлыг шийдэхээр дорвитой ажиллаж байгаа</li> <li>■ Сайн хуульч, сайн хууль боловсруулдаг</li> <li>■ Сайн ерөнхийлөгч байсан, төрийн тэргүүн, ерөнхий сайд байсан</li> <li>■ Ардчиллыг Монгол Улсад авчирсан</li> <li>■ Авлигатай тэмцсэн</li> <li>■ Спортыг дэмжсэн</li> <li>■ Туршлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Эрэгтэй хүн бүх салбарт манлайлах чадвар өндөр</li> <li>■ Улс орон, засаг төр, орон нутаг, цэрэг армийг удирдаж байна</li> <li>■ Логик дүгнэлт, гарц гаргалгаа олж хардаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Хийж бүтээсэн зүйлтэй, сайн ажилласан, амлалтаа биелүүлдэг, сайд байхдаа ихийг хийсэн, сайн ажилласан, дарга, удирдагчийн албыг хаших чадвараа харуулсан, Ковид-19 цар тахлаар сайн ажилласан, буянтай, гавьяатай</li> <li>■ Эмэгтэйчүүд, эх хүүхдийн асуудалд анхаардаг, шийдэхэд хувь нэмэр оруулсан</li> <li>■ Ерөнхийлөгчид нэр дэвшсэн, сайд байсан</li> <li>■ Хүний эрхийн төлөө тэмцэгч</li> <li>■ Туршлагатай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Олон ажлыг зэрэг амжуулдаг</li> <li>■ Зарим салбарыг сайн удирдаж байна</li> <li>■ Нийгмийн салбарыг удирдаж байна</li> <li>■ Эмэгтэйчүүд олон талаас нь бодож хийдэг</li> <li>■ Үлгэрлэн дагуулахдаа сайн</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>■ Мэдлэгтэй, чадвартай</li> <li>■ Удирдагч</li> <li>■ Сайхан харилцдаг, харилцааны соёлтой, ялгаварладаггүй</li> <li>■ Уран илтгэдэг</li> <li>■ Хараат бус, өөрийн гэсэн бодолтой</li> <li>■ Хөрөнгө чинээтэй, бизнесийн ухаантай</li> <li>■ Асуудлыг зөв талаас нь хардаг, бодлогыг оновчтой тодорхойлох чадвартай, системээр нь хардаг</li> <li>■ Өөрчлөлтийг хийх чадвартай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Өрхийн тэргүүн гэдэг утгаараа манлайлагч</li> <li>■ Төрөлхийн манлайлах чадвартай</li> <li>■ Монголчуудын эр хүнийг дээдлэх ёс уламжлалаар манлайлагч</li> <li>■ Нийгэмд эрчүүд илүү хүлээн зөвшөөрөгддөг</li> <li>■ Эрэгтэйчүүд удирдах чадвартай</li> <li>■ Эр зориг, тууштай байдал, өөрийгөө илэрхийлэх нь илүү</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Мэдлэг боловсрол, чадвартай</li> <li>■ Удирдах чадвартай</li> <li>■ Өөрчлөлтийг хийх чадвартай</li> <li>■ Асуудлыг зөв талаас нь хардаг, бодлого тодорхойлох чадвартай, системээр нь хардаг</li> <li>■ Биеэ даасан хэнээс ч хараат биш</li> <li>■ Бусадтай сайн ойлголцож чаддаг, харилцааны соёлтой</li> <li>■ Бизнесийн ухаантай</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Боловсролтой</li> <li>■ Эмэгтэйчүүд өндөр боловсролтой тул зарим салбарыг удирдаж байна</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>■ Намын хүн тул, намынхаа манлайлагч</li> <li>■ Залуу гишүүн, шинэ хүн</li> <li>■ Жинхэнэ Монгол</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>■ Дэмждэг намын гишүүн</li> <li>■ Ардчилсан үзэлтэй</li> </ul>	
<ul style="list-style-type: none"> <li>■ Хатуу удирдагч байж чадна</li> <li>■ Бүх тоглолтын ард байдаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Ажил хэрэгч, зарчимч имиж бүрдүүлдэг</li> <li>■ Биеэ зөв авч явдаг</li> <li>■ Албаны хувцасладаг</li> <li>■ Монгол эр хүн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Биеэ зөв авч явдаг, чадалтай</li> <li>■ Гоо сайхны мэдрэмжтэй, үлгэр жишээч</li> <li>■ Ярианы өнгө нь уярмаар, зарчимч, хүлээцтэй.</li> <li>■ Улс төрчийн дүр төрхтэй</li> <li>■ Даруу, хэл амд ордоггүй, төлөв төвшин</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>■ Ажил хэрэгч имиж бүрдүүлдэг</li> <li>■ Биеэ зөв авч явдаг</li> <li>■ Үс засалт, гадаад байдалдаа анхаардаг,</li> <li>■ Даруу төлөв</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>■ Арай дээр</li> <li>■ Таньдаг нь, нэр нь их дуулддаг</li> </ul>		<ul style="list-style-type: none"> <li>■ Манай тойргоос сонгогдсон, таньдаг нь,</li> <li>■ Телевизээр гардаг, нэвтрүүлэг хөтөлдөг, сэтгүүлч</li> </ul>	



Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэн  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 6 хороо  
Утас: (+976) - 99884067  
(+976) - 99092624